

**ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 07 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-57</i>
<hr/>	
<i>1. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан холбогдох хуулийн байгууллагуудаас мэдээлэл сонсох</i>	<i>4-57</i>

**Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны
2024 оны 07 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, П.Сайнзориг, Ц.Сандаг-Очир.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Ж.Баясгалан, Л.Мөнхбаясгалан, С.Цэнгүүн, Ө.Шижир, Д.Энхтуяа нар хуралдаанд оролцов.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан саналыг тусгаад хэлэлцэх асуудлыг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 0
Бүгд: 7
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хэлэлцэх асуудлаас хувь хүний нууц, төрийн болон албаны нууцтай холбоотой хэсгийг хаалттай горимоор хэлэлцэх горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нар үг хэлэв.

Х.Тэмүүжин: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 1
Бүгд: 7
85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан холбогдох хуулийн байгууллагуудаас мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамьянхүү, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч Т.Сүхболд, мөн газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга Б.Батдэлгэр, Захиргаа удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын Тасгийн дарга Б.Болдбаяр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Б.Нандинболор, мөн газрын Тэргүүн дэд дарга А.Намсанманд, Хуулийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу,

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Ч.Жаргалбаатар, мөн хэлтсийн ахлах мөрдөгч Д.Батбаатар, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Комиссын гишүүн Я.Цэлмэн, Гомдол хяналт, шалгалтын хэлтсийн дарга Г.Ууганбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээллийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нар хийв.

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээлэлд хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл яригдах тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын санал гаргав.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 2
Бүгд: 7
71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв./11:11/

Нээлттэй хуралдаан 12 цаг 38 минутад үргэлжлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Х.Баасанжаргал, Ж.Баярмаа, Л.Мөнхбаясгалан, Ө.Шижир, С.Эрдэнэболд, Ж.Баясгалан, М.Нарантуяа-Нара, Г.Уянгахишиг нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын гишүүн Я.Цэлмэн, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга Б.Нандинболор, мөн газрын Тэргүүн дэд дарга А.Намсанманд, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Ч.Жаргалбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, С.Цэнгүүн, Л.Мөнхбаясгалан, Ө.Шижир, Ж.Баярмаа, М.Нарантуяа-Нара нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан холбогдох хуулийн байгууллагуудын мэдээллийг сонслоо.

Уг асуудлыг 14 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 3 цаг 18 минут үргэлжилж, 10 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 70.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 07 дугаар сарын 30-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,
10 цаг 10 минут

**ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Х.Тэмүүжин: Номинчимэг гишүүн ирсэн байна. Тэмүүжин ирсэн. Уянгахушиг ирсэн байна. Цогтбаатар гишүүн ирсэн байна. Эрдэнэболд гишүүн ирсэн байна. Ингээд 7 гишүүний ирцээр хурал эхэлж байна. Энэ зүгээр явж байгаа юу. Тасалдаад байна уу. Энэ техник жоохон асуудалтай байх шиг байна. Техникийнхээ асуудлыг шийдээдэлье. За хуралдаанаа үргэлжлүүлэе. Хуралдаан даргалагч Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин Хүний эрхийн дэд хорооны өнөөдрийн хуралдааныг удирдана.

Хүний эрхийн дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хүний эрхийн дэд хорооны 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Дахиад танилцуулчихъя. Микрофон дээр. Дэд хорооны хуралдааны ирцийг түрүүн танилцуулсан. Баасанжаргал, Нарантуяа-Нара, Номинчимэг, Тэмүүжин, Уянгахушиг, Цогтбаатар, Эрдэнэболд гэсэн 7 гишүүний ирц бүрдсэн тул хуралдааныг эхлүүлж байна.

Хүний эрхийн дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Тэгээд гишүүдийн зүгээс цагдан хорих төвд хоригдож, таслан сэргийлэх

арга хэмжээ авагдан хоригдож байсан иргэний бие муудаж 3 дугаар эмнэлэгт хүргэгдсэнээр нас барсан асуудал хөндөгдсөн. Тухайн иргэнтэй холбоотой ямар асуудлууд хөндөгдсөн бэ гэхээр эрүү шүүлтэд өртсөн гээд Авлигатай тэмцэх газарт гомдол гаргасан байна. Гомдол гаргасныхаа дараа бол цагдан хоригдсон. Цагдан хоригдсон иргэн нас барсантай холбоотойгоор ар гэр бүл нь бол мэдэгдэл хийсэн. Тэр мэдэгдлийн хүрээнд цагдан хоригдож байхдаа бол цагдан хоригдохоос өмнө болон цагдан хоригдож байхдаа бол эрүү шүүлтэд өртсөн байж болзошгүй байгаа. Энэ эрүү шүүлтийн улмаас бол бие нь муудаж нас барсан гэж бид бол үзэж байна гэдэг байдлаар бол мэдээлэл өгсөн байгаа. Үүнтэй холбоотойгоор бол иргэдийн дунд бас тодорхой хэмжээний бухимдал үүсэж байна. Нийгмийн зүгээс энэ асуудлыг Улсын Их Хурлын түүвшинд шалгах ёстой, асуудалтай холбогдуулаад мэдээлэл авах ёстой, шаардлагатай бол зарим нэгэн шийдвэр гаргах ёстой гэдэг ийм байр суурь руу гадуур нэлээн яригдсан. Үүнтэй холбоотой байх. Манай гишүүд ч гэсэн бас яг энэ чиглэлээр бас Хүний эрхийн дэд хороог хуралдуулах шаардлагатай байна. Зарим байгууллагуудаас мэдээлэл авах шаардлагатай байна гэдэг санал гарсан. Үүнтэй холбоотойгоор бол өнөөдрийн дэд хорооны хурлыг хийж байна.

Дэд хорооны хурлаар үндсэндээ бол 8 асуудлыг бид мэдээлэл авна гэдэг байр суурьтай байна. Саяын асуудлын хүрээнд. Саяын асуудлын хүрээнд ямар 8 асуудал байна вэ гэхээр 1 дүгээрт эрүү шүүлтэд өртсөн гэж Авлигатай тэмцэх газарт гомдол гаргасан иргэн цагдан хоригдсон байна. Ингэж цагдан хоригдож байхдаа бие нь муудаж 3 дугаар эмнэлэгт хүргэгдэн нас барсан асуудлаар мэдээлэл авах шаардлага байна.

2 дугаарт нь цагдаагийн байгууллагад хэрэгт шалгагдаж байгаа болон хүсэлт гомдол гарган тус

байгууллагаас үйлчилгээ авч байгаа, эсхүл тус байгууллагын чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагаанд өртөж байгаа иргэдээс хохирдог, цагдаагийн алба хаагчид хувийн харилцаанд орохыг шаарддаг хүчлэх тохиолдол цөөнгүй гарсан гэдэг мэдээллүүд байна. Тухайлбал Сэлэнгэ аймагт гарсан үйл явдал байна. Яг үүнтэй төстэй бас хэд хэдэн тохиолдол гарсан гэх тийм мэдээллүүд байна. Тэгэхээр энэ мэдээллүүд үнэн, худал, энэ мэдээлэлтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний комисс дээр мэдээлэл байгаа эсэх, цагдаагийн байгууллага бол Хууль зүйн яаман дээр энэ тухай асуудал хөндөгдсөн эсэх гээд мэдээллийг авах шаардлага байна. Саяын ганц асуудал биш энэ нь өөрөө ер нь бол хууль сахиулах болон гэмт хэрэгтэй тэмцэх үйл явцын хүрээнд иргэд хохироод байна гэдэг ийм гомдол санал гараад байгаа учраас.

2-т нь Авлигатай тэмцэх газарт гомдол гаргасан. Гэтэл гэрч, хохирогч өөрөө хамгаалагдаагүй байна гэдэг бас асуудал хөндөгдөөд байна. Тийм учраас гэрч хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа ер нь хэрхэн явагдаж байна вэ. Саяын тохиолдол болон бусад асуудалтай холбоотойгоор энэ талаар мэдээлэл авах шаардлага байна.

4-д нь Хүний эрхийн Үндэсний Комиссын нэг бус илтгэлд эрүү шүүлтийн асуудал бол хөндөгдсөн. Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж, дүгнэлт, зөвлөмж бол гарч байсан. Үүний дагуу эрүү шүүлтийг зогсох талаар авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээнүүд хийгдсэн эсэх, тодорхой баримтууд дурдагдсантай холбоотойгоор тэр баримт үйл явдалд өртөгдсөн албан хаагчдад хариуцлага тооцсон эсэх асуудлаар бас мэдээлэл авах шаардлага байна.

5-д нь цагдаагийн байгууллагаас мэдээлэл хийхдээ иргэнийг буруутгах, муутгах, харлуулах, хувийн мэдээллийг зарлуулах, зарим талаар гүтгэх явдал гарч байна гэдэг гомдол санал нэг бус

удаа гарлаа. Саяын үйл явдал дээр бас гарсан. Өмнө нь бас 1, 2 тохиолдол бас гарч байсан. Тэгэхээр энэ зохицуулалт энэ мэдээллийг өгч байгаа хүрээ гэх мэтчилэн асуудлаар бас тодорхой мэдээлэл авах шаардлага байна гэж үзсэн.

6-д нь саяын үйл явдал бас цагдан хорих байрнаас эрүүл мэнд нь муудаж 3 дугаар эмнэлэг рүү явсан. Ар гэрийнх нь мэдээлэл бас цагдан хорих байранд эрүү шүүлт, дарамт шахалт байдаг мэт мэдээлэл бас өгсөн. Тийм учраас цагдан хорих байранд эрүү шүүлт хийгдэж байгаа эсэх, өмнөх Засгийн газрын үед энэ сонгуулиар Зоригийн хэрэгтэй холбоотой цагдан хорих төвд гүйцэтгэх ажлын нэрийн дор эрүү шүүлт тулгарсантай холбоотой нэлээн их хэл ам дагуулсан, гарсан. Энэ дагуу арга, ажиллагаа явсан юм уу, үгүй юм уу. Энэ үйл явц чинь дахиад цагдан хорих төвд үргэлжлээд байгаа юм биш биз гэдэг ийм одоо сэжиг гэдэг юм уу, таамаг гэдэг юм уу, эс үгүй бол хардалт бол байна. Тэгээд энэ тухай бас мэдээлэл авах шаардлага байна.

7. Гүйцэтгэх ажил эрүүгийн төлөөлөгчидтэй холбоотойгоор энэ эрүү шүүлттэй холбоотой гомдол санал бол цөөнгүй гараад байна. Энэ тохиолдолд ч гэсэн бас мөн адил байна. Тэгэхээр энэ гүйцэтгэх ажилтай холбоотой хууль тогтоомж боловсронгуй байгаа юм уу, үгүй юм уу. Цаашид сайжруулах шаардлага байна уу, үгүй юу. Энэ мөрдөн байцаалтын би санаж байна. 2013 онд шиг санаж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссоос илтгэлд дурдагдаад энэ мөрдөн байцаалтын өрөө тасалгаанд эрүү шүүлт болоод байна. Айлган сүрдүүлэлт болоод байна. Зодож, нүдэх асуудал гараад байна гээд мөрдөн байцаалт хийх өрөө тасалгааны стандарт гарсан шиг санаж байна. Тэр стандартын дагуу тоногдсон байх шаардлага тавьсан. Тэнд камерын дуу, дүрсийн бичлэг байх ёстой гэх мэтчилэн. Тэгээд саяын үйл явдал одоо тэр

өрөөндөө болсон юм уу, өрөөнөөс гадна болсон юм уу. Ер нь бол нөгөө энэ өрөөний стандарт баригдаж явж байгаа юу, үгүй юу гэдэг талаар бас мэдээлэл авах шаардлага байна.

Төгсгөлд нь 8-д нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг буюу үйлдэгдэж байгаа энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах үйл явц ер нь ямар байгаа юм бэ. Цагдаа, тагнуул, АТГ гэх мэтчилэн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагууд хууль сахиулах үйл ажиллагаа явуулж байгаа болон мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байхдаа иргэдтэй холбоотой эрүү шүүлт гаргах, нотлох баримтыг устгах, гэрч, хохирогчид нөлөөлөх гэх мэтчилэн ийм зөрчлүүд, гэмт хэргүүд гараад байна гэдэг үг, өгүүлэл гадуур нэлээн их байна. Энэ талаарх гомдол санал, энэ талаарх гэмт хэргийг мөрдөн шалгах үйл явц ер нь бол ямар хэлбэр дүрстэй, зохион байгуулалттай явж байгаа юм бэ гэдэг асуудлыг ярьж гээд ийм 8 асуудлаар мэдээлэл авъя гэдэг байна.

Байнгын хороо хорооны хуралд оролцож байгаа гишүүдээс авах гэж байгаа мэдээллийн 8 асуудалтай холбоотой бас гадуур ингээд дутуу орхигдсон байна. Бас ийм мэдээлэл авах хэрэгцээ шаардлага байна гэдэг саналтай гишүүн байна уу. Нарантуяа гишүүн байна. Өөр. Баасанжаргал гишүүн байна. 2 гишүүнээр тасаллаа. Нарантуяа гишүүн.

М.Нарантуяа-Нара: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг. Бүгдээрээ сайхан наадсан уу. Энэ 21 настай залуугийн хоригдож байгаад амь насаа алдсан энэ байдал бол ингэж бичсэн байгаа байхгүй юу. Одоо бол бид нар яг ямар хэргийн үндсэн дээрээс энэ хүн 3 сарын туршид буюу 90 хоног баривчлагдав. 1 дүгээрт энэ хэрэг нь байх ёстой байх. Би бол нарийн мэдээллийг мэдэхгүй байна. Ер нь бол сошиал дээр явж байгаа мэдээллээс бол гар утасны хулгайн хэрэгт

сэжиглэгдэж байгаад хоригдсон гэдэг тийм мэдээллүүд яваад байгаа.

Тэгэхээр миний яг гол хүсэж байгаа юм бол Эрүүгийн хуулийн яг ямар зүйл, заалт зөрчсөний улмаас энэ хүн баривчлагдаж, 461-д хоригдоод бүр 3-ын 3 сар хоригдсон байна шүү дээ. Би бол сошиалаас авсан мэдээллээр 1 сар гаруй, дахиад 1 сар ингэж юу яасан гэж бодож байсан. Тэгээд энд бол бүр бүхэл бүтэн 90 хоног байсан байна. Тэгээд энэ хүн чинь нөгөө шоронгоос гарчхаад биш, шоронд байхдаа өвдөж нас барсан юм байна шүү дээ. Тэгэхээр энэ сошиал дээрх олны мэдээлэл, энэ 2 зөрүүтэй байна гэж би хувьдаа харж байна. Тийм учраас энэ хүн яг Эрүүгийн хуулийн ямар зүйл, заалтыг зөрчсөний улмаас гэрч юм уу, хохирогч юм уу, хэрэгтэн юм уу гэдэг юм нь байхгүй байгаа байхгүй юу. Бид нар болохоор бас гэрч хохирогчийн тухай бас асуудлыг ярьж байна. Гэтэл энэ хүн гэмт хэрэгтэн гээд баригдсан байж таарах байх гэж би хувьдаа бодож байна. Тэгэхээр Эрүүгийн хуулийн ямар зүйл заалтыг зөрчсөн тийм гэмт хэргийн улмаас баривчлагдаж, хоригдон саатагдсан юм бол гэдэг асуулгыг тавимаар байна. Тэгээд ер нь бол бид нар ингээд асуултуудыг юу яахаас гадна олон талын мэдээлэл авах хүсэлтэй байна. Жишээлбэл ар гэрийнхэн тань энэ нийт 90 хоногийн хугацаанд бол 4 удаа л эргэлт, гэр бүлийн эргэлт авсан юм байна шүү дээ. Тэгэхээр тэр эргэлтийн хугацаанд хүүхэд нь яг ямар байдалтай байсан юм. Ар гэрийнхэнтэй нь бас уулзаж тодорхой мэдээлэл, бодит үнэн мэдээллийг зөвхөн хууль хяналтын байгууллагаас биш олон талын мэдээллийг бас авах нь зүйтэй болов уу гэж би хувьдаа бодож байна.

Х.Тэмүүжин: Эхнийх нь болохоор нөгөө бид хэдийн сая 8 асуудал гэж дурдсаны эхний 1 дүгээр асуудал дээр угаасаа хөндөгдөх байх. Хэргийн дотоод үйл явдал болон шалгах үйл ажиллагаа руу нь бол бид нар оролцохгүй. Улсын Их Хурлын хууль тогтоох болон хяналтын

чиг үүргийнхээ хүрээнд бид нар мэдээлэл авна. Би бас нэг зүйлийг дутуу хэлсэн байх шиг байна. Энэ бол зөвхөн эхний хурал. Би бол энэ хурлаар асуудал дуусна гэж бодохгүй байна. Эхлээд бид нар жоохон ойлголттой болох ёстой. Тодорхой мэдээллийг эрх бүхий байгууллагуудаас авах ёстой. Тэгээд мэдээлэл дутуу байна. Ажиллагаа гүйцэт хийх ёстой гэх мэтчилэн асуудал байх юм бол Хүний эрхийн Үндэсний Комисс болон байгууллагууддаа чиглэл өгөөд, тэгээд 14 хоногийн дараа ву, хэд байх вэ хугацааг нь хараад, тэгээд дараагийнхаа хурал дээр бүрэн дүүрэн мэдээлэлтэйгээр асуудлаа шийдвэр гаргах хэмжээний хурлаа хийнэ гэдэг байдлаар ажиллаж гэсэн тийм зорилготой байна.

2-т нь яг тэр 2 дахь хурал дээрээ шаардлагатай гэвэл хохирогчийн төлөөлөл гэр бүлээс нь бас оролцуулж болно. Өнөөдрийнхөө хурлаар зөвхөн энэ асуудал биш нийтлэг нэлээн том асуудлууд бас байгаа учраас илүү өргөн бүрэлдэхүүнтэйгээр асуудал хөндөж болно. Магадгүй хүний эрхийн дэд хороо дээр сонсгол зохион байгуулах тухай бас ярьж болно. Цаашаа бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн хүрээнд байгаа учраас ямар л бол ямар хэлбэрээр энэ асуудлыг хөндөж ярьж болно.

Одоо Баасанжаргал.

Х.Баасанжаргал: Саяын хэлэлцэх мэдээлэл авах 8 асуудлын хүрээ гэж ойлголоо. Энэ дээр нэмээд 3, 4 асуудал нэмэх саналтай байна. Тэгэхдээ бас багтсан байж магадгүй.

1 дүгээрт энэ цагдаагийн байгууллагын чиг үүрэг, ажлын ачаалал, энэ мөрдөн шалгах хэв журам гэдэг энэ 2 том чиг үүрэг нэг энэ байгууллагын хүрээнд байгаа нь өөрөө хамгийн сүүлийн ийм үр дагаварт хүргэж байгаа юм биш байгаа даа. Цагдаагийн байгууллагын цагдаагийн алба хаагчдын нийгмийн асуудлыг бас энэ хүрээнд оруулж ирээч. Ажлын ачааллынх нь зураглал, ажлын

ачаалалтай холбоотой хийгдсэн судалгаа байдаг юм болов уу гэсэн ийм зүйл байна. Энийг оруулж ирэх хүсэлтэй байна.

2 дугаарт түрүүн Нарантуяа-Нара гишүүн хэлсэн. Цагдан хорих үндэслэлийг ингээд харахаар яг энэ Хүний эрхийн Үндэсний Комисс дээр өгсөн мэдээлэл дээр бол байхгүй байна. Гэхдээ Авлигатай тэмцэх газарт эрүүдэн шүүлттэй холбоотой гомдол өгснийхөө дараа цагдан хоригдсон байна гэж зүгээр он сарыг нь харах юм бол тэгж харагдаад байна. Тэгэхээр зайлиггүй ингэж цагдан хорих үндэслэл байсан эсэх мэдээж яг энэ хохирогч дээр. Түүнээс гадна яг энэ шүүхийн зөвшөөрөлгүйгээр сэжигтнийг баривчлах, цагдан хорих асуудал мар түвшинд байгаа юм бэ. Хамгийн сүүлд миний мэдэж байгаагаар, санаж байгаагаар 2023 онд НҮБ-аас хийсэн шинжээчийн дүгнэлтээр бол 90 гаруй хувь нь анх баривчлагдахдаа шүүхийн шийдвэргүйгээр цагдан хоригдсон байна гэдэг ийм мэдээллийг өгсөн байдаг. Тэгээд үүний мөрөөр авсан арга хэмжээний талаарх мэдээлэл, үүнийг дагаад бас эрүүгийн процессын хуульд өөрчлөлт уг нь бол орсон гэж ойлгож байгаа. Тэгэхээр тэр өөрөө үр дүн өгч байна уу, өгөхгүй байна уу, ямар асуудал үүсэж байна вэ. Яг бодит одоо үр дүнтэй алхам авч хэрэгжүүлж чадсан уу, үгүй юү гэдгийг эргэж харах хэрэгтэй байх.

3 дугаарт цагдаа, прокурорын ажлын үзүүлэлтийг үнэлэхдээ сард хэчнээн гэмт хэргийг илрүүлж ялагдагчаар татагдсан гэдэг ийм байдлаар ажлын үзүүлэлтийг нь үнэлдэг гэж ойлгоод байгаа. Дээрээс нь ялаад, шүүх рүү шилжүүлсэн тохиолдолд цагаатчих юм бол ажлаа муу хийсэн гээд эргээд ажлын үзүүлэлт дээр нь сөрөг оноо очдог гэдэг ийм мэдээлэл байдаг. Тэгэхээр яг энэ цагдаа, прокурорын ажлын үзүүлэлтийг үнэлдэг үнэлгээ өөрөө хүний эрхийн зөрчлийг бий болгох гол бас учир шалтгааны нэг биш байгаа даа гэдэг ийм бас хардлага байна. Тийм

учраас яг энэ ажлын ачаалал, ажлын үзүүлэлттэй холбоотой мэдээллийг 3 дугаарт нь авмаар байна.

4 дүгээрт өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхийн асуудлыг бид нар энэ удаа зайлиггүй хөндөх ёстой байх. Тэр ар гэрээс нь гадна өмгөөлөгчийг нь оролцуулж мэдээлэл авах хэрэгтэй байх. Ялангуяа эрт үеийн өмгөөллийн асуудал аягүй чухал байгаа манайд. Энэ ерөөсөө хангагдахгүй яваад байгаа ийм хүний эрхийн ноцтой зөрчил байгаа. Тэгэхээр яг энэ талийгаачийн хувьд болоод, өөр бусад одоо яг цагдан хорих байранд баривчлагдчихсан байгаа сэжигтэн, яллагдагчдын дунд өмгөөлөгчийг эрт үеийн өмгөөлөгч эрт үеийн өмгөөллийн эрхээрээ хангагдах эрхийн нөхцөл байдал ямар байгаа бол.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Нэг асуулт нь бол урд талын хэсэгт орчих юм байна. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилгаа, мөрдөгч, прокурорын ажлын үзүүлэлттэй холбоотой хэсэг. Өмгөөлөгч, өмгөөлүүлэх хэрэгтэй холбоотой хэсэг гээд нийтдээ ингээд нэмэх юм бол 11 асуудал болох юм байна. Ямар ч байсан энэ 11 асуудлаар хэлэлцэх асуудлаа баталчих уу. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан хуулийн байгууллагуудаас мэдээлэл сонсох гэсэн асуудлын хүрээнд энэ 11 асуудлаар мэдээлэл авъя гэдгээ баталчих уу хэдүүлээ. Санал хураалт явъя. Хурууны хээ таарахгүй байна гэж байгаа юм. Техник ажиллаж байна уу. Гараа өргөчих үү. Харин тийм. Яах вэ бид 3 гурвууланг нь ийшийгээ тооцоод 7-уулаа санал өгсөн гээд явчих уу. Энэ техникийн алдаа гараад байна. Хэлэлцэх асуудал 100 хувиар баталлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8.3, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.3-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэх болно. Мөн Монгол Улсын Их Хурлын тухай

хуулийн 21.3-д хэлэлцэх асуудлын шинж байдлыг харгалзан хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно гэж заасны дагуу хэлэлцэж байгаа асуудал нь хүний эмзэг мэдээлэл агуулсан асуудал байгаа тул хуралдааныг хаалттай явуулах горимын санал гаргаж байна гэж би гаргах ёстой юм уу. Алтангэрэлд микрофон өгчихье. Алтангэрэл сайдын микрофоныг нээчих

О.Алтангэрэл: Дахин өглөөний мэнд хүргэе. Тэгээд саяын асуултуудад хариулахаар гарцаа байхгүй энэ хохирогчийн эмзэг мэдээлэл бас нэлээн нарийн дурдагдах гээд байна л даа. Тэгэхээр та бүхнийг бас энэ хаалттай горимыг дэмжиж өгөөч ээ. Тэгээд бас өнөөдөр энэ мэдээллийн үеэр яригдах асуудлыг цаашаагаа бас тэр эмзэг мэдээлэлтэй холбоотой хэсгийг нь олон нийтэд задруулахгүй байх талаас анхаарч өгнө үү гэсэн ийм хүсэлт байна.

Х.Тэмүүжин: Эхлээд хаалттай, нээлттэйгээ шийдчихээд дуудсан байгууллагуудынхаа мэдээллийг өгөөд явах юм байна. Энэ асуудал дээр гишүүдийн байр суурь байвал. Эрдэнэболд.

С.Эрдэнэболд: Тэр нөгөө яг амь хохирогчийн хувийн мэдээлэлтэй холбоотой хэсгүүдийг хаалттайгаар яваад, бусад ерөнхий процессын алдаа мадагтай холбоотой юмнуудыг нь нээлттэй гээд 2 хуваах нь зөв байх. Тэгэхгүй болохоор олон нийтэд чинь ийм баахан хардалт яваад байдаг. Тэгэхээр энэ дээр тодорхой хэмжээнд Улсын Их Хурал тэр дотроо Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо бас ямар процесс явж байгааг иргэдэд мэдээлэл өгөх нь зөв байх. Тэгэхээр яг нөгөө асуудлаа ангилаад, яг хохирогчийн хувийн эмзэг мэдээлэлтэй холбоотой эсэхийг нь хаалттай горим гээд явбал илүү зөв байх. Тэгэхгүй бүхэлд нь хаалттай болчихлоор бас баахан оньсого таавар болоод ингээд явчих болов уу гэж бодож байна.

Х.Тэмүүжин: Би ч гэсэн яг тийм байр суурьтай байна. Мэдээлэл өгч байгаа байгууллага энэ бол яг хувь хүний эмзэг мэдээлэл, энэ нь төрийн мөрдөн шалгах үйл ажиллагаа юм уу, эсвэл төрийн байгууллагын нууцтай холбоотой мэдээлэл хөндөгдөх гээд байна гэх юм бол хаалттай горимд гаргах саналаа гаргаад хаачихъя. Тэрнээс бусад үйл явдалтай холбоотой мэдээлэл бас нууцлаад хаагаад байх шаардлага байхгүй байх гэж бодож байна. Ийм байдлаараа бол яаж байна. Санал хураах уу. Зөвлөх өө, саяынх дээр санал хураах уу. 2 ялгаатай гээд.

Би албан ёсны горим гаргалаа. Тэгвэл яг хувь хүний хувийн эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудал болон төрийн байгууллагын төрийн нууцтай холбоотой асуудал хэрвээ үнэхээр хөндөгдвөл тэр асуудал дээр нь хаалттай хуралдаад, тэрнээс бусад асуудлаар нь бол нээлттэй хуралдъя гэдэг горим гаргаж байна. Энэ горимтой холбоотой санал хураалт эхэлье. Техник зүгээр явах уу. Санал хураалт. Зөвшөөрсөн 6, татгалзсан 1.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Холбогдох албан тушаалтнуудыг дуудсан. Ер нь бол хурал өөрөө анхны удаа явж байгаа. Манай чуулган эхлээд, Байнгын хороодод ажиллагаанд ороод, Хүний эрхийн дэд хороо бүрэн гүйцэт ажиллагаанд ороогүй байсан учраас хурал дуудах албан тушаалтнуудыг урьдчилсан байдлаар ажлын хэсэг дээрээ яваад явчихсан шүү. Та бүгдийнхээ саналыг бас гүйцэт авч чадаагүйдээ хүлцэл өчье.

О.Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Д.Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Я.Цэлмэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн комиссын гишүүн, Г.Нарантуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Л.Нямгэрэл Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга,

Г.Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Т.Сүхболд Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч, Б.Нандинболор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, А.Намсанманд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, Н.Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн дарга, Б.Батдэлгэр Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дэд дарга, Л.Нямдаваа Цагдаагийн ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын дарга, Э.Бадамсамбуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Ж.Жаргаланбаатар Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга, Б.Батбилэг Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга, Г.Ууганбаатар Хүний эрхийн Үндэсний Комиссын Гомдол, хяналт шалгалтын хэлтсийн дарга, Д.Батбаатар Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, Б.Болдбаатар Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын тасгийн дарга гэсэн ийм бүрэлдэхүүнийг дуудсан байна. Дуудсан хүмүүс бүгдээрээ ирсэн гэж байна.

Сая дуудагдсан хүмүүс орж ирээгүй байхад хэдүүлээ ямар хүрээнд мэдээлэл авах гэж байгаа гэдэг хүрээгээ танилцчихсан. Орж ирсэн хүмүүс бол мэдээгүй байгаа байх. Зарим нэг нь. Тийм учраас тэр хүрээгээ дахиад танилцуулаадахъя.

Өнөөдөр Хүний эрхийн дэд хорооны хуралдаан дээр гишүүд 11 төрлийн мэдээллийг сонсох, авах хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн.

1 дүгээрт. Эрүү шүүлтэд өртсөн гэж Авлигатай тэмцэх газарт гомдол гаргасан иргэн цагдан хоригдсон. Мөн цагдан хоригдож байхдаа бие нь муудаж 3 дугаар эмнэлэгт хүргэгдэн нас барсан. Энэ асуудлаар мэдээлэл авахыг хүсэж

байна. Ямар үйл явдал болсон юм. Яагаад цагдан хоригдсон юм. Авлигатай тэмцэх газарт эрүү шүүлтэд өртсөн гэдэг гомдол хэзээ гаргасан юм. Энэ гомдолтой холбоотойгоор ямар арга хэмжээ авсан юм гэх мэтчилэн гишүүд мэдээлэл авахыг хүсэж байна.

2-т нь цагдаагийн байгууллагад хэрэгт шалгагдаж байгаа болон хүсэлт, гомдол гарган тус байгууллагаас үйлчилгээ авч байгаа, эсвэл тус байгууллагын чиг үүрэгтэй нь холбоотой үйл ажиллагаанд өртөж байгаа иргэд хохирч байна. Цагдаагийн алба хаагчдаас хувийн харилцаанд орохыг шаарддаг, хүчлэх тохиолдол цөөнгүй гарсан. Тухайлбал сая бол эрүү шүүлтэд өртөж байна. Сэлэнгэд бас нэг үйл явдал болсон гэнэ. Мөн яг үүнтэй адил бас хэд хэдэн аймагт ийм зүйл болсон гэх мэдээлэл гадуур яваад байна. Энэ юу болсон юм. Үнэн юм уу, худлаа юм уу. Ямар асуудал байгаа юм. Цагдаагийн байгууллага, Хууль зүйн яам, Хүний эрхийн Үндэсний Комисс гэх мэтчилэн энэ байгууллагууд дээр мэдээлэл байгаа юу. Энэ мэдээллийн дагуу арга хэмжээ авсан уу. Ер нь ямар түвшинд байна гэдэг энэ мэдээллийг авахыг хүсэж байна.

3-д нь сая мөн энэ Авлигатай тэмцэх газарт эрүү шүүлтэд өртсөн гэдэг гомдол гаргасан. Нэг талаасаа гэрч, нөгөө талаасаа хохирогч байгаа. Гэрч, хохирогч хамгаалах үйл ажиллагаа ер нь хэрхэн явагдаж байна. Энэ талаар мэдээлэл авахыг хүсэж байна.

4-д нь Хүний эрхийн Үндэсний Комиссын нэг бус илтгэлд эрүү шүүлттэй холбоотой асуудал хөндөгдсөн. Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж, дүгнэлт, зөвлөмж гарсан. Үүний дагуу эрүү шүүлтийг зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байна уу, байхгүй юу. Ямар үр дүнд хүрч байна. Энэ тухай Хүний эрхийн Үндэсний Комисс болон цагдаагийн байгууллага, өөр бусад байгууллагуудтай, мөрдөн шалгах гэмт хэрэгтэй тэмцэх

байгууллагуудын мэдээллийг авах хэрэгцээ шаардлага байна. Энэ хүрээнд бас эрүү шүүлт тэнд чинь ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлт, тайланд нэртэйгээ устайгаа, эрүү шүүлттэй холбоотой баримтууд байгаад байна. Тэр албан хаагчдад арга хэмжээ авсан юм байдаг юм уу, байдаггүй юм уу. Өчигдөрхөн хүртэл сошиал дээр нэг дүрс бичлэг яваад байна лээ гэх мэтчилэн. Тэгээд олон нийтийн зүгээс бол ямар асуулт тавьж байна вэ гэхээр энэ хүмүүст ер нь хариуцлага тооцдог уу. Тооцсон бол тооцсон тухайгаа мэдээлэл өгөөч. Тооцоогүй бол тооцоогүй тухайгаа мэдээлэл өгөөч гэдэг. Тэгэхээр бид бол дэд хороо дээрээ бас яг энэ чиглэлийн мэдээллийг бүрэн гүйцэд авмаар байна.

5 дахь нь цагдаагийн байгууллагаас мэдээлэл хийхдээ иргэнийг буруутгах, муутгах, харлуулах, хувийн мэдээллийг задруулах, зарим талаар гүтгэх явдал гарч байна гэх гомдол, санал хохирогчдын зүгээс байнга гарч байна. Үүнтэй холбоотой хууль тогтоомж ямар байгаа юм. Зааварчилгаанууд нь яаж явагддаг юм. Прокурорын зөвшөөрлөөр өгөгдсөн гэдэг хэмжээ дотор өгөгдсөн тайлбар цагдаагийн байгууллагаас хийж байх шиг байна лээ. Гэхдээ ганц цагдаагийн байгууллага биш шүү. Гэмт хэрэгтэй тэмцэх болон мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагууд энэ төрлийн мэдээллийг өгөхдөө хүний эрхийн мэдрэмж талаасаа ямар байгаа юм. Хууль мөрдөж байгаа талаасаа ямар байгаа юм. Дөнгөж саяхан, одоо удаагүй байна. Нэг сэтгүүлч иргэний хувийн эмзэг мэдээллийг тараасан гэдгээрээ ял авч байна. Төрийн байгууллага энэ төрлийн мэдээллийг тарааснаараа гэмт хэрэг ерөөсөө болохгүй байна. Эсхүл хууль зөрчсөн гэх үйлдэл ерөөсөө гарахгүй байна. Энэ ялгамжтай байдал чинь хуулийн аль хэсэг дээр байгаад байна гэх мэтчилэн энэ асуултад хариу авмаар байна. Мэдээлэл авмаар байна. Хүний эрхийн Үндэсний Комисс бас энэ

чиглэлээр судалсан, цуглуулсан мэдээлэл байна уу, үгүй юу.

6.Цагдан хорих байранд эрүү шүүлт хийгдэж байна гэх гомдол, санал саяын тохиолдол дээр ч гэсэн бас гарлаа. Энэ үнэн үү, худал уу. Өмнө нь бас цагдан хорих төв дээр эрүү шүүлт гарсан гээд бүр нөгөө 3 шатны шүүхээр явсан хэрэг хүртэл хэрэгсэхгүй болж байгаа. Тэгэхээр энэ цагдан хорих төвд эрүү шүүлт явагдаад байгаа юм уу, үгүй юм уу. Энэ өмнөх тохиолдлуудтай холбоотой арга хэмжээ авсан юм уу, үгүй юм уу. Саяын үйл явдал чинь үнэн юм уу, худлаа юм уу гэх мэтчилэн энэ мэдээллийг бас бүрэн гүйцэт авмаар байна.

7.Гүйцэтгэх ажил эрүүгийн төлөөлөгчтэй холбоотойгоор энэ эрүү шүүлттэй холбоотой асуудал гарч ирээд байна. Тэгэхээр энэ чиглэлийн хууль тогтоомжийн боловсронгуй байдал ямар түвшинд байгаа юм гэдэг талаарх мэдээлэл авмаар байна. Миний санаж байгаагаар 2013 онд байна уу. Мөрдөн байцаалтын өрөөний стандарт болон хяналтын зааварчлал чиглэл нэлээн сайн гарсан. Миний мэдэж байгаагаар Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаалт явуулж байгаа өрөө тасалгаа бол маш сайн байгаа. Цагдаагийн байгууллага ямар байгаа юм. Саяын үйл явдал энэ мөрдөн байцаалт явуулах өрөөнд гарсан юм уу, гадуур гарсан юм уу. Ер нь энэ стандартаа мөрдүүлж, хянаж чадаж байна уу, үгүй юу гэдэг асуудлыг бас мэдмээр байна.

8.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн мөрдөн шалгах үйл явц ер нь ямар байгаа юм бэ. Ямар тогтолцоогоор явж байна. Ямар үр дүн гарч байна. Энэ төрлийн гэмт хэрэг чинь гаралт болон мөрдөн шалгах үйл явц ямар байгаа гэдэг талаар бас мэдээлэл авмаар байна.

9.Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилгаа ер нь ямар түвшинд байна. НҮБ-ын шинжээч ирээд бас нэг том дүгнэлт хэлчхээд байдаг. Тэрний дагуу арга хэмжээ авагдсан уу. Хууль өөрчлөгдсөн гэж ойлгосон. Энэ хуулийн биелэлт, хэрэгжилт ямар түвшинд байна гэдэг талаар. Ер нь шүүхийн зөвшөөрөлгүй ганц баривчилгаа биш шүүхийн зөвшөөрөлгүй хийгдэж байгаа хүний эрх рүү халдаж байгаа нэлээн хэдэн ажиллагаа байгаа. Энэ ажиллагаатай холбоотой асуудлын хууль тогтоомжийг боловсронгуй болгох болон тэр чиглэлийн мэдээллийг бас авах шаардлага байна.

10.Мөрдөгч, прокурорын ажлын үзүүлэлт чинь зарим талаараа ийм алдаанд хүргээд байгаа юм биш биз. Ажлын үзүүлэлтийг нь шалгадаг шалгуур, үнэлдэг үнэлгээ, хариуцлага тооцдог механизмууд нь зарим талаараа энэ эрүү шүүлт болон хүчилж гэмт хэргийг илрүүлэх явц руу түлхээд байгаа юм биш биз гэдэг ийм бас болгоомж байна. Энэ төрлийн мэдээллийг бас авахыг хүсэж байна.

11-д нь ер нь бол саяын үйл явдал болон энэ төрлийн эрүү шүүлттэй холбоотой асуудал дээр өмгөөлөгч, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой учир дутагдалтай зохицуулалт байна уу. Үйл ажиллагаа байна уу. Ер нь бол прокурор, өмгөөлөгчийн шүүхийн өмнөх тэнцвэртэй байдал процессын хууль тогтоомжоор хангаж байна уу, үгүй юу гэдэг асуудлаар бас мэдээлэл авах хэрэгцээ байна.

Ийм 11 асуудлаар өөр өөрийн хамаарах чиг үүрэг, харьяалах ажлынхаа хүрээнд мэдээлэл өгнө. Эхлээд Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээллийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид танилцуулна. 5 дугаар микрофон ажиллах уу.

Д.Сүнжид: Хууль зүйн байнгын хорооны Хүний эрхийн дэд хорооны эрхэм гишүүд, энд цугласан ажлын хэсэг та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

11 асуултын хүрээнд тодруулга хүсэж байгаа юм байна. Хуралдаан даргалагчаас асуухад эхлээд 1 дүгээр асуултын хүрээнд тодруулгаа өгөөд, тэгээд бусад ажлын хэсгийн гишүүд хариулаад явах уу.

Х.Тэмүүжин: Эхлээд танилцуулгаа хийчих. Бид нар бол та хэд бол энэ 11 асуултыг бүгдээрээ анхлан сонсож байгаа байх. Тийм учраас энэ удаа өгч болох хэмжээ мэдэж байгаа хэмжээндээ тайлбаруудаа өгөөд, протоколоор юм уу бид нар эндээс бас чиглэл өгнө. 14 хоногийн дараа хугацаагаа хэдүүлээ тохироод, тэр хугацааны дараа дахиад хуралдана. Тэгж хуралдахдаа аль болох бүрэн дүүрэн мэдээллээ гүйцэт авахыг хичээнэ. Тэр хуралдааны дараа тодорхой шийдвэрүүд, тодорхой зөвлөмжүүд, чиглэлүүд тодорхой гарах байх. Энэ удаа бол одоо байгаа мэдээлэл дээрээ эхлээд ямар ч байсан мэдээллээ аваадахъя. Тэгээд ямар мэдээллүүд дутуу байна тэр мэдээллүүд дээрээ та хэдэд чиглэл өгөөд, тэгээд ажиллах боломж мэдээллээ бүрэн дүүрэн авчрах тэр хугацааг нь өгөөд, дараагийнхаа хуралдааныг бид нар хийнэ. Сүнжид.

Д.Сүнжид: Энэ 2024 оны 7 сарын 23-ны өдөр амь хохирсонтой холбогдуулаад 461 цагдан хорих төвд 21 настай иргэн цагдан хоригдож байх хугацаандаа эмнэлгийн тусламж шаардлагатай болоод амь хохирсонтой холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссоос бол ийм ажиллагаа хийсэн. Тухайн өдрийн орой 22-ны орой хүргэгдсэн байна. Ингээд энэ үед манай Энхболд гишүүн. Хүний эрхийн Үндэсний Комисс 6 гишүүнтэй ажилладаг. Тэгээд төрийн бүх байгууллагууд хүний эрхийг хангах, хамгаалах, эрхийг нь зөрчих, зөрчигдсөн эрхийг нь сэргээх ийм үүргийг бол тус тусдаа чиг үүргийнхээ дагуу

хуулиараа хүлээдэг. Хүний эрхийн Үндэсний Комиссоос энэ чиг үүргийнхээ хүрээнд төрийн байгууллагуудаас мэдээлэл авч эхэлсэн. Энэ дээр бол Энхболд гишүүн ахалдаг. Энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дээр хяналт тавьж ажилладаг ийм эрхийн хүрээнд хяналт тавьж ажилладаг ийм гишүүн байгаа.

Тэгээд цагдаагийн байгууллагаас дэд даргатай нь холбогдсон. Тэгээд энэ дээр 23-ны өдөр бид нарт бол албан ёсоор үүнтэй холбоотой цагдаагийн байгууллагаас мэдээллээ ирүүлсэн. Түүний дараагаар 3 дугаар эмнэлгийн эмч нартай очиж уулзсан. Тэгээд биеийн байдал, онош, эмчилгээ, үйлчилгээний талаар лавласан. 461 дүгээр ангид очиж бас ажиллалаа. Мөн энэ амь хохирогчийн хувийн хэрэгтэй танилцлаа. Тэнд хийгдсэн үзлэг, эмчилгээтэй танилцлаа. Камерын бичлэгийг нь үзлээ. Мөн ШШГБ-ын албан хаагчидтай уулзаж болсон үйл явдлын талаар ярилцлаа. БГД-ийн прокурорын газар, Авлигатай тэмцэх газарт хяналт тавьж ажиллаж байна. Өөрөөр хэлэх юм бол 1 сард гаргасан эрүүдэн шүүгдсэн гэх асуудал хянан шийдвэрлэх ажиллагаанд явж байгаа гэдэг мэдээллийг өгч байгаа. Тэгэхээр энэ талаар БГД-ийн прокуророос ямар шатдаа байгаа вэ гэдгийг тодруулах бас албан бичиг авсан. Ингээд үзэхээр 3 үйл явдал дээр бид нар байгууллагууд, төрийн байгууллагуудаас бид нар мэдээлэл авлаа. Төрийн байгууллагуудын ажил хариуцаж байгаа хүмүүстэй бид нар уулзаж тайлбарыг нь авлаа. Мөн холбогдох тэр бичиг баримт, хувийн хэрэг, холбогдох бусад баримтуудыг нь бид нар татаж аваад дүн шинжилгээ хийлээ. Ингээд үзэхээр 3 асуудлууд байгаа.

1 дүгээрт, тэр 1 дүгээр сард эрүү шүүлт тулгасан гээд цагдаагийн албан хаагчдад холбогдуулаад гаргасан гомдол байна. Энэ бол АТГ-аас чиг үүргийнхээ дагуу эрүүдэн шүүсэн эсэхийг хянан шийдвэрлэдэг, мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг чиг үүрэг бүхий байгууллага бол

Авлигатай тэмцэх газар. АТГ-аас энэ бол ажиллагаанд байна гэдэг мэдээлэл өгч байна. БГД-ийн прокуророос энэ дуусаагүй байна. Бид нар энэ нотлох ажиллагааг бүрэн дүүрэн, ач холбогдолтой тал бүрээс нь шалгана гэдэг мэдээллийг бид бид нарт ирүүлсэн. Одоогийн байдлаар яллагдагчаар татагдсан хүн байхгүй гэдэг ийм мэдээллийг БГД-ийн хяналт тавьж байгаа прокурорын байгууллагаас нь ирүүлээд байна. Тэгэхээр үүнтэй холбоотой энэ хэргийг хянан шийдвэрлээд эрүү шүүлт тулгасан юм уу, үгүй юу. Цагдаагийн албан хаагч буруутай юм уу, үгүй юу. Тэгээд үүнтэй нь холбогдуулаад тодорхой мэдээллийг бол даруй хийх ёстой гэж үзэж байгаа. Тэгэхдээ энэ бол мөрдөн шалгах ажиллагааны байгууллагын өөрийнх нь харьяалдаг хуулийн чиг үүргийн асуудал гэдгийг нь бас онцлон тэмдэглэе.

2 дугаар асуудал 461 дүгээр цагдан хорих ангид байхдаа яг юу болов гээд. Энэ дээр 7 сарын 11-нд бол гэдэс орчмоор өвдөж байна гээд. Тэгээд хорихын дотоод журмынхаа дагуу үзлэг эмчилгээ бол хийсэн байна. Эмч нар нь үзсэн байна. Тэгээд 13-нд бол эргээд буцаад гарсан байна. Эргээд 17-ны орой бас таагүй байна гэдгээ мэдэгдсэн байна. Ингээд эхо-д үзсэн. Тэгээд энэ биеийн байдлыг нь бол өөрсдөө журмын дагуу бид нар үзлэгээ хийсэн гэдгээ хэлж байгаа. 22-ны орой бид нар бол түргэн тусламж үзүүлэх шаардлагатай болсон учраас 3 дугаар дугаар эмнэлэг рүү бид нар шилжүүлсэн. Түргэн тусламж дуудаад ингээд шилжүүлэн өгсөн гэдгийг нь хэлж байгаа юм. Тэгээд энэ болсон үйл явдал камерын бичлэгийг харахаар 2 хүнтэй хамт бас цагдан хоригдож байсан. Тэгээд энэ хугацаа бол ерөөсөө 1 минут 20 секунд орчмын хугацаа байгаа юм. Таталт өгч байгаа юм. Тэгээд тэр нь дуудаж байгаа юм. Тэгээд тэр тэр шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хариуцсан албан хаагчид нь очоод тэгээд дараа дараагийн үйл ажиллагаа явж байгаа ийм хугацаанууд байна. Энд энэ

ямар үйл явдлыг тогтоох ёстой вэ гэхээр эмч нь өөр бусад байдал дээр бол бид нар хүний эрх зөрчигдсөн гэж үзэхгүй байна. Тэр эмчийн тусламж үйлчилгээ буюу эхо-гоор харсан гэж байна. Анх биеийн бүтцийг нь оношилсон гэж хэлж байна. Энэ үедээ тэр үрэвсэл өөр бусад шатлалын эмнэлэгт шилжүүлэх ёстой байсан уу, үгүй юу гэдэг талаар бол бас эмч, эмнэлгийн байгууллагуудаас нь өөрсдөө зохих ёсны хариугаа өгөх ёстой гэж үзэж байгаа юм. Тэгээд амь хохирсон шалтгааныг мэдээж Шүүхийн шинжилгээний ерөнхий газар буюу тэр шинжээч эмч нар дүгнэнэ. Ямар шалтгаанаас болж амь нас нь хохирсон бэ гэдэг, нас барсан бэ гэдгийг тогтооно. Тэрийг үндэслэж байж бол дараагийн бид нар дүгнэлтээ гаргах боломжтой.

3 дахь асуудал байгаа. Тэр нь эмчилгээ үзүүлэх үедээ 3 дугаар эмнэлэгт энэ бол 24 цаг орчмын үйл явдал өрнөж байгаа. Тэгээд энд бол өөрөө бол ухаангүй байсан учраас, хүчилтөрөгч дутагдсан байсан учраас бид нар бол эмчилгээ үйлчилгээ үзүүлэхдээ өөрийг нь бол хүлэх шаардлагатай болсон. Ингээд хөдөлгөөнгүй байлгах шаардлагатай болсон гээд тайлбарыг эмчлэгч эмч хэлж байгаа. Бас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын албан хаагч хэлж байгаа. Тэгэхдээ энэ дээр гав хэрэглэсэн гэж байгаа юм. Тэгэхээр энэ гав хэрэглэсэн гэдэг дээр бол бид нар эмчилгээ үйлчилгээний журам байх ёстой гэж үзэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар ч гэсэн, Эрүүл мэндийн газар ч гэсэн. Яагаад гэвэл олон хүмүүс дээр мэдээж ийм явдал тохиолддог байх. Тэр яах ёстой болдог байх. Эмчилгээ үйлчилгээг зохих журмын дагуу мэдээж үзүүлэх ёстой болдог байх. Хэрвээ өөрөө ухаангүй юм уу эсвэл тийм нөхцөл байдал байдаг бол янз бүрийн нөхцөл байдал үүсдэг учраас. Тэгэхээр энэ дээр гав хэрэглэсэн гэдэг дээр бол хүнлэг бус, хэрцгий харьцаа байна. Тэр эмчилгээний журам юу байдаг юм. Түүнийгээ дагах ёстой байсан. Ийм явдал бол 1 удаа үүсдэг гэж бодохгүй байна. Тэгэхээр энэ

дээр эмчилгээ өөрөө ямар дүрэм журам горимоор үзүүлэх ёстой байдаг юм. Тэр хүмүүсийг тэрийг нь бол энэ хүнлэг бус хэрцгий харьцааны асуудал байна гэж дүгнээд, энэ дээр бас шалгах шаардлагатай. Зайлигүй юм уу, ямар нөхцөл байдалтай байсан юм. Эмчилгээ үзүүлэхдээ хэрвээ ийм өвчтөн ирвэл яаж үйлчлүүлэх журамтай байдаг юм. Ямар арга хэрэгсэл ямар зүйлийг хэрэглэх ёстой байдаг юм бэ гээд энэ асуудлуудыг тодруулах ёстой гэж ингэж үзэж байна. Ийм ажиллагаануудыг Хүний эрхийн Үндэсний Комиссоос бол хийсэн.

2 дахь асуудлын хүрээнд ер нь эрүү шүүлттэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдаад 23 жил болж байна. 23 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна. Байгуулагдсанаас хойш халдашгүй байх эрх, эрүү шүүлтээс ангид байх эрх гэдгийг нийт 15 удаагийн илтгэлдээ тус бүрд нь сэдэв болгож хөндсөн. Түүний үр дүнд мэдээж тодорхой бас зарим өөрчлөлтүүд гарч байгаа. Хууль тогтоомжийн хүрээнд, албан хаагчдын хандлагын хүрээнд, тогтолцооны хүрээнд, урьдчилан сэргийлэх хүрээнд, таслан зогсох хүрээнд гээд энэ ажлууд хийгдэж байгаа. Хамгийн сүүлд гээд дурдахад 23 дахь илтгэл дээр халдашгүй байх эрх гэж нэг бүлэг байна. Тэр дээр энэ сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр цагдан хорьж байна гэдэг асуудлыг хөндөж тавьсан. Түүний мөрөөр Улсын Их Хурлын тогтоол дээр тусгасан. Одоо тэгээд үүний үр дүнд энэ Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газар ахлаад Хүний эрхийн Үндэсний Комиссоос бас Энхболд гишүүн орсон. Ингээд энэ дээр одоо бол 8 сарын 1-ээ энэ оны 1 сарын 17-нд орсон Эрүүгийн хуульд ямар өөрчлөлт орсон бэ гэхээр шүүгчийн зөвшөөрөлгүйгээр 1 ч цагдан хорих ийм шийдвэр гарахгүй гээд. Өмнө нь бол 24 цаг, цагуудын асуудал хэдүүлээ яриад байгаа шүү дээ. Одоо энэ манай амь хохирсон иргэн дээр бас ярьдаг. Бид нар энийг тэр хугацаанд нь саатуулсан юм. Тэгээд шүүгчийн захирамжийг бол

нөхөж авсан юм гэдэг асуудал ярина. 8 сарын 1-ээс одоо нөгөөдрөөс энэ 4 дэхээс их үйлчилж эхлэх хууль дээр шүүгчийн зөвшөөрөлгүйгээр ямар ч цагдан хорих тийм асуудал байхгүй гэдэг асуудлыг ярьж байгаа. Тэгээд үүнтэй холбоотой зохион байгуулалтыг хийсэн үү, бэлэн үү гээд энэ оны 5 сард жишээлэх юм бол Хүний эрхийн Үндэсний Комиссоос уриалаад. Яагаад гэвэл журмууд гарах ёстой. Жижүүрийн шүүх, тойргийн шүүх гээд бэлэн байх ёстой. Бүх цаг үед амралт хамаагүйгээр, шөнө, өдөр хамаагүйгээр шүүгч ажиллаж байх ёстой болсон энэ хуулийн дагуу. Тэгээд энэ дээр бид нар бэлэн байгаа юу бүх холбогдох байгууллагууд. Журам дүрэм нь гарсан уу, хүний нөөц чинь бэлэн үү, бүгдээрээ ойлгочихсон уу, энэ хуулиа ер нь хэдүүлээ таньж мэдсэн үү гэдэг асуудлаар 5 сард хүртэл Хүний эрхийн Үндэсний Комиссын уулзалт зохион байгуулалтыг хийгээд юу бид нар бэлтгэх ёстой юм бэ. Хэн, ямар байгууллага гэдэг дээр бас хэлэлцүүлэг өрнүүлж байлаа.

23 дахь илтгэлийн 1 асуудал бол шийдэгдээгүй. Тэр нь хүний эрхийн ээлжит төлөв байдлын хэлэлцүүлэг гээд UPR гээд товчлоод байдаг. Тэр дээр өгсөн зөвлөмжийн 3 дахь хэлэлцүүлэг дээр өгсөн зөвлөмжийн 1 нь юу вэ гэхээр тэр НҮБ-ын гишүүн байгууллагуудаас эрүү шүүлт тулгасан хэргийг тусдаа мөрдөн байцаах байгууллагыг байгуулаач гэсэн. Тэрийг бол бид нар одоогийн хууль тогтоомжоор АТГ энэ үүргийг хэрэгжүүлээд явж байгаа. Тэгэхээр тусдаа байгуулаач, энэ чинь яагаад гэвэл дандаа тусгай субъект бүхий албан хаагчдыг мөрддөг шалгадаг учраас тэнд ийм тусдаа нэгж байх ёстой байна. Тэгж байж энэ эрүү шүүлттэй тэмцэх, таслан зогсох ажил чинь үр дүнтэй байж чадна гэдгийг НҮБ-ын гишүүн орнуудаас зөвлөсөн. Тэрний мөрөөр 1 арга хэмжээ бас авна уу гэдгийг нь Улсын Их Хурлын энэ тогтоолд. Бас хүний эрхийн үндэсний комисс бас тусгуулсан. Одоогийн байдлаар бол хэвээрээ байгаа. Авлигатай тэмцэх

газрын нэгж одоо энэ асуудлыг харьяалан шийдэж байгаа хэвээрээ байгаа.

Урьдчилан сэргийлэх асуудлаар энэ бид нар хууль тогтоомжийн асуудлыг 1 дүгээрт нь бас их бүгдээрээ ойлгох ёстой юм байна лээ. Тэгэхээр хууль тогтоомжийн асуудал дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын хувьд тулгардаг асуудал юу вэ. Шударга ёс, хүний эрхийг хамгаалах тогтолцоо бүх төрийн байгууллагуудын ажил бөгөөд хэрвээ гэмт хэрэг, зөрчил гарсан тохиолдолд 22.2 гэдэг заалтаар ХЭҮК-ыг оролцохыг хориглохыг хориглож байгаа юм. Яагаад гэвэл 2 давхацсан шүүх ажиллах ёсгүй. Шүүх систем бол шүүх тогтолцоо өөрөө ажиллаад, эцсийн шийдвэрээ гаргаад, хүний эрх зөрчсөн эсэхийг нь тогтоогоод буруутай этгээд нь гэм бурууг нь ноогдуулаад, тэгээд хохирогчийн эрхийг нь сэргээх энэ тогтолцоо бол шүүх юм гэж. Энэ тогтолцооны хэсэг нь Үндсэн хуульд зааснаараа шүүх байна, прокурор байна. Хяналт тавина гээд хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурор. Тэгэхээр энэ хэсэг рүү ХЭҮК орох боломж нь хуулиараа хаалттай. Бид нар ямар хүрээнд өөрсдөө сайн дураараа гэдэг юм уу бид нар идэвхийлэн оролцдог вэ гэхээр процессын ажиллагаанд хүний эрх хангагдсан юм уу гэдэг рүү бол бид нар байнга орж байгаа. Хяналт шалгалт хийж байна. Хорих ангиудад, цагдан хорихуудад, СЭМҮТ-д асрамжийн газруудад, хүүхэд хамгааллын байр гээд бүгдэд нь хийдэг. Тэгээд зэрэгцээд жишээлэх юм бол прокурортой адилхан. Бид нар хяналт шалгалт хийгээд явж байгаа. Тэгээд өөрийнхөө эрх хэмжээнд гэж үзсэн хүрээндээ бид нар шаардлага тавиад, зөвлөмжөө өгөөд явж байгаа юм.

Тэгээд 2023 оны байдлаар гэхээр 60 гомдол яг эрүү шүүлттэй холбоотой тулгасан гэдэг асуудлаар ирсэн. Үүнээс 6-г нь бол зөвлөмж болгож өгсөн. Нөгөө

бид нарын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль дээр байгаа бас нэг асуудал бол хэрвээ манай чиг үүргийн асуудал биш юм бол бид нар 72 цагийн дотор эрх бүхий байгууллагууд нь шилжүүлэх үүрэг хүлээдэг. Тийм учраас Авлигатай тэмцэх газар, шүүхийн шийдвэр гээд энэ байгууллагууд руу нь өөрсдийнх нь харьяаллын дагуу шилжүүлдэг. Ингээд шилжүүлсэн байна. Заримыг нь бол бид нар өөрт нь зөвлөсөн ийм байдлаар бол 60 гомдол ингээд шийдэж байна. Тэгээд тогтолцооны хувьд эргээд харахаар бас хурал даргалагчийн асуусан асуулт байна. Энэ тогтолцоо өөрөө ажиллаж чадаж байгаа юм уу гэж. Энэ дээр хууль тогтоомж дээр нь тогтолцооны хувьд анхаарах ёстой хэд хэдэн асуудлууд байгаа. Саяын хэлдэг тэр тусдаа нэгж гэдгийг яах юм. Байгуулах юм уу гэдгийг Монгол Улс өөрөө шийдэх ёстой.

2-т нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийг бид нар эрүүгийн хуульд тусдаа гэмт хэрэг болгож хуульчилсан нь сайн хэрэг. Үүгээр зүйлчлэгдэж байгаа, яг ял шийдэгдэж байгаа хэрэг бол цөөхөн байгаа. Яагаад вэ гэвэл одоо тэр эрүү шүүлтийн эсрэг конвенцтойгоо бид нар энэ Монгол Улсын хууль тогтоомж чинь өөрөө нийцсэн үү гэдэг асуултад хариу өгөх ёстой болдог. Хүнлэг бус, хэрцгийн харьцаа, нэр төрийг гутаан доромжлох, эрүүдэн шүүх гээд 3 ойлголтыг бид нар хамт нэг дор нь хийчихсэн учраас заримдаа энэ нь бас төвөг бэрхшээл учруулдаг, зүйлчлүүлэхэд бас төвөг учруулдаг гэдгийг бас хэлээд байгаа юм. Тийм учраас одоо бид нар ингээд бодит байдлыг харъя. Эрүү шүүлт тулгахын эсрэг тэр 22.10-ын эсрэг гэмт хэргийг шийтгэгдсэн хүн хэд вэ. Цөөхөн байна. Энд асуудал байна. Тэгвэл үүнийг бид нар хууль тогтоомжийн хүрээнд энийг бас ялгах ёстой. Бүгдээрээ тэр 3 зүйлийг нэг дор нь ингэж хавсарсан нийлмэл өгүүлбэр байдлаар ойлгохгүйгээр тус тусад нь энэ нь ямар учиртай юм, энэ нь ямар юм бэ гэдгийг бас хууль тогтоомжийн хүрээнд энэ ялгаа заагийг нь гаргаж өгөх ёстой.

Мөрдөн шалгах байгууллагын хувьд энэ ялгаа заагийг нь гаргаж өгөх ёстой. Тэгээд цагдаагийн байгууллага дээр бол тусдаа энэ хэрэг эрүүдэн шүүлттэй холбоотой асуудал дээр дүгнэлт өгөөд, яг юу хийх юм бэ энэ тогтолцооны хувьд гэдгийг нь хийх ёстой. Дотоод хяналт шалгалт нь ажиллаж чадаж байгаа юм уу, үгүй юу гэдгийг бас Хууль зүй, дотоод хэргийн сайдын зүгээс энэ дээр бас анхаарлаа хандуулаад тогтолцооны хувьд бид нар юу хийж чадах юм бэ.

Дараагийн асуудал бол мэдээж энэ албан хаагчдын хандлагын асуудал байна. Албан хаагчдын хандлага бол бүх л эрх зүйн суурь чухал, тогтолцоо чухал. Тэгээд мэдээж хэрэгжүүлж байгаа албан хаагчдын ойлголт, хандлага, мэдлэг, чадвар, дадал гэдэг энэ асуудал чухал. Тийм учраас энд урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа хийсээр л байх болно. Шаардлагатай байнга тогтмол хийх ёстой. ХЭҮК энэ талаар юу хийв.

Дагнаад сүүлийн 3 жил бол 430 хяналт шалгалтыг зөвхөн энэ эрүүдэн шүүх, хүнлэг бус хэрцгий харьцаа байна уу. Нэр төрийг нь гутаан доромжилсон уу гэдгээр хийсэн. Тэр болгонд нь бид нар түүний мөрөөр хариу арга хэмжээг аваад явж байгаа. Сургалт хийж байгаа. Сургалтыг бид нар зөвхөн албан хаагчдад зориулж хийж байгаа. Мэдээж энэ нөгөө эрүүдэн шүүх гэдэг өөрөө гэмт хэрэг чинь тусгай субъект л үйлдэх боломжтой учраас яг тэр зэвсэгт хүчин ярьдаг, тэгээд энэ хууль сахиулах чиглэлийн байгууллагууд энэ тэртэй хамтраад л бид нар ингээд сургалтаа хийгээд, сургагч багшаа бэлтгээд, ингээд малтикатор болгоод ингээд цаашаа энэ үйл ажиллагаа бас өргөжүүлсэн. Энийг бол тасралтгүй үргэлжлүүлэх л ёстой ажил. Тэгээд цагдаад бэлтгэж байгаа, зөвхөн цагдаагийн албан хаагч биш. Ер нь энэ хууль сахиулах чиглэлийн албан хаагчаа бэлтгэж байгаа Дотоод Хэргийн Их сургуулийн хүний эрхийн хөтөлбөрт уржнангаас эхлээд очиж танилцсан.

Ямар хэмжээнд хүний эрх үздэг юм бэ гэдэгтэй танилцсан. Тэгээд энийг хангалттай байна гэж үзээгүй учраас одоо бол нөгөө НҮБ-ын төсөлтэй хамтраад ямар байвал зохих юм хичээлийнх нь хөтөлбөрийг гаргаад туршаад эхлээд ингээд явж байна гээд бүх үйл ажиллагааг л цогцоор хийх ёстой юм байна лээ л дээ. Бүх шатдаа. Одоо ажлаа хийж байгаа албан хаагчидтай ажиллах ёстой, тэр албан хаагчийг бэлтгэж байгаа сургуультай ажиллах ёстой. Тэгээд энэ хууль тогтоомжтой ажиллах ёстой, тогтолцоотой ажиллах ёстой гээд энэ асуудлуудыг бол шийдэх ёстой юм байна.

Хувийн мэдээллийг задруулж байгаа байдалд бүх төрийн албан хаагчид үнэхээр нухацтай хандмаар байна. Одоо тэр хүний хувийн байдлыг би бол хуульчдын хувьд хэдүүлээ энд ингээд Хүний эрхийн дэд хороонд тайлбар тавиад сууж байгаа хуульчдын хувьд бол ойлгож байна. Хувийн нөхцөл байдал, үйл баримтыг хуульчид бол дандаа дурддаг. Тэгэхдээ олон нийтэд хэдүүлээ мэдээлэл өгөхдөө нөгөө Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг 2021 оноос хэдүүлээ хэрэгжүүлж эхэлж байна. Тэр дээр эмзэг мэдээлэл, хувийн мэдээллийг олон нийтэд шаардлагагүй бол битгий өгөөч гэдэг асуудлыг байнга дурдаж байгаа. Тэгэхээр энэ дээр албан байгууллагуудын хувьд мэдээж тэр тодорхой үйл баримт тэр мэдээллүүд ирэх ёстой. Яагаад вэ гээд. Жишээ нь цагдан хорих үндэслэл байсан уу, үгүй юу гэдэг дээр тайлбарлах юм бол тэр нь хувийн байдал чухал шүү дээ. Яагаад гэсэн юм бэ гэдэг. Тэгэхээр энэ байдлыг олон нийтэд ялангуяа мэдээлэл өгөхдөө бүгдээрээ энэ төрийн байгууллагууд анхаарахгүй бол болохгүй байна. Хувийн мэдээлэлд нь хэдүүлээ тэр хуулиа баримтлаад, тэгээд үүнийг бол чанд баримтлах шаардлагатай байна. Энийг бид нар ингээд Хүний эрхийн Үндэсний Комиссоос дахиад зөвлөмж өгч байгаа юм. Шаардлага өгч байгаа юм. Тэгээд уриалж байгаа юм. Анхааруулж байгаа

юм. Хувийн мэдээлэл дээр хэдүүлээ маш нухацтай хандъя. Яагаад гэвэл бид нар ОУБ-ын хүний эрхийн индекс харах юм бол халдашгүй байх эрхийн үзүүлэлт манайх муу хангалтгүй. Бид нар хувийн мэдээлэл хүний орон зай хүндэтгэх тэр энэ асуудал дээр бол их хойрго. Одоо тогтолцооны хувьд ч хойрго байлаа. Эрх зүйн хувьд ч хойрго байлаа. Одоо тэгээд урагшлах алхам хийгээд Хувь хүний нууцын тухай хууль гэдэг 1996 оны хуулиа шинэчилсэн шүү дээ. Тэгээд хүний хувийн мэдээлэл гэдгийг чинь бид нар ялгаад, зааглаад, хэн цуглуулах юм, ямар үед цуглуулах юм, ямар үед мэдээлэх юм бэ гэдгээ зохицуулчихлаа. Тэгэхээр энэ дээр төрийн байгууллагууд тун анхааралтай хандаж, нухацтай ийм алдаа дутагдал гармааргүй байна. Иргэнийхээ нэр хүндэд халдаж байгаа давхар буруутгагдаж байгаа, нэг ийм юу бол гаргамааргүй байна. Энийгээ болих хэрэгтэй байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад прокурор хяналт тавьдаг. Тэгэхээр прокурор бол жишээ нь бас энэ мэдээлэл өгч байвал зүгээр субъектийн нэг байгаа. Яагаад гэхээр бид нар жишээлэх юм тодорхой нэг ийм хэрэг кэйс гараад, ялангуяа ийм эрхээр хангагдахгүй байна гээд түрүүн хэлсэнчлэн бид нар хэрэг рүү нь бол орох эрхгүй. Тэгэхээр бид нар өмгөөлүүлэх эрхээр хангасан юм уу, эсвэл тэр нөхцөл, орон байр, бусад эрүү шүүлтээс ангид байх эрх нь хангадаг уу гээд үзэхээр энэ дээр бас прокурор давхар хяналт тавьдаг учраас яг энэ тогтолцооны нэг чухал хэсэг учраас прокурор энэ дээр хариултаа өгч байх ёстой. Бас дүн шинжилгээ хийх ёстой. Хэр идэвхтэй ажиллаж байгаа юм. Тогтолцооны хувьд бид нар ажиллаж чадаж байгаа юм уу гээд прокурорын байгууллага бас энэ дээр хариулах л ёстой л гэж бодож байна.

Өмгөөлөгчөөр ажиллах нөхцөл гээд энэ дээр одоо бид хэд мэдэж байгаа даа. Сая жишээлэх юм бол яг шууд эрүүдэн шүүхтэй бол хамаагүй. Сэтгүүлчийн

асуудал сая шүүхээр шийдвэрлэгдлээ. Тэр дээр ХЭҮК ямар хүсэлт өгсөн бэ гэхээр бид нар ажиглагчаар сууя гэсэн. Тэгээд 5 гэмт хэрэгт энэ хүн буруутгагдаж байгаа юм байна. Тэгэхдээ тэрний 2 нь нууцтай хамаатай юм байна. Тэр нууцтай хамааралгүй 3-ыг нь нээлттэй явуулж өгөөч гэж хүсэлт гаргасан. Тэгээд хүлээж аваагүй л дээ. Төрийн болон албан нууцын тухай хуультай бол холбоотой шүүх хурал бол 1 дүгээрт хаалттай байх ёстой. 2 дугаар ХЭҮК бол энэ тогтолцооны оролцогч биш гэж шүүх, прокуророос дүгнэдэг. Тэгэхээр энэ дээр бас Комиссын тухай хууль, Процессын тухай хууль, бусад хуулиар энэ зааг ялгааг бас тодорхой болгож өгөхгүй бол олон нийт комиссоос шууд дүгнэлт хүсдэг. Гэтэл комиссыг хуулийг нь харах юм бол мэргэжлийн, хараат бус ажиллаач гэсэн. Тэгэхээр бид нар ингээд шууд зарим нэг хэрэг маргааныг шууд дүгнэлт өгөх боломжгүй. Зарим нь болдог. Зарим нь бол энэ шууд зөрчил гээд бид нар хэлж чадахуйц тийм нөхцөл байдал байдаг. Илэрхий тодорхой. Тийм биш талуудыг бид нар сонсох ёстой. Нотлох баримтыг нь цуглуулах ёстой, үнэлэх ёстой, дүгнэх ёстой тийм нөхцөл байдал байдаг. Энэ чинь нөгөө мэргэжлийн гэдэгтээ ороод байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас ойлгож хандахгүй бол бид нар мэдээж цаг тухайдаа мэдээллийг өгөх үүрэгтэй. Өгөөд явна. Тэгээд хийж байна, явж байна, ажиллаж байна гэдгээ бол хэлнэ. Одоо жишээлэх юм бол амь хохирсон иргэний тухайд ч гэсэндээ бид нар Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тодорхой тодорхой ийм байгууллагуудын дүгнэлтийг хүлээж байна ч гэдэг юм уу ийм нөхцөл байдал байдлыг бас танилцуулъя.

Ингээд орхигдсон зүйл байвал хуралдаан даргалагчаас хэлсэнчлэн бид нар бас нэмж хариулъя. Манай эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн байна. Гомдол хянан шалгалтын хэлтсийн дарга бас байгаа.

Х.Тэмүүжин: Сүнжид даргад баярлалаа. Одоо Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэдээллийг сонсьё. **О.Алтангэрэл.**

О.Алтангэрэл: Тэмүүжин гишүүн ээ, нөгөө саяын бүх асуултуудын чиглэлээр үү, ерөнхий мэдээлэл үү.

ШШГБ-ын харьяа хорих 461 дүгээр ангид цагдан хоригдож байсан иргэн О харамсалтайгаар амь насаа алдсан ийм хэрэг гарсан. Тэгээд хэрэг гарсан даруйд ШШГБ болон цагдаагийн байгууллагаас танилцуулга авч, Хууль зүйн яамны зүгээс танилцсан. Тэгээд Хууль зүйн яам дотоод хяналт шалгалтынхаа хүрээнд энэ болсон үйл явдлын хүрээнд чухам ямар явдал болоод өнгөрөв. Хуулийн зөрчил байна уу гэдэг байдлаар хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулсан. Зарим чиглэлийн үйл ажиллагаа нь энэ ХЭҮК-ын танилцуулсантай давхцаж байна. Болсон үйл явдлын талаар бол манай энэ цагдаагийн удирдлагууд болон ШШГБ-ын удирдлагууд яг үйл явдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг бол өгөх байх. Тийм учраас ер нь яг Хууль зүйн яамны хувьд ямар үйл ажиллагаа явуулав. Цаашидаа ер нь юун дээр анхаарах ёстой гэж үзсэн бэ. Цаашид ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ гэдэг дээр та бүхэндээ товч мэдээлэл өгье.

Хууль зүйн сайдын хувьд хохирогчийн ар гэртэй нэлээд хэдэн удаа утсаар ярьсны эцэст биечилж уулзсан. 25-ны өдрийн 20 цаг 30 минутаас 22 цаг 30 минут хүртэл уулзсан. Энэ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тавьж байгаа болон энэ өөрсдийнхөө гомдолтой байгаа хэсгүүдийн талаар өмгөөлөгч, тэгээд хууль ёсны төлөөлөгчид нь ирж өөрсдийнхөө гомдлыг танилцуулсан. Үүнийх нь дагууд Хууль зүйн яамнаас байгуулагдсан Хяналт шинжилгээ үнэлгээний газар болон Бодлогын хэрэгжилтийн газраас төлөөлөл оролцуулж бид нар ажлын хэсэг байгуулсан. Тэгээд энэ ажлын хэсгийнхээ хүрээнд удирдамж чиглэл

болгож энэ үйл ажиллагааг явуулсан. Ар гэрийнх нь зүгээс бол үндсэн 3 зүйлийн талаар бидэнд гомдолтой байгаагаа хэлсэн.

1 дүгээрт хамгийн гомдолтой байгаа зүйл бол амь хохирогчийн хувийн эмзэг мэдээллийг олон нийтэд дэлгэлээ. Энэ дээр бол маш гомдолтой байна гэдэг асуудал ярьсан.

2 дахь асуудал нь энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээг цагт нь үзүүлсэнгүй. Амьд байж болох байсан. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байхдаа гав хэрэглэж, тусгай хэрэгсэл хэрэглэж, ингэж ухаангүй байхад нь хүний эрхийг ноцтой зөрчсөн гэдэг ийм гомдол гаргасан.

3-д нь бол яагаад манай дүү ингээд өөрөө цагдаагийн байгууллагын эрүүдэн шүүсэн байж болзошгүй гэдэг асуудлаар гомдол гаргачхаад байхад энэ асуудал нь огт шийдэгдэлгүйгээр ингээд сэжиглэгдэн шалгаж байсан хэргийнхээ улмаас нас барж байгаа юм бэ гэдэг энэ үндсэн 3 агуулга дээр төвлөрч ярьсан. Хохирогчийн төлөөлөл болон өмгөөлөгч нар яг энэ асуудлаар асуулт тавьсан.

Бид бас энэ асуудлын хүрээнд тодруулахаар ажилласан. Нэн тэргүүнд цагдаагийн байгууллагад Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа мөрдөн шалгах ажиллагаа гол явуулж байгаа газар бол цагдаагийн байгууллага байдаг. Цагдаагийн байгууллагын бүх түвшинд дахиж мэдээлэл хийхдээ ер нь бол яг тусгайлсан ийм манай цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код журам дотор прокурорын зөвшөөрөлтэйгөөр мэдээллийг хийнэ гэдгээс биш бас яг ийм нарийвчилсан зүйл байхгүй юм байна лээ. Цаашид хохирогчийн талаар мэдээлэл хийхдээ, нэн ялангуяа амь хохирогчийн талаар мэдээлэл хийхдээ хувийн эмзэг мэдээллийг задруулахгүй байх ёстой гэсэн ийм чиглэл өгсөн. Дүрэм журамд тусгуулах талаар

ажиллаж байгаа. Одоо ба бараг бэлэн болж байгаа байх.

Харин энэ түрүүн Сүнжид гишүүний ярианд гарч байна. Энэ гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүд сэжигтэн яллагдагчийн талаар бол шаардлагатай тохиолдолд энийг хэлэхээс арга байхгүй. Энэ хүн нь бол урьд нь ийм ийм хэргээс оргон зайлсан этгээд нь ийм ийм хэргийн улмаас сэжиглэгдэж байгаа гэдэг ч юм уу ийм мэдээллийг олон нийтэд өгөх шаардлагатай мэдээллийг өгөхөөс өөр арга байхгүй. Харин хохирогчийг ямар ч тохиолдолд урьд нь биеэ үнэлэгч байсан гэдэг юм уу, энэ бэлгийн харьцаанд орж байсан гэдэг юм уу, эсвэл урьд нь гэмт хэрэг үйлдэж байсан, тэдэн удаагийн ял шийтгэлтэй гэх байдлаар ерөөсөө эмзэг мэдээллийг задруулахгүй байх гэсэн энэ чиг үүргийг өгсөн.

ШШГБ-аас ер нь энэ үйл ажиллагаагаа бид нар хууль дүрмийн дагуу явуулсан гэдэг тайлбарыг удаа дараа гаргасан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ажлын хэсэг ажилласан. Зарим нэг зөрчлийг бид нар тодорхой төрлийн зөрчил байна гэж энэ үйл ажиллагаа дээр үзсэн. Тэгэхдээ бас цаашид анхаарахгүй бол болохгүй асуудлууд байгаад байгаа нь үнэхээр манай энэ хорих байгууллага, хорих ял эдлүүлж байгаа болон энэ баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлж байгаа байрнуудад байгаа эмч, эмнэлгийн боловсон хүчин үнэхээр муу байна. Техник хэрэгсэл үнэхээр муу байна. Энэ дадлага туршилагатай гэдэг юм уу эмч нар хорих байгууллагад ажиллах, ялтнууд, хоригдлуудтай ажиллах, сэжигтэн, яллагдагчидтай харьцах сонирхол багатай байна. Хүн тогтохгүй байна. Боловсон хүчний гэсэн энэ олон жил хуримтлагдсан асуудлууд энэ асуудалд нөлөөлж байна гэж үзсэн. Мөн би хуралдаа хаалттай яваа гэж ойлгож байгаа. Амь хохирогч маань ... хаагаагүй байгаа юу. Нээлттэй байгаа юу. Тэгвэл...

Х.Тэмүүжин: Ер нь бол нөгөө хувь хүний эмзэг мэдээлэл болон төрийн нууцтай холбоотой асуудлаас бусдыгаа яриад, яг тэр асуудлаар ярья гэвэл хуралдааныг хаах горим гаргаад хааж болно. Тэрнээс бусад асуудлаа бол нээлттэй ярьчихъя гэсэн.

О.Алтангэрэл: Тэгвэл ялгаагаа яах вэ. Одоо ер нь эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудал дараа нь ярья гэж тооцох уу. Хүлээж байгаад. Одоо нөгөө эмнэлгийн тусламж үзүүлсэн байдал, хэрэгцээ, шаардлага энэ тэр ярихаар эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудал ярих гээд байна л даа.

Х.Тэмүүжин: Тэгвэл одоо хаалттай горимоор яваад эмзэг мэдээлэлтэй холбоотой тэр хэсгийг нь сонсчихоод. Тэгээд нээе.

Хүний эрхийн дэд хорооны хуралдааны энэ хэсгийг хаалттай горимоор явъя гэдэг санал гаргаж байна. Санал хураалт явах уу. Хааж нээхэд 5, 5 минут хэрэгтэй гэсэн. Тэгэхээр техникийн хүн хэлээд хаалттай боллоо гэхээр хэдүүлээ үргэлжлүүлэе.

/Хаалттай хуралдаан/

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын гишүүд бас оролцож байгаа. Мөнхбаясгалан оролцож байна. Баясгалан оролцож байна. Цэнгүүн оролцож байна. Баярмаа оролцож байна. Шижир оролцож байгаа. Хууль зүйн сайд мэдээлэл өгөх зорилготой оролцож байгаа.

Нөгөө нээлттэйгээр ярина гээд хойшоо суучихсан 2, 3 гишүүн байгаа. Тийм нөгөө хувийн мэдээлэлтэй юм асуухгүй гээд хойшоо суучихсан гишүүд байгаа. Тэр гишүүд маань асуухаар асуулт чинь давтагдаж магадгүй. Тэгэхээр тэр асуултынхаа хүрээгээр явчихъя. Эхний ээлжид. Ард нь үг хэлэх горим байгаа. Бүгдээрээ хугацаандаа үгээ хэлж болно. Дахиад нөгөө хувийн

мэдээлэлтэй хэсгээ ярихгүй шүү. Хувийн мэдээлэлтэй хэсэгт нь нөгөө ял эдэлсэн, ямар хэргүүд шалгагдаж байгаа мөн нөгөө өвчний хамаарал бас байгаа шүү. Ямар ч байсан нэрсээ авчих уу. Хэн хэн нөгөө үг хэлэх эрхээ дарчихлаа. Асуулт асуулт гишүүд Баасанжаргал байгаа. Цэнгүүн байгаа. Баярмаа байгаа. Нарантуяа түр нэрээ авчих. Дахиад дарчих. Баасанжаргал, Цэнгүүн, Баярмаа хааччихсан. Чи бүртгэлдээ орсон уу. Баярмаа ороод ирлээ. Баярмаа, Баасанжаргал, Цэнгүүн дахиад сая үг хэлээгүй. Номинчимэг байхгүй юм уу. Нарантуяа ээрээ авчих. Дахиад дарчих. Болж байна. Уянгахушиг нэрээ авчих түр зуур. Цэнгүүн, Баасанжаргал, Баярмаа, Тэмүүжин. Эхний ээлжид. Эхлээд нөгөө түрүүн асуултууд асуучихсан нь хойшоо суучих. Энэ 3 хүн асуултуудаа асуусны дараа сая бол асуулт нь гарсангүй. Би асуумаар байна гэвэл нэрсээ авъя. Болсон уу. Одоо дахиад асуулт асууя гэж байгаа. Түрүүний ярьсан хүмүүс одоо кнопоо дарчих. Шижир, Мөнхбаясгалан, Нарантуяа дарсан уу. Эрдэнэболд, Баясгалан, Нарантуяа байхгүй л байна даа. Нарантуяа, Тэмүүжинийг оруулаад асуулт хаалаа. Байж байгаарай. Нарантуяа орсон. Уянгахушигийг нэмээд. Би нэрийг чинь дурдаадахъя. Цэнгүүн, Баасанжаргал, Баярмаа, Мөнхбаясгалан, Шижир, Эрдэнэболд, Баясгалан, Нарантуяа, Уянгахушиг, Тэмүүжин. Эрдэнэболд байна. айна Цэнгүүн.

С.Цэнгүүн: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр Хүний эрхийн дэд хорооны хурал 2 цаг 40 минут орчим үргэлжилж байна. Бид нар нөхцөл байдалтай холбоотойгоор талийгаач О-ийн нөхцөл байдалтай, кэйстэй танилцаад ярилцлаа. Тэгэхээр эндээс 1 зүйл ажиглагдаж байгаа нь бид нар маш олон хууль, дүрэм журмуудыг ажлын хэсгийнхэн бол ярьж байна. Тэгээд энэ тухайн хууль, дүрэм журмын дагуу үйл ажиллагаанууд болсон гээд бүгдээрээ бол өөрсдийнхөө үйл ажиллагааг бол зөвтгөх зүйлүүд бол хэлж байна.

Тэгэхээр 1 зүйлийг ингээд хараад үзэхээр манай улсад ер нь хэрэгждэггүй маш олон хууль дүрэм журмууд байна. Тэр нь хоорондоо холбоотой ажиллаж байгаа байгууллагууд нь бол ямар ч нийцэлгүйгээр ажиллаж яваад байна. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос би асуумаар байгаа зүйл нь одоо үнэхээр хэрэгжиж байгаа хууль, дүрэм журмууд дээр 800 гаруй зүйл заалтуудыг нь өөрчилж байж хүний эрх өнөөдөр Монголд хамгаалагдах боломжтой гэж яригдаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн ажлын төлөвлөгөө та бүхэнд байгаа юу. Дээрээс нь ажлын хэсгийн гишүүдээс бас асуухад үнэхээр өнөөдөр нэг кэйсээр хаагдахгүйгээр энэ чинь цаашидаа ахиад маш олон хүн дээр тулгамдаж болох, одоо яг энэ байдал процесс бол адилхан харагдаж байна л даа. Тэгэхээр энэ процессоо яаж уялдуулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа вэ. Энэ дээр ямар нэгэн ажлын хэсэг ажиллаж байгаа юу гэж асууя.

Х.Тэмүүжин: 1 дүгээр микрофон.

Д.Сүнжид: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Хууль тогтоомжийг санаачлах эрх нь 3 субъекттэй байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс санаачилсан хуулийн төсөл болон одоо үйлчилж байгаа хууль тогтоомжид хүний эрхийн үүднээс зөрчилтэй, давхардалтай, хийдэлтэй асуудлууд дээр саналаа тухай бүр өгөөд явж байгаа юм. Хамгийн сүүлд бол илтгэлийг дагуулаад Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хуулиудыг жишээлбэл сайжруулах шаардлагатай гээд үндэслэлийг нь тэгээд 1 хуулийнх нь төсөлтэй нь хамт жишээ нь өргөн барьсан. Засгийн газрын зүгээс Хүний эрхийн багц хууль гээд өнгөрсөн 5 дугаар сард санал авсан. Тэрэнд нь холбогдох бүх хууль тогтоомжид нь санал өгөөд ажиллаж байна. Тэгэхээр Алтангэрэл сайдыг бас би энэ дээр тодорхой Засгийн газрын

байр сууриа илэрхийлэх болов уу гэж бодож байна. Хууль санаачлагчдын холбоотой ажлын хэсэг байгуулах, шинээр хууль тогтоомжийг санаачлах. Комиссын зүгээс энэ дээр санаачилсан эсэхээс үл хамаараад ямар хуульд ямар өөрчлөлт орвол зохистой вэ гэдэг саналаа бол тухай бүр уламжлаад явж байна.

Х.Тэмүүжин: Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс Хүний эрхийн багц хуулиуд дээр ажиллаж байна. Энэ Хүний эрхийн багц хуулийг Монгол Улсын Засгийн газраас өргөн барина. Энэ дунд бол олон асуудал байгаа. ХЭҮК-оос ер нь бол энэ Хүний эрхийн Үндэсний Комиссоос хөндөж тавиад байгаа асуудлууд, эрүүдэн шүүлт болон хүний эрхийн нөхцөл байдлуудтай холбоотой асуудлуудыг салбар бүрийн их олон хууль тогтоомжид суулгах ёстой юм билээ. Энэ дээр бас сая гол хуулиудыг нь манай Сүнжид гишүүн дурдаж байна. Нэн ялангуяа бид нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдсэн эрүүгийн хууль тогтоомжийн чиглэлээр бас нэлээн олон өөрчлөлт оруулах ёстой. Бас нэг асуудал бол энэ түрүүн манай байгууллагуудын үйл ажиллагаанд танилцуулагдаад байгаа таны бас хөндөж тавьж байгаа энэ гэрч хохирогчийг хамгаалах асуудал. Тахарын алба гээд гэрч, хохирогчийг хамгаалдаг, шүүхийн аюулгүй байдлыг хамгаалдаг ийм том алба байсан. Энэ алба татан буугдсан. Ингээд тус тусын байгууллагадаа чиг үүргээ шилжүүлж авсан. Түрүүн Авлигатай тэмцэх газрын тэр яриан дундаас бас гарч байна. Жишээлбэл Авлигатай тэмцэх байгууллагад энэ гэрч хохирогчийг хамгаалах чиглэлээр нэгж байдаггүй. Ингэхээр бол энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж чаддаггүй гээд. Тэгэхээр бид бол энэ хүний эрхийн тогтолцоо дээр гэрч хохирогчийг хамгаалах талаасаа бас ухралт хийсэн.

Өнгөрсөн сонгуулиар энэ улс төрийн сонгуульд орсон намуудын мөрийн хөтөлбөрт гэрч хохирогчийг хамгаалах талаар алба байгуулахаар тусгагдчихсан байгаа. Бид нар энэ гэрч хохирогчийг хамгаалах, шүүхийн аюулгүй байдлыг хамгаалах талаар энэ байгууллагыг дахиж байгуулах, өнөөдөр иргэдийн зөрчигдсэн эрхийг бас хэрхэн яаж хамгаалах вэ гэдэг тал дээр ажиллаж байна. Үүнтэй нийлээд бид нар Хүний эрхийн багц хуулиуд, энэ дотроос нэлээн олон хуулийн төслүүдийг ирэх намрын чуулганаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын зүгээс ажиллаж байна.

Х.Тэмүүжин: Гишүүдэд дахиад хэлэхэд хууль санаачлах эрх 3 субъект байгаа. Хэрвээ хэрэгжүүлэгч агентлагууд ямар нэгэн хуулийн санал байгаа бол Хууль зүйн яамаар дамжуулаад, саналаа нэгтгээд тэрүүгээр өргөн баригдана. Ер нь бол Улсын Их Хурлын гишүүд тэр дундаа Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгын хороо энэ 4 жил яг энэ хүний эрхийг хангах чиглэлээр өөрсдөө санаачилгатай нэлээн сайн ажиллах ёстой байх. Хууль санаачлах эрх нь өөрөө манай дээр бүрэн байж байгаа учраас хэн нэгнийг чи санаачлаач ээ гэж шаардахаас илүүтэйгээр саналуудаа боловсруулаад, хуулийн төслөө өргөн бариад хэлэлцүүлэх боломж Улсын Их Хурлын өөрт нь бүрэн байгаа шүү.

Дараагийнх Баасанжаргал.

Х.Баасанжаргал: Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам 2-оос 2, 2 асуулт асуугаадахъя.

1 дүгээрт, Цагдаагийн ерөнхий газар танай цагдаагийн алба хаагчдын ачаалалтай холбоотой судалгаа ер нь хамгийн сүүлд хэзээ хийгдсэн бэ. Ажлын байран дээрх зураг авалт, ажлын ачааллын талаар та бүхэнд ямар бодитой судалгаанууд байдаг вэ. Энэ талаар хэрвээ та мэдэж байвал хэлээд, үгүй бол дараа нь бид нарт мэдээлэл өгөөрэй гэж хэлэх гэсэн юм.

2 дугаарт, цагдаагийн алба хаагчдын ажлын үзүүлэлтийг шалгахдаа ямар үзүүлэлтээр шалгадаг вэ. Миний мэдэж байгаагаар, санаж байгаагаар мөрдөгчдийг үйлдсэн яллах дүгнэлтээр нь, тэгээд нөгөөдөх нь буцаад хэрвээ шүүх дээр цагаатгах юм ажлын үзүүлэлтээс нь буурдаг. Хэв журмын цагдаа нарыг бол торгууль, орлого бүрдүүлэх байдлаар энэ сарын орлого тэдэн төгрөг ч гэдэг юм уу ийм байдлаар ажлын үзүүлэлтүүдийг нь шалгаад байна гэж хараад байдаг. Тэгэхээр энэ ажлын үзүүлэлтүүдийг шалгадаг ямар шалгуур үзүүлэлтүүд байдаг вэ. Энэ чинь өөрөө бид нарын энэ хүний эрхийн зөрчлийг үүсгэх нөхцөлийн чинь нэг нь биш биз дээ гэдэг ийм асуудлаар асууж байгаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс энэ хэв журам мөрдөн байцаах алба 2-ыг ер нь цаашид салгах тийм бодлого байгаа юу. Эсвэл прокурор нь өөрөө энэ мөрдөн байцаах ажиллагаагаа хийгээд, цагдаа нь өөрөө энэ хэв журмаа хариуцаад явах юм уу, яах юм. Энэ дээр ер нь энэ цагдаагийн байгууллага яг энэ хариуцаж байгаа чиг үүрэгтэй холбоотой энэ тогтолцооны хувьд ямар нэгэн өөрчлөлт хийгдэх үү гэдэг асуулт байна.

2 дугаарт Хууль зүйн яамнаас мөн Цагдаагийн ерөнхий газар өөрөө хариулах байх. Хүний эмзэг мэдээллийг сая задалсан хэвлэлийн хурлыг хийсэн. Тэгэхээр энэ бол нэгэнт хууль зөрчсөн гэдэг нь нийтэд илэрхий байна. Үүнийхээ төлөө хариуцлага хэн хүлээх вэ.

Хүний эрхийн Үндэсний Комисс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа Цэлмэн гишүүнээс хэд хэдэн асуулт байна. Мөн Авлигатай тэмцэх газар бас үүн дээр нэмж хариулах хэрэгтэй болох байх. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ийм чиг үүрэг бүхий нэгжийг байгуулсан нь бол маш өндөр хүлээлттэй байгаа. Хэдийгээр байгуулагдаад удаагүй ч гэсэндээ бас нэг

их удаагүй гэхгүй бас багагүй хугацаа өнгөрсөн гэж уг нь бол харж байгаа. Тэгэхээр яг энэ эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж байгуулагдаад ямар үр дүнд маш тодорхой хүрсэн үр дүн байна уу. Таны Хууль зүйн яаманд өгсөн Энхбаяр сайдыг байх үед өгсөн гээд энэ албан тоот юмнуудыг бол харлаа. Гэхдээ үүн дээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрлэгдсэн хэргээс тоонууд гарч ирээд байна. Яг цагдаа, мөрдөн байцаах алба, Авлигатай тэмцэх газарт яг энэ эрүү шүүлттэй холбоотой өгсөн гомдол мэдээлэл хэд ирээд, хэд нь шүүх рүү шилжээд, хэд нь прокурорын шатдаа хэрэгсэхгүй болоод байгаа юм бэ. Үүний бас цаад учир шалтгаан өөр янз бүрийн асуудлууд байгаа юм биш биз дээ. Яагаад гэвэл 1-5 жилийн хорих ялтай ийм төрлийн хэрэг байгаа. Эрүү шүүлт нь өөрөө. Өөрөөр хэлбэл маш бага ялтай байгаа. Тэгэхээр магадгүй хохирогч нөгөө тусгай субъект буюу цагдаагийн.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Нэмэлт 1 минут.

Х.Баасанжаргал: Хоорондоо тохиролцоод хэрэг нь хаагдчихдаг юм биш биз дээ гэдэг ийм зүйл байна. Тэгэхээр танайхаас ирж байгаа энэ тоон мэдээллүүд чинь шүүхийн шийдсэн хэрэг биш, танай өөрийнхөө чиг үүргийн хүрээнд хийгээд, олж аваад мэдсэн мэдээлэл тоонууд хэр байдаг вэ гэдгийг асуух гэсэн юм.

Тэгээд 2 дугаарт энэ хохирол барагдалт. Яг энэ эрүүдэн шүүлттэй холбоотой гэмт хэргийн хохирогч болоод хохирол нь хэрхэн барагдсан юм. Хэчнээн төгрөг барагдсан байдаг юм гэдэг дээр яг тодорхой мэдээлэл хэрэгтэй байна.

Хамгийн сүүлд Авлигатай тэмцэх газраас мэдээж камертай газар хүнийг эрүүдэн шүүхгүй. Ойлгомжтой. Миний мэдэж байгаагаар БГД-т камергүй хэд хэдэн газар цагдаа нар ийм төрлийн зөрчлийг үйлддэг нь манай өмгөөлөгчдийн дунд бол маш тодорхой яригддаг. Одоо

болтол засагдаагүй бололтой юм шиг байна. Тэгэхээр үүнтэй холбоотой дорвитой авах арга хэмжээ юу байдаг вэ. Танай Авлигатай тэмцэх газар дээр ирж байгаа мэдээллийн дагуу шалгаад үзэхээр камергүй гэдэг үндэслэлээр нотлогдохгүй гээд үндэслэлээр хэрэгсэхгүй болж байгаа хэчнээн хэрэг байдаг вэ. Үүний цаад учир шалтгааныг нь шалгах талаар.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Эхлээд Хууль зүйн сайд. Хүний эрхийн Үндэсний Комиссоос асуусан. Хууль зүйн сайдаас асуусан. Цагдаагийн ерөнхий газраас асуусан. Хэн нь эхэлж хариулах юм. Хүний эрхийн Үндэсний Комисс. 1 номер.

Д.Сүнжид: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Хамгийн сүүлд асуусан хохирол барагдуулах асуудлаар. Хохирлыг барагдуулах тогтолцоо Монгол Улсад бол тун хэцүү байгаа. Хохирол ер нь барагдахгүй байгаа. Гэрч хоригчийн хамгаалах тухай хууль ч үүнтэй холбоотой. Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдсан цагаасаа эхлээд 52 нэхэмжлэлийг бусдын нэрийн өмнөөс шүүхэд хандаж гаргаж шийдүүлсэн байна. Ихэнх нь эрүү шүүлттэй холбоотой, бас амь нас алдсантай ч холбоотой ийм гомдлууд байгаа. Тэгээд ер нь бол 90 хувь нь энэ 52 шүүхээр шийдүүлээд, тодорхой хэмжээний мөнгөн төлбөр дүйцүүлээд, гэм хорын төлбөр ингэж шийдүүлсэн нэхэмжлэлийг аваад үзэхээр ерөөсөө л энэ цагдан хоригдсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэм буруутай тогтоогдоогүй байхад эсвэл дараа нь гэм буруугүй нь тогтоогдсон гэдэг ийм үндэслэлээр бол төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас эрх нь зөрчигдсөн ийм хүмүүсийн өмнөөс нэхэмжлэл гаргасан байдаг. Яг мөнгөн дүнг нь харах юм бол Хүний эрхийн Үндэсний Комиссын нэхэмжлэлийн мөнгөн дүн тийм хангалттай сайн биш. Сая Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын үр дүнд бас зарим гэмт хэргийн улмаас сэтгэцэд

учирсан хор уршгийг тооцуулах боломж нээгдсэн. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын анхны хохирол барагдуулахтай холбоотой мэдээлэл өгөхөд ийм байна.

Хамгийн сүүлд бол бид нар Чимгээ гээд Хүний эрхийн Үндэсний Комисст хандсан. Эрүүдэн шүүгдсэний улмаас гэм хорын нэхэмжлэл гаргаж өгөөч гээд энэ хэрэг дээр Хүний эрхийн Үндэсний Комисс ажиллаж байна. Цэлмэн гишүүнээс бусад асуултад нэмж хариулна.

Я.Цэлмэн: Гишүүний асуултад хариулъя. Цэлмэн. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн. Монгол Улсад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа үүсэн бий болоод 2 жил хугацаа өнгөрч, 2 удаагийн тайлангаа бол Хууль зүйн байнгын хороонд танилцуулсан. 2 удаагийн тайландаа Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдал, тэр дундаа эрүү шүүлт тулгах гэмт хэрэг, түүний бүртгэл, шийдвэрлэлтийн талаар бол тодорхой мэдээлсэн. Энэ дээр бас тодорхой зөвлөмжүүд болон манай тайлан дээр тодорхой байгаа. D-Parliament.mn дээр орж харж болно. D-Parliament.mn дээр бүрэн барьсан. Гэхдээ жилд ойролцоогоор ирж байгаа энэ 3 оронтой тоотой гомдол мэдээллийн шүүхээр шийдвэрлэгдэж байгаа байдал бол сүүлийн 3 жилд бол 3 хэрэг л шийдвэрлэгдсэн байгаа. 3, 3 хэрэг жилд шийдвэрлэгдэж байгаа. Үндэсний ажиллагаа үүсэн бий болоод ямар үр дүнд хүрсэн бэ гэхээр 1 дүгээрт бид хуулиар хүлээсэн 4 чиг үүргийг асуудал эрхэлсэн гишүүн хэрэгжүүлэх ёстой үндэсний хэмжээнд. Энд бол мэдээж хүн өөрөө гарч явах боломжгүй бүх газарт хяналт шинжилгээ хийх ёстой. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тогтолцооны шалтгаан нөхцөл юу байна судалж, зөвлөмж хүргүүлэх зорилгоор. Ингээд Монгол Улсад нийтдээ албан ёсны статистик баримтаар бол 400 гаруй хүнийг сайн дураар нь гарч явах боломжгүй байдалд богино, дунд, урт

хугацаанд байлгаж байгаа ийм газар төрийн байгууллага бий. Энд бол миний энэ хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хяналт шинжилгээ хийх ёстой. Тухайн хүмүүс.../минут дуусав/

Х.Тэмүүжин: 1 номерын микрофоныг нээе.

Я.Цэлмэн: Ёстой хүн бол жилд давтагдсан тоогоор 140 гаруй мянган иргэн шууд тулж энэ хяналт шинжилгээ хийх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааг явуулах ийм шаардлагатай. Дээрээс нь Монгол Улсын бүх төрийн албан хаагчид эрүү шүүлт тулгах гэмт хэргийн субъект болохоор ингэж 2015 оны Эрүүгийн хуульд хуульчлагдсан. Эрүүгийн хуулийн 21.12 дээр. Тийм учраас энэ бүх төрийн албан хаагч нартаа бид нар урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, судалгааг бол хийж хэрэгжүүлж ажиллаж байна. Үр дүнд нь юу хүрсэн бэ гэхээр үндэсний хэмжээндээ бид эрүү шүүлт гэж юу вэ, түүний хор аюул нь ямар аюултай юм бэ гэдгийг бол сүүлийн 2 жил бол тодорхой мэдэж ойлгож бүх түвшинд эрүү шүүлтийн чиглэлээр ярилцаж, хэлэлцэж хор аюулыг байж байгаа энэ бодит үр дүн болов уу гэж харж байгаа. Бид үүсгэн байгуулагдаад нийт 35 зөвлөмжийг хүргүүлсэн. Энэ зөвлөмж бүрийг тайланд оруулчихсан учраас түүнээс бас харахыг хүсэж байна. Гол нь тоон мэдээ бас асуулаа. Бидний өөрсдийн авсан тоон мэдээ бол анх байгуулагдаад 6 сарын хугацаанд тайлагнасан тайландаа бол 6 удаагийн хяналт шинжилгээний хүрээнд гомдол мэдээлэл иргэдээс болон хоригдсон хүмүүсээс, цагдан хоригдсон хүмүүсээс авч холбоотойгоор шилжүүлсэн. Өнгөрсөн хугацаанд бол 66 гомдол мэдээлэл болж, 11 дахин өссөн. Үүнтэй холбоотой гомдол.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Болж өгвөл хугацаандаа тодорхой хариулаарай. Дахиад 1 минут сунгачихъя.

Я.Цэлмэн: Бидний авсан тоон мэдээг тайландаа оруулсан. Ингээд хорих ангийн алба хаагчид эрүү шүүлт тулгасан энэ зөвхөн холбогдсон гомдол мэдээлэл аваад шалгуулсан тоон мэдээ 10, прокурорын алба хаагчтай холбоотой эрүү шүүлт тулгасан чиглэлээр бид нарт ирсэн гомдол мэдээлэл 8, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагч эрүү шүүлт тулгасан чиглэлээр ирсэн гомдол мэдээлэл 7, бусад албан тушаалтан бол ингээд 2 гэсэн ийм одоо байдалтай байгаа.

Мөн шударга шүүхээр шүүлгэх эрхийг сэргээлгэх талаар хилс хэрэгт холбогдсон талаар бол 5 удаагийн гомдол, мэдээлэл, хууль зүйн туслалцаа авч чадахгүй байгаа болон хууль зүйн туслалцаа авахдаа бүрэн авч чадаагүй ийм өмгөөллийн байгууллагатай, өмгөөлөгчтэй холбоотой гомдол бол 10, нотлох баримт шалгуулах шүүхэд нэхэмжлэл гаргах чиглэлээр бол 11 гэсэн ийм. Мөн ялгаварлан гадуурхалттай холбоотой 5 гомдол, биечлэн хууль зүйн зөвлөгөө авах хүсэлт хангагдаагүй гэсэн 8 гомдол мэдээлэл ирснийг холбогдох байгууллагад шилжүүлж шалгуулсан. Ер нь бол хамгийн гол нь бол бид олон улсын зарчим, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдэх тухай хуульдаа бол хуульчлаад өгчихсөн байгаа. Энэ юу вэ гэхээр мөрдөн шалгах ажиллагааны явцад тухайн хүнд эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг хэрвээ эрүүдэн шүүж авсан байх юм бол тухайн хүний үйлдсэн гэмт хэргийг.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Цагдаагийн ерөнхий газраас 2 дугаар микрофон.

Т.Сүхболд: Гишүүний асуултад хариулъя. Бид энэ цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалал өнөөдөр ямар түвшинд явж байна вэ гэдэг дээр 2022 оноос хойш судалгаа хийсэн. Өмнө нь бас 2017, 2018, 2019 онуудад судалгаа бол явагдаж байгаад тухайн үед нь бас ажлын байрны ачаалалтай холбоотой холбогдох нэгжүүдийг өөрчлөх ийм

шийдвэрүүд гарч байсан. Цагдаагийн байгууллагын ажлын ачааллыг бид нар хөндлөнгийн байгууллагаар болон албадын өөрсдийнх нь дотоод хүчээр, мөн цагдаагийн хуульд заасан судалгааны төв цагдаагийн байгууллагын ажил болон энэ судалгааны төвөөрөө ингээж энэ жил хийлгэсэн. 2001, 2002 онд бол энэ судалгааг би өөрөө гардан бас хийж байсан. Ажил бол ачаалалтай байгаа. Энийгээ бид нар энэ судалгаа, дүн шинжилгээ дээрээ тулгуурлаад, ажлын ачаалал дээрээ тулгуурлаад, газар нутгийнхаа онцлог дээр тулгуурлаад зарим нэг бүтэц болон нэгжүүд дээрээ өөрчлөлт оруулахаар ингээд ажиллаж байгаа. Энэ бас 9 сарын дунд үеэс эхлээд хийгдээд эхэлнэ. Мөн энэ ажлын ачаалал бол яах вэ, Эрүүгийн мөрдөгч бол Улаанбаатар хотын хэмжээнд 160-80 гар дээрээ хэрэг бүртгэлтийн хэрэгтэй байна. Мөрдөн байцаагч бол нэг 20-60 хэрэгтэй байна. Орон нутаг, зарим орон нутагтаа ажлын ачаалал арай бага ийм л байгаа. Энийг бол бид нар нөгөө нутаг дэвсгэрийнх нь гэмт хэргийн гаралт онцлогоос нь шалтгаалаад бас ингээд дотор нь өөрчилж болох юм байна гэдгийг хараад ингээд юмнуудаа хийж байгаа. Торгох ажлын үзүүлэлт дээр ямар юу тусгаж өгдөг вэ гэж байна. Ажлын үзүүлэлт бол ер нь 2024 онд бүх албадын ажлын үзүүлэлт шинэчилсэн. Энэ миний тушаалаар бүх албадын дарга нарт ажлын чиглэл өгөгдөөд ажлын үзүүлэлтүүд өөрчилсөн. Ажлын үзүүлэлт дотроо жишээлбэл та мөрдөн байцаах албыг ярьж байна. Мөрдөн байцаах албанд бол иргэдийн өгсөн гомдол мэдээллийг түргэн шуурхай хуулийн анхны хугацаанд нь шалгах. Шалгаж байвал ажлын үзүүлэлтэд орно. Дээрээс нь иргэдийн хохирлыг нөхөн төлүүлж байвал ажлын үзүүлэлтэд орно. Дээрээс нь иргэдийн дуудлага гомдол мэдээлэлд хамгийн түргэн шуурхай очиж байвал ажлын үзүүлэлтэд орно гэсэн ийм томоохон иргэд рүүгээ чиглэсэн ажлын үзүүлэлтийг л оруулсан. Тэгснээс хуулийн хугацаагаа сунгаад, хэрэг маргаанаа шийдэхгүй, нэг газар луу лавлагаа авах

гэж тоот хүргүүлчхээд тэрийгээ хүлээгээд байгаа энийг бол ажлын үзүүлэлтэд оруулахгүй гэдгийг яасан. Тэгснээс зөвхөн шүүхэд шилжүүлж яллагдагчаар татсанаа биш. Тэр бол орно. Мэдээж хохирогчтой юм чинь хохирлын хэмжээг барагдуулах шүүхэд шилжүүлэх саналтай прокурорын байгууллагад хүргүүлэх эд нар бол орно. Аль болохоор нөгөө хэргийг эрүүгийн хэргийг мөрдөн байцаалтын шатад хэрэгсэхгүй болгох ажил бол байхгүй гэдгийг л энэ ажлын өөрчлөлтдөө тусгаж өгсөн.

Х.Тэмүүжин: Нэмэлт минут.

Т.Сүхболд: Хэв журмын цагдаа, замын цагдаа энэ торгох шийтгэлээр ажлыг нь үнэлдэг. Энэ бол больсон. Энэ бол нөгөө яг Зөрчлийн тухай хуулиа зөрчсөн үйлдэл илэрсэн тохиолдолд л арга хэмжээ авъя гэдэг л болсон. Голцуу бид нар камерын тусламжтайгаар зөрчлөө шалган шийдвэрлэх, бусад зөрчил хянан шийдвэрлэх үйл ажиллагаа явуулах байгууллагад нь шилжүүлэх ийм ажлууд л хийж байгаа.

Экологийн бүх зөрчлийг бусад зөрчил хянан шийдвэрлэх байгууллагад шилжүүлж байгаа. Тэгээд ийм нэг юмнууд хийж байгаа. Дээрээс нь урьдчилан сэргийлэх ажлаа тэргүүлэх зэрэг болгоё гэсэн ажлын үзүүлэлтийг л бүх нэгжийн даргын ажлын үзүүлэлтэд оруулж өгсөн. Та гэмт хэрэг гараад араас нь мөрдөх биш, урьдчилан сэргийлж чаддаг дарга бай гэдэг энэ ажлыг тэгээд энэ хөтөлбөрийг цогцоор нь бий болгоод юу хийхийг нь хэлж өгөөд, одоо улсын хэмжээнд цагдаагийн байгууллага камержуулах, ногоон бүс болгох ажлууд явагдаж байгаа. 2 дүүрэг, 1 аймаг бол ногоон бүс болчихсон.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Авлигатай тэмцэх газраас. Хэд дээр суух гэж байна. 5 дугаар микрофоныг нээе.

Ч.Жаргалбаатар: Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Жаргалбаатар байна. Тэгээд энэ эрүү шүүлттэй холбоотой гэмт хэрэг, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг шалгаж байгаа талаар та бүхэнд товч мэдээлэл өгье. 2002 оноос 2014 он хүртэл Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанаас энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан. 2014-2018 оны хооронд бол Цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсээс хэргийг шалгаж байгаад 2018 оноос Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа. Тоон мэдээ статистикийн хувьд байгууллага бүр өөр өөр зөрүүтэй гараад байгаа. 2002-2014 оны хувьд бол эрүү шүүлт тулгасан гэмт хэргийн бүртгэлийг нь аваад үзэх юм бол 12 жилийн хугацаанд 18 хэргийг шүүхэд шилжүүлэх санал гаргасан боловч яг шүүхийн шийдвэр нь хэрхэн гарсан талаар бол мэдээлэл байхгүй байгаад байгаа. Энэ цаг хугацааны шалтгаан нь юу юм бэ гэхээр бараг зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүү шүүлт тулгасан бол гэсэн гэмт хэргийн шинжийг тэгж тодорхойлж өгсөн субъектийн хийдэлтэй холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргүүд цөөхөн шийдвэрлэгдэж байсан юм байна лээ. 2014-2019 оны хооронд бол 5 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Одоо шүүхийн шийдвэрийн сангаас шүүгээд үзэхээр. 2020-2024 оны хооронд Авлигатай тэмцэх газраас 15 хэргийг шүүхэд шилжүүлсэн. Шүүхийн шийдвэрийн сангаас үзэх юм бол 2019-2024 оны хооронд 15 хэрэг энэ төрлийн гэмт хэрэг шийдвэрлэгдсэн байгаа юм. Энэ эрүү шүүлт тулгах гэмт хэргүүдийн гараад байгаа шалтгаан нөхцөл шалтгааныг судлаад, жил бүрийн эцэст бол цагдаагийн байгууллагад ийм ийм зүйлүүд нөлөөлөд байна. Энэ шалтгаан нөхцөлийг арилгаач гэдэг ийм мэдэгдлийг хүргэх, цагдаагийн байгууллагууд прокурорын байгууллагуудтай

хамтарсан сургалтуудыг зохион байгуулах ажлууд хийдэг. Зөвхөн камерын бичлэгээр энэ төрлийн гэмт хэргүүдийг нотлодоггүй. Бусад төрлийн нотлох баримтуудаар энэ төрлийн гэмт хэргүүдийг нотлох ажиллагаануудыг хийж байгаа. Тэгээд энэ нөгөө Эрүүгийн хуулийн гэмт хэргийн шинжийг бусад гэмт хэргүүд дээр давхиулан бичсэнтэй холбоотойгоор бусдын амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргээр эрүү шүүлтээр шалгаад шилжүүлсэн хэрэг маань шийдвэрлэгдсэн тохиолдол байна. Олон улсын конвенц болон Эрүүгийн хуульд зааснаараа энэ төрлийн гэмт хэргүүд маань шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн бүлэгт орж байгаа. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хууль бусаар явах төрлийн гэмт хэргүүд рүү бас орох тохиолдлууд байна. Одоо жишээ ярих юм бол цагдан хоригдож байсан хугацаанд үйлдэгдсэн гэмт хэргийг тухайн хүн хүлээгээд шүүх дээр очсон ийм тохиол лууд гарч байсан. Тэгээд энэ дээр яаж байна вэ гэхээр цаг хугацааны хувьд бид алдчихжээ гээд байдаг. Гэтэл нөгөө хэрэг гарсан цаг хугацаанд нөгөө хүн хоригдож байсан нөхцөл байдал тогтоогдчихоод энэ бол эрүү шүүлтийн шинжтэй юм гэдэг ийм нөхцөл байдлууд үүсэж байгаа.

Тэгээд ер нь Эрүүгийн хуулийн санцрын хувьд бид нар бас шинээр Эрүүгийн хуулийн төсөл боловсруулах, батлуулах шаардлага байгаа юм. Хүн хулгайлах гэмт хэрэг, мал хулгайлах гэмт хэрэг 2-ын яг адилхан санцртай. Тэгээд нөгөө гэмт хэргийн шинжийг нь давхардуулаад биччихээрээ ял шийтгэл оногдуулах зорилгоор хийсэн хуурамч нотлох баримт бүрдүүлсэн асуудлуудаар энэ төрлийн гэмт хэргүүд бас шийдэгдэх.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Нэмэлт хугацаа.

Ч.Жаргалбаатар: Хуурамч нотлох баримт бүрдүүлж бусдыг ялгаварлан гадуурхаж, шийтгэх зорилготой энэ төрлийн 46 хэрэг сүүлийн 4 жилд шүүх

эцэслэн шийдвэрлэгдсэн байх жишээтэй. Тэгээд энэ хүний эрхийн зөрчлүүд ийм олон байгаа учраас нэг бол хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болчихдог эсвэл өөр төрлийн гэмт хэргээр зүйлчлэгдээд байгаа учраас энэ статистик мэдээллүүд өөр хоорондоо зөрүүтэй яваад байгаа юм. Ийм мэдээллийг өгье.

Х.Тэмүүжин: Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Хэв журам, мөрдөн шалгах чиг үүргийн байгууллагуудыг салгах уу гэж асууж байна. Тэгээд өнөөдөр цагдаагийн байгууллага Цагдаагийн ерөнхий газрын бүтцэд энэ хэв журам, тээврийн цагдаа гэдэг юм уу энэ нэгж нь тусдаа. Дахиад энэ мөрдөн шалгахтай холбоотой, мөрдөн шалгах үйл ажиллагаанд оролцдог, тусалдаг энэ нэгжүүд нь бас өөр удирдлагатай явдаг. Тэгэхээр ер нь энэ үндэсний хэмжээний Мөрдөх албаны концепц 2012 оноос эхэлж манай Тэмүүжин гишүүн анх ярьж байсан. Сая 2020 оны сонгуулиар намуудын мөрийн хөтөлбөрт энэ Үндэсний мөрдөх албыг байгуулах асуудал тусгагдсан байна лээ. Зүгээр энэ асуудал яригдаад Улсын Их Хурлын түвшинд яригдаад, энэ асуудал яриад явбал цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах чиг үүрэгтэй холбоотой асуудал яригдах байх. Одоогоор Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс энэ цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой ямарваа нэгэн өөрчлөлт санаачилсан, энэ талаар хэлэлцэж байгаа, ярьж байгаа зүйл байхгүй.

Тэр 2 дахь хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудал. Тэгээд хариуцлагынхаа асуудал ярьж байна. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас энэ дотоод шалгалт хийж байгаа. Маргаани эцсийн байдлаар дүнгээ гаргана. Бас нэлээн олон хүнтэй уулзаж, олон байдлыг тодруулж байгаа. Ингээд хариуцлага тооцох асуудал яригдана. Хууль зүй, дотоод хэргийн сайдын зүгээс хууль сахиулах байгууллагууд, тэр дундаа энэ

цагдаагийн байгууллага, шийдвэр гүйцэтгэх байгууллагын энэ дэд дарга нартай холбоотой асуудал дээр бие даан шийдвэр гардаг. Энэ хүрээндээ шийдвэр гаргана. Харин энэ хууль тогтоомж зөрчсөн байж болзошгүй бөгөөд тогтоогдсон зөрчлүүдийн хүрээнд албан хаагчдадаа хариуцлага тооцох асуудлаар энэ байгууллагуудын дарга нарт шаардлага хүргүүлнэ. Тэгээд энэ цаашаагаа ямар арга хэмжээ авах вэ, ямар албан хаагчид хариуцлага тооцох вэ гэдгээ байгууллагуудын дарга нар бие даан шийдвэрлэх бололцоотой. Тэгээд энэ хүрээнд бүх түвшинд хариуцлагын асуудал яригдана.

Х.Тэмүүжин: Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Энэ өдрийн амрыг эрье. Ихэнх асуулт Баасанжаргал гишүүнийхтэй давхацчихлаа. Тэгэхдээ яриан дундаас 2, 3 зүйл тодруулъя гэж бодлоо. Цагдаагийн ерөнхий газар, Үндэсний комисс 2-оос.

Түрүүн Баясгалан гишүүн бас асуусан. Энэ Цэлмэн гишүүний яриад байгаа тэр нөгөө Авлигатай тэмцэх газрын албан бичиг маш тодорхой заасан байгаа. БГД-ийн Эрүүгийн мөрдөгчдийн тэр өрөө, албан тасалгаанд камер байгаагүй гээд удаа дараа хэлээд байгаа. Тэгээд энэнд яг та маш тодорхой хариулж өгөөч. Камер байгаагүй гээд байна. Яагаад байгаагүй юм. Та түрүүн яриандаа бол бүгдийг нь камержуулсан гэж байна. Тодорхой албан хаагчдын буруутай үйл ажиллагаанаас болоод камергүй байгаа бол тэр хүнд хариуцлага тооцно гэж хэлэх шиг болсон. Тийм хариуцлага тооцсон тохиолдол байна уу. Нэгд.

2-т, түрүүн бас нэг зүйл хэлсэн. Нотлох баримтаар хэрвээ эрүүдэн шүүсэн нь нотлох баримтаар нотлогдсон бол тэр гэмт хэрэгтнийг тэр хэрэгт гэмт хэрэг үйлдсэнийг үйлдсэн гэж тооцохгүй гэсэн агуулга. Тийм үү. Би яг тэр хуулийн хэллэг

мэдэхгүй. Яг ингээж шийтгэгдсэн тохиолдол байна уу. Тэгээд яг нотлогдоод, тэгээд тэр хэрэг нь энэ эрүүдэн шүүсэн байдлаар авагдсан учир гэж ингээж хаагдсан ч юм уу.

2-т, Үндэсний комиссоос ер нь нэлээн сая тоо баримт ярьчихлаа л даа. Тэгээд би жоохон ойлгомжтой байдлаар хэлээд өгнө үү л гэж хүсэж байна. 1000 орчим гомдол ирдэг гэсэн. Бас та бүгдийн хэвлэл мэдээллээр өгч байсан ярианд байсан. 1 жил тутам 34 орчим эрүүдэн шүүлттэй холбоотой гомдол ирдэг гээд. Яг хувилаад хэлээд өгөөч. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны явцад гараад байна уу. Хоригдож байх явцад яг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын одоо харьяа цагдан хорих байгууллага болон хорих ангиудад ялтан болчихсон хоригдлуудын түвшинд явагдаад байна уу. Эсвэл бол цэрэг армийн асуудлыг бас бид ярьдаг. Энэ 3 субъекттэй алинд нь илүү их энэ хүний эрхийн зөрчил гараад байгаа юм бэ. Тэгээд дахиад цагдаагийн газраас асуухад хүний эрхийн чиглэлээр сургалтууд хийдэг гэсэн. Энэ сургалтууд ер нь хэзээнээс эхэлж хийгдэж эхэлсэн бэ. Бие бүрэлдэхүүнд шинээр орж байгаа хүмүүст заавал хийдэг үү.

Дахиад 1 асуулт. Судалгаа хийдэг хөндлөнгийн байгууллагаар судалгаа хийлгэдэг гэж бас түрүүн хэлсэн. Тэгэхээр цагдаад итгэх итгэлийн талаарх судалгаа гэж хийж байсан уу. Энэ бол аягүй чухал санагдаж байна. Тэгэхээр та нар ер нь өөрсдийгөө иргэд та нарт хэр их итгэдэг гэж боддог вэ. Иймэрхүү асуулт асууя даа. Баярлалаа.

Х.Тэмүүжин: Бүгдийг нь ЦЕГ-аас бараг асуучих шиг боллоо. 2 дугаар микрофон.

Т.Сүхболд: Гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн байгууллагын хэмжээнд мэдүүлэг авах шаардлагыг хангасан прокурорын байгууллагын зөвшөөрөл бүхий яг одоогийн түрүүн 253 гэж хэлсэн. Яг одоогийн байдлаар бол

266 өрөө байгаа юм байна. Яг ингээд өдөр болгон зөвшөөрлийг нь сунгадаг өрөө нь 266 өрөө байгаа. Тусгайлан бэлтгэсэн 59, уулзалт мэдүүлгийн 169, насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах 38 өрөө ашиглагдаж байгаа. Өрөө тасалгааны боломжоос шалтгаалаад одоо мэдүүлэг авах зөвшөөрөл бүхий 253 зөвшөөрөл нь л яг байгаа юм байна. Таны хэлсэн тэр алба хаагчдын өрөө гээд. Алба хаагч өрөөндөө хүнтэй уулзах ёсгүй. Алба хаагч өрөөндөө тайлбар мэдүүлэг авах ёсгүй. Зарим газар бол яах вэ, зарим цагдаагийн газар хэлтсүүд дээр мэдүүлэг авах, тайлбар авах өрөөний хүрэлцээ муутайгаас шалтгаалаад алба хаагчийн сууж байгаа өрөөнд прокурорын зөвшөөрөлтэйгөөр мэдүүлэг байцаалт авах зөвшөөрөл авсан байгаа. Тэрэнд бол 2-оос дээшгүй алба хаагч суух гэдэг байдлаар. Тэгэхгүй бол 2 зэрэг мэдүүлэг авч болохгүй. Эсвэл ганцаараа сууж байгаа алба хаагчийн өрөөнд прокурорын зөвшөөрөл авсан. Энэ нь бол яг энэ 253-даа л орчихсон байгаа. Тэгэхээрээ эрүүгийн мөрдөгч жишигээр өрөөндөө хүнтэй уулзах ёс байхгүй. Энэ нь цагдаагийн байгууллагын хууль болон Цагдаагийн албаны тухай хууль болон энэ цагдаагийн байгууллагын холбогдох журмаар заагаад өгчихсөн байгаа. Цагдаагийн байгууллага бол нэгж цагдаагийн нэгж байгууллага бол прокурорын зөвшөөрөлтэй мэдүүлэг авах, байцаалт авах өрөөнүүдийн камерууд заавал ажиллах ёстой. Заавал ажиллах ёстой. Дээрээс нь тухайн байгууллагын аюулгүй байдал, алба хаагчийн аюулгүй байдлын үүднээс гадна орчин, нийтийн эзэмшлийн талбай, коридор, нийтийн эзэмшлийн талбай зэрэг нь камертай байх ёстой. Яг энэ зохих журмынхаа дагуу л явагдана. Энэ дээр нь дарга нар нь өдөр болгон хяналт тавина. Камер эвдэрсэн тохиолдолд дээд шатны байгууллагадаа энэ камер эвдэрчихлээ, солих шаардлагатай байна гэдгийгээ явуулна. Өөрсдийнхөө батлагдсан төсөв хөрөнгөөр өдөр тутмынхаа засвар үйлчилгээ солих шаардлагатай юмнууд хийгдэнэ. Хэрвээ

төсөв нь хүрэхгүй бол дээшээ камер авъя л гэсэн үг. Алба хаагчийн өрөөнд бол заавал тийм камер байх шаардлагагүй. Алба хаагч жишээлбэл өөрөө эрүүгийн мөрдөгч нар голдуу олуулаа сууж байгаа. Тэр зааланд иргэнтэй уулзах тийм журам байхгүй. Зөвхөн тэр тайлбар мэдүүлэг авдаг өрөөнд л иргэнтэй уулзана гэж ойлгох хэрэгтэй байгаа юм.

Цагдаагийн байгууллага энэ цагдаагийн алба хаагчийн ажил ямар байна вэ гэсэн иргэдээс нь олон төрийн болон төрийн бус байгууллага судалгаа шинжилгээ авсан байдаг. Бид нар хамгийн сүүлд.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Тодорхой, товч хариулаарай. Микрофоныг нээчихье.

Т.Сүхболд: 2021 онд энэ цагдаагийн алба хаагчийн үнэлгээтэй холбоотой судалгааг миний санаж байгаагаар Максима байгууллагаар хийлгэсэн. Яг цагдаагийн алба хаагчийг иргэд хэрхэн хүлээж авч байна. Цагдаагийн алба хаагч хэрхэн ажиллаж байна гэдэг судалгааг хийсэн. Тэр дээрээ тэгсэн дүн шинжилгээ хийгээд холбогдох журам кодтой өөрчлөлт оруулсан. Зарим нэг бүтэц өөрчилсөн ийм байгаа.

Х.Тэмүүжин: Микрофоныг нээе.

Т.Сүхболд: Заавал хийнэ. Дагалдах багш нар томилно. Тэгээд хүний эрхийн сургалтуудаа хийнэ. Сургалтын төлөвлөгөөгөө цагдаагийн байгууллага тухайн оныхоо 1 сарын 1-ээс хэрэгжүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яамдаа өгөөд, тэрнээсээ зөвшөөрөгдсөн тохиолдолд сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлнэ. Байгууллага болгон сургалтын төлөвлөгөө хийнэ. Хүний эрхийг хийнэ. Энэ жилийн хувьд бол Засгийн газар болон Хүний эрхийн комиссоос зөвлөмж өгсөн. Засгийн газраас үүрэг чиглэл өгсөн болохоор энэ 2024 онд бол арай илүү төсөв хөрөнгөтэйгөөр, илүү багштайгаар, багш нараа сургаж бэлдээд ингэж

явуулсан. Арай илүү төсөв хөрөнгөтэйгөөр л явуулсан. Ер нь бол үүрэг тавих болгонд хүний эрх л ярьж байгаа. Нийт хүний эрхтэй холбоотой.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Өөр хариулах хүн байгаа юу. 1 дүгээр микрофон. Хүний эрхийн Үндэсний Комисс.

Я.Цэлмэн: Хувилаад хэлээд өгье. Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газраас авсан гэмт хэргийн статистик, дүн мэдээгээр бол 2018-2022 онд нийт 385 гомдол мэдээлэл бол Эрүүгийн хуулийн 21.12, 14.1, 13.9 хууль бусаар баривчлах, ялгаварлан гадуурхах, эрүү шүүлт тулгах гэмт хэргүүд дээр бол ирсэн. Ингээд 471 хүн шалгагдсан. 359 гомдол мэдээлэлд буюу 93,2 хувьд нь Хууль зүй, дотоод хэргийн салбарын буюу цагдаагийн албан хаагчид холбогдсон байгаа гэсэн тоо байна.

Тэр нотлох баримт. Хэрэгт шалгагдаж байх явцадаа эрүүдэн шүүгдээд, эрүүдэн шүүгдсэн нь нотлогдоод, тэгээд эрүүдэн шүүгдсэн нотлох баримтыг шүүхээр бол тухайн хүний гэмт хэргийг нотлох үйл баримтаар тооцохгүй гэсэн хэргийн статистик Монгол Улс одоогийн байдлаар бидэнд авагдаагүй байна. Тийм учраас одоо энэ зарчмыг хэрэгжүүлэхийг Хууль зүйн салбарын сайдад жил болгон зөвлөмжөөрөө өгч байгаа. Их Хуралд мөн саналаа Хууль зүйн байнгын хороогоор дамжуулж танилцуулж байгаа. Хэд хэдэн хуулийн өөрчлөлт авахаар тогтоол батлагдсан байгаа. Баярлалаа.

Х.Тэмүүжин: Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Цагдаагийн ерөнхий газрын дарга Сүхболдоос асуулт асууя. Таны хийж байгаа ажил бол ерөөсөө л хүний эрхийн төлөө л өдөр шөнөгүй сургалт хийгээд л, цагдаагийн байгууллагынхны мэдлэгийг дээшлүүлдэг хүн байна шүү дээ. Таны ярьж

байгаагаар тийм ээ. Тэгэхэд амь хохирогчийн тухай эмзэг мэдээллийг дэлгэсэн. Олон нийтэд. Энэ бол хууль зөрчсөн үйлдэл мөн үү. Дээрээс нь ёс зүй, хүний эрх, хүнлэг ёсны талаар хэрвээ танай байгууллага ойлголттой бол, та ойлголттой бол өнөөдөр та Цагдаагийн ерөнхий газрын даргын хувьд хариуцлага хүлээгээд огцроход бэлэн байна уу. Танай БГД-ийн 1 дүгээр хэлтсийн мөрдөгчдөд зодуулсан гэдэг гомдол гаргасан хүн өнөөдөр эмнэлэгт гавтайгаа байж байгаад амь насаа алдчихсан байхад та нар бол зүгээр нэг муу хүн ирээд байж байгаад өөрөө үхчихлээ дээ гэсэн шахуу юм ярьж байна шүү дээ. Та ёс зүйн хариуцлага хүлээхэд бэлэн байна уу. 1 ч хүн одоогийн байдлаар яллагдагчаар татагдаагүй байна. Шалгалтын явцад.

Хууль зүйн сайдаас 1 юм асууя даа. Эмзэг байдлыг дэлгэсэн гэж яриад байна л даа. Цагдаагийн байгууллага, дарга нар хохирогчийн эмзэг байдлыг дэлгэчих юм бол ямар нэгэн хариуцлага хүлээхгүй хууль байна уу. Гэтэл сэтгүүлч Өнөрцэцэг онц ноцтой гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байсан хүний мэдээллийг дэлгэснээрээ өнөөдөр шоронд сууж байгаа шүү дээ. Энэ 2-т салгаж ангилах юм байна уу. Би түрүүн таны хэлсэн мэдээллээс харахад бол нэгэнт ингээд хоригдчихсон хохирогч хүний эмзэг байдлыг бол дэлгэж болохгүй. Нөгөөдөх нь бол онц ноцтой гэмт хэрэгт эрэн сурвалжлагдаж байгаа бол дэлгэдэг тийм хуулийн заалт байна уу. Хэрвээ байхгүй яг адилхан юм бол өнөөдөр энэ хүний эмзэг байдлыг дэлгэсэн хүмүүст ямар хариуцлага тооцох вэ. Түрүүний асуултыг дахиад нэг авчихъя даа. 1 ч хүн яллагдагчаар татагдаж өнөөдөр шалгагдаагүй гэсэн.

3 дахь асуулт Нандинболор даргаас асууя. Та түрүүн хэллээ. Ухаангүй тохиолдолд гавгүй байж байгаад оргосон 3 тохиолдол байдаг гэж. Яг ухаангүй юу тээ. Ухаангүй биш тээ. Би танаас ухаангүй байж байгаад бусдын бие болоод ямар нэгэн байдалд гэмтэл

учруулсан тохиолдол гарсан уу. Ухаангүй байж байгаад хорих газраас буюу эмнэлгээс оргосон тохиолдол гарсан уу гэж асуусан шүү дээ. Та яг ухаангүй байж байгаад, гавлаагүй учраас оргочихсон тийм тохиолдол надад хэлээд өгөөч. Тэгээгүй бол та гавтай байсныг бол өнөөдөр журмаа зөв байна гэж яриад байна шүү дээ. Танд ер нь хүний ёс гэдэг ойлголт хэр байна. Ухаангүй байгаа хүнийг гавлаж байгаад эмчилж болдог юм уу. Зүгээр хүний хувьд, бас хуульчийн хувьд. Эрх зүйч мэргэжилтэй. Ийм асуулт байна

Х.Тэмүүжин: Эхлээд Цагдаагийн ерөнхий газраас хариулт өгөх үү.

Т.Сүхболд: Гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн байгууллага гэмт хэргийн талаар болон гэмт хэрэгтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагааны талаар зөвхөн прокурорын байгууллагад танилцуулаад, прокурорын байгууллагын танилцсан хэмжээнд, прокурорын байгууллагын зөвшөөрсөн хэмжээнд ЭХХШТХ-ийн 29.3-д заасан прокурорын байгууллагын зөвшөөрөгдсөн хэмжээнд мэдээлэл өгдөг. Иргэдэд нээлттэй мэдээлэл өгдөг. Яах вэ, зүгээр мэдээлэл өгөх эсэхийг нь бол Цагдаагийн ерөнхий газрын дарга өгнө. Жишээлбэл яг энэ нийгэмд гараад байгаа энэ амь нас хохирсонтой холбоотой мэдээллийг өгөх үү эсэх үү гэдгийг. Мэдээлэл өгөхдөө зөвхөн хэрхэн ямар мэдээлэл өгөхөө зөвхөн мөрдөн шалгах ажиллагааны талаар мэдээлэл өгч байгаа учраас ямар мэдээлэл өгөхөө зөвхөн прокурорын байгууллагаас бичгээр тодруулга аваад энэ хуулийн дагуу зөвшөөрөгдсөн хэсэгт л өгнө. Манай алба хаагчид бидний бич өгсөн мэдээлэл дотор яг хуулийнхаа дагуу хүний эмзэг мэдээлэл гээд үзэхээр бид нар бас хууль зөрчөөгүй гэсэн ийм тайлбар ярьж байгаа юм. Энийг бол бид нар дотооддоо албан шалгалт хийлгэж байна. Таны түрүүн хэлсэнтэй адилхан үнэхээр энэ хүн эмзэг мэдээлэл, иргэний эмзэг мэдээлэл тараасан ийм гэмт хэргийн шинжтэй үйлдэл, дээрээс нь

прокурорын байгууллагаас яг энэ хэсгийг ярь гээд байхад чи хүний эмзэг мэдээлэл гаргасан байна гэж ингэж үзвэл бид нар хариуцлага хүлээхэд бэлэн. Бид нар хариуцлага хүлээхэд бэлэн.

Цагдаагийн алба хаагчтай холбоотой гэмт хэргийг Авлигатай тэмцэх газар шалгаж байгаа. Өнөөдөр надад ирсэн энэ хэрэг дээр хэдэн цагдаагийн байгууллагын ажилтныг яллагдчихаад татагдчихаад байгаа юм бэ гэдэг надад ирсэн мэдээлэл алга байна. Энэ бол мөрдөн шалгах ажиллагааны нууц. Тийм учраас бидэнд ямар алба хаагч нар шалгагдаж байгаа, ямар алба хаагч яллагдагчаар татагдсан бэ гэдэг мэдээлэл бол байхгүй. Үүний дараа бол бид нар бас үүнийгээ үзнэ. Энэ алба хаагчдын буруутай үйл ажиллагаа байгаа юм уу, эсвэл энэ нэгжийнх нь дарга нар энэ алба хаагчдаа тавих хяналт нь сул байсан юм уу, эсвэл яг түрүүний хэлж байсан тэр камерын өнцөг өөрчилсөн юм уу, тэгж байгаад ингэсэн юм уу гээд энэ мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон нөхцөлд бид нар дараагийн арга хэмжээ авах ийм эрх зүйн зохицуулалттай. Тэрийг бол одоо шалгаж тогтоосны дараа хэлэх байх. Би бол ёс зүйн хариуцлага хүлээхэд бол бэлэн. Асуудалгүй. Танай алба хаагч чинь буруутай байна. Танай алба хаагчид хүн ингээд зодсоор байгаад алсан байна. Таныг.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Микрофоныг нээгээрэй. Болчихсон уу. Хууль зүйн сайд.

О.Алтангэрэл: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Яг нөгөө зааг ялгаатай бид нар бас ойлгох ёстой болчихоод байгаа. Энэ цагдаагийн алба хаагчдын бусдыг эрүүдэн шүүсэн байж болзошгүй асуудал гарах асуудал Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байна. Эндээс Авлигатай тэмцэх газар шалгагдаж байгаа энэ хэргээс гэм буруутай нь тогтоогдвол цагдаагийн албан хаагчид бусдыг эрүүдэн шүүсэн байж болзошгүй асуудалтай холбоотой

хууль зүйн хариуцлага нь нэг яригдана. Нөгөө талаар энэ заавал юу гэдэг юм Мөрдөн шалгах байгууллага болоод шүүхийн шийдвэрийг хүлээхгүйгээр бид нар өөрсдөө дотооддоо үнэлэлт дүгнэлт өгөх бололцоотой ийм асуудлууд гэж байгаа. Энэ дундаас бол түрүүн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, зарим үйл ажиллагаатай холбоотой болон энэ хохирогчийн хувийн эмзэг мэдээллийг задруулсан гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр энэ дээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд буруутай албан тушаалтнуудтай хариуцлага тооцно. Дахиад мөн энэ тал дээр хариуцлага хүлээх шаардлагатай албан тушаалтнуудад Цагдаагийн ерөнхий газрын дарга өөрийнхөө эрх хэмжээнд хариуцлага хүлээлгэх асуудлаа шийдвэрлэнэ.

Х.Тэмүүжин: 3 дахь асуултын хариултыг хэн өгөх байлаа. Хууль зүйн сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Энэ сэтгүүлч Өнөрцэцэгтэй холбоотой шийдсэн хэргийн талаар бас харьцуулж асуудал хөндөж байх шиг байна. Тэгээд тухайн хэрэг маань хаалттай явагдсан учраас мэдээлэл хомс байна. Тэгэхдээ эрэн сурвалжлагдаж байгаа болон нийгэмд аюул учруулж болзошгүй этгээдүүдийн талаар төр өөрөө олж мэдсэн буюу цагдаагийн байгууллага өөрийнхөө үйл ажиллагааны хүрээнд өөртөө байгаа мэдээллээ олон нийтэд түгээж, энэ мэдээллийг задруулахад ямарваа нэг хуулийн хариуцлага хүлээхгүй гэдэг зарчим барьж байгаа. Хэрвээ энэ зарчим сэтгүүлчид өөрөөр үйлчилсэн бол энэ хууль хэрэглээний асуудал дээр асуудалтай байна гэж үзэ, бид нар дахиад энэ чиглэлийн хууль тогтоомжоо эргээж харах ийм шаардлага үүссэн байна гэж үзэх юм. Тэгээд ер нь энэ хохирогчтой холбоотой асуудал дээр бол нэн ялангуяа амь хохирогчтой холбоотой.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Нандинболор 4 дүгээр микрофон.

Б.Нандинболор: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Нандинболор. Би бас түрүүнд 2, 3 кэйс ярьсан нь бол яг таны асууж байгаатай адил бүр огт ухаангүй биш. Зүгээр тийм байдлаар оргох гэмт хэрэг үйлдэж байсан учраас урьдчилан сэргийлэх байдлаар тусгай хэрэгслийг хэрэглэдэг. Тусгай хэрэгслийг бол тухайн үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагч өөрөө иүүд бие даан шийдвэр гаргадаг. Тэгээд яг таны хэлж байгаа асуусан асуултад бол тийм кэйс одоогоор бол байхгүй байгаа. Байхгүй ээ. Хүний ёсонд нийцэхгүй. Хүн ёсны хувьд бид нар хэдий хуулийг хэрэгжүүлж байгаа ч гэсэн амьдралд бас өөрөө хүн ёсны жам ёстойгоо уялдаж явдаг. Бид хүнлэг энэрэнгүй байх ёстой гэдэг энэ зарчмыг баримтлах ёстой. Тэгээд энэ дээр бол би бас тухайн байгууллагын ар гэрээс бид уучлал хүссэн байгаа. Гишүүн ээ илтгэж дууслаа.

Х.Тэмүүжин: Улсын Их Хурлын гишүүн Шижир.

Ө.Шижир: Маш харамсалтай хэрэг гарлаа. Нэг биш сүүлийн хэдэн жилийн хугацаанд нэлээн хэдэн удаа ШШГБ-ын хорих ангиудад. Энэ өнөөдөр ярьж байгаа нэг сэдэв биш. Тодорхой хэсэг хугацааны өмнөөс энэ хэргүүд, энэ асуудлууд яригдаж л байсан. Энэ асуудал өнөөдөр бол шийдэгдээгүй байна. Монгол Улсад ХЭҮК гээд маш том хэмжээний өөрийн бүтэцтэй, хуультай, тусгай чиг үүрэгтэй ийм бүтэц байдаг. Гэтэл өнөөдөр ганц энэ хэрэг дээр биш өөр бусад хэргүүд дээр ХЭҮК ямар чиглэл, үйл ажиллагаа явуулж байгаа вэ гэдгийг комиссын гишүүдээс асууя. 1 мэдэгдэл гаргаад өнгөрдөг байж болмооргүй байгаа юм. Бас яг ний нуугүй хэлэхэд энд ирсэн хүмүүс маань нэг их онц сурдаг хүүхдүүд шиг асуултын хаанаас нь ч тэр хуулийн тэд, энэ хуулийн тэд гээд бүгд

буруугүй мэт тиймэрхүү асуултууд сая хаалттай, нээлттэй аль аль дээр нь яригдлаа. Ийм байж боломгүй байгаа юм. Бодит байдал дээрээ бид нар хүний эрх ямар байгааг мэдэж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргаж байгаа олон улсын дүгнэлтүүд дээр Монголд байгаа хүний эрхийн зөрчил бол арилаагүй шүү дээ. Тэрийг та бүгд бүгдээрээ мэдэж байгаа. Арилаагүйн хамгийн тод жишээ бол энэ хэрэг. Үүнээс өмнөх хэргүүд. Амь хохирогч, сэжигтэн, ялагдагч хэн байлаа ч гэсэн тэдний эрх чөлөөг хязгаарласан үед эрх бүхий байгууллагууд амьд явах эрх нь баталгаажуулах үүрэгтэй.

Энэ Монгол Улсын Үндсэн хуульд ч байгаа. Хүний эрхийн нэгдсэн үндэсний түгээмэл тунхаглагдаж байгаа. Тэгэхээр энэ тал дээр ШШГЕГ маань ямар чиг үүрэгтэй ажиллаж байна вэ. Тиймээс нэг хэд хэдэн асуулт асууя. Голцуухан урьдчилан сэргийлэх маягтай. Монгол Улсад өнөөдөр өдөр тутам хүний эрх зөрчигдөж байгаа. Эдгээр дээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх анги гэлтгүйгээр нийтэд улс даяар ямар ямар хөтөлбөр хэрэгжүүлж байгаа вэ. Хэдий хэмжээний төсөвтэй, ямар үр дүнтэй. Мөн саяын харамсалтай хэрэг гарсантай холбоотойгоор ер нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх харьяа ангиудад байгаа хүний эрхийг хангуулах дээр урьдчилсан ямар ажлууд хийсэн бэ. Сургалт биш шүү.

Гуравдугаарх нь түрүүн та яриан дундуураа 2022 оноос хойш хөтөлбөр батлуулах гэж байгаа гээд дурдчих шиг болсон. Таны микрофон сайн сонсогдоогүй. 2 жил энэ хөтөлбөрийг батлуулж чадаагүй бодит шалтгаан чинь юу юм бэ. Сая хаалттай хуралдаан дээр бас Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга маань цаашид урьдчилан сэргийлэх талаар мөн хүний эрхийг ингэж хангуулах талаар, мөн зарим хуулийн чиг үүрэг бүхий байгууллагуудтай хэрхэн ажиллах талаар тодорхой хариулт өгсөнгүй.

Харамсалтай нь. Мөн танай комисст танай хуульд заасан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа гээд бүхэл бүтэн 7 дугаар бүлэг байна. Тийм болохоор сая Мөнхбаясгалан гишүүнтэй давхцаж асууя. Гавтайгаа эмнэлгийн орон дээр нас барсан хохирогчийг та эрүүдэн шүүсэн гэж үзэж байгаа юу. Тийм бол ямар хариуцлага хүлээх вэ хүлээлгэх вэ.

Хүний эрхийн Үндэсний Комисс болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа болон бусад байгууллагууд хуулийн хүрээнд энэ үйл ажиллагаанд оролцсон хүмүүст ямар хариуцлагууд хүлээх вэ. Энэ дээр тодорхой хариулт өгөөрэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудад хүний эрхтэй холбоотой хэчнээн зөрчил 2024 он гарснаас хойш гарсан, тэрийг хэрхэн хангуулсан тухай Шүүхийн шийдвэрийн ерөнхий газраас асууя. Хуралдаан даргалагчаа 1 минутаа авчихъя.

Х.Тэмүүжин: Нэмэлт 1 минут.

Ө.Шижир: Бид бас нэг удаагийн асуудал гэж хандаад ингээд өнгөрөөд байж боломгүй байгаа юм. Энэ чинь ингээд яагаад гэвэл нэг биш удаа давтагдаад байна шүү дээ. Бид нарт анх удаагаа болж байгаа үйл явдал биш. Тэгэхээр ер нь цаашид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, мөн Хүний эрхийн Үндэсний Комисс, мөн бусад хуулийн тусгай чиг үүргийн байгууллагууд хүний эрх хэрэгжүүлэх тал дээр хэрхэн ямар төлөвлөгөөтэй, хэдэн жилийн хөтөлбөртэй ажиллаж байгаагаа та бүхэн минь одоо энэ нээлттэй хуралдаан дээр тайлбарлаж өгөөч. Тэгээд асуултдаа маш тодорхой хариултууд авмаар байна. Тэгэхгүй бол нэг ийм ерөнхий ерөнхий хариултууд өгөөд, аль ч хүн, аль ч байгууллага буруугүй мэт амь хохирогч хүний эрхийг зөрчүүлж байгаа хүмүүс өөрсдөөсөө болсон мэт тийм

асуудлууд нийгэмд түгээд байна. Энэ нь өөрсдөө ямар учиртай вэ гэхээр та хэдийн үйл ажиллагаанд цаашид улам сөргөөр нөлөөлөх учраас энэ тал дээр тодорхой хариултууд өгөөч.

Х.Тэмүүжин: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ихэнх асуулт нь явчихлаа. Хүний эрхийн Үндэсний Комисс дараа нь тайлбар хэлнэ биз. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага. 5 номер.

А.Намсанманд: Шижир гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга, хурандаа Намсанманд. Хүний эрхийг ялангуяа хоригдогч хоригдлын эрхийг хангах чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага сүүлийн жилүүдэд шат дараалсан үйл ажиллагаануудыг бол бас авч хэрэгжүүлж байгаа. Сургалт биш шүү гэсэн. Тухайлбал энэ алба хаагчдын үйл ажиллагааны стандарт гэж байна. Алба хаагч нэг бүрийн ажлын байрны тодорхойлолт дээр хоригдол, хоригдогчийн эрхийг хангах чиглэлээр хэдийгээр тэр хүн түр хугацаагаар зорчих эрхээ гэдэг юм уу, бусад эрхээ хязгаарлуулсан хоригдож байгаа ч гэсэн тэр хүний чинь жам ёсны эрх гэж байна. Тэр жам ёсны эрхийг хангах чиглэлээр та нөхөд ийм ийм ажил үйлчилгээнд бол анхаарч ажиллана шүү гэдгийг нарийвчилсан зохицуулалт журмуудаараа зохион байгуулчихсан байж байгаа. Зохион байгуулчихсан. Мэдээж сургалтыг бол жил болгон, тухай бүр, улирал бүр гэдэг юм уу ерөнхий газрын даргын баталсан тушаалаар зохион байгуулж, бүсчилсэн хэлбэрээр, магадгүй бүлгийн хэлбэрээр зохион байгуулж ажилладаг. Мэргэжил бүр дээр. Одоо хорих ангид ажиллаж байгаа, хоригдол, хоригдогчтой ажиллаж байгаа. Түрүүн дурдагдсан эмнэлгийн байгууллагын ажилтан ч гэдэг юм уу, харуул хамгаалалтын. Хариулж дууслаа.

Х.Тэмүүжин: Их товч хариуллаа. Нэлээн хэдэн асуултууд байсан. Ер нь бол наад асуултуудаа текстээр бичээд, дараагийн хурал дээр бүр асуулга маягаар авчихъя. Хүний эрхийн Үндэсний Комисс. 1 номерын микрофон.

Д.Сүнжид: Шижир гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт чиг үүргийн хувьд хууль сахиулах болон цэргийн байгууллагууд байна. Дотоодын цэргийн байгууллага, цэргийн байгууллагууд. Үүнтэй холбоотой хүний эрхийн зөрчлүүд байгаа үнэн. Үндсэн хуульд зааснаар халдашгүй байх эрх ялангуяа хаана зөрчигддөг вэ гэхээр яг таны дурддаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих анги, цагдан хорих анги, цагдан хорих байр, 461 энэ цагдаагийн албан хаагчдаас хэлтсээс гээд. Тэгээд зэвсэгт хүчний албан хаагч, төрийн цэргийн байгууллагуудаас буюу эрх чөлөө нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал тушаал, дүрэм, журмыг сахих ёстой энэ газрууд бас зөрчигдөх магадлал байдаг. Зөрчигдсөөр байгаа учраас энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс өөрийнхөө стратеги төлөвлөгөөний нэг тэргүүлэх чиглэл болгож яг энэ халдашгүй байх эрх чөлөө, ялангуяа ийм тодорхой хязгаарлагдмал нөхцөлтэй байдаг энэ хүмүүсийн эрхийг хянана, шалгана, зөрчлийг таслан зогсооно, урьдчилан сэргийлнэ, дагалдах үр дагавар, хариуцлагыг хүлээнэ гэдгийг стратегийнхаа тэргүүлэх нэг чиглэл болгож, 2020 онд бол баталсан.

2-т нь бид нар энэ хорих ангиудад болон цагдан хорих байранд хяналт шалгалтыг тогтмол хийж байгаа юм. Гомдол мэдээллээс үл хамаараад. Төрийн цэргийн байгууллагуудаар мөн адилхан хамгийн их бас өмнө нь Баярмаа гишүүн асууж байсан. Хамгийн их хяналт шалгалт зохион байгуулдаг газар хаана вэ гэвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хорих ангиуд байдаг. 461 энэ цагдан хорих төв байдаг. Тэгээд аймгуудад байгаа цагдан хорих байруудад бас бид нар хяналт шалгалтыг

бол байнга зохион байгуулдаг. Жилдээ бид нар энэ дээр бол дунджаар 30 ийм хорих анги, цагдан хорих байруудад хяналт шалгалтыг бол тогтмол хийж байгаа. Тэрний мөрөөр хэрвээ зөрчил илэрвэл бид нар шууд шаардлага явуулдаг. Байж болзошгүй байна гэвэл бид нар зөвлөмж хүргүүлдэг. Олон нийтэд хүргүүлэх тал дээр бид нар бас дутуу мэдээлэл өгсөн байж магадгүй. Тийм учраас энэ мэдээллийг бас сайжруулах ёстой юм байна гэдэг дүгнэлтийг бол хийж байна. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр дээ буруу түрүүн ойлгуулсан юм шиг байна. Уучлаарай. Энэ Улсын Их Хурлаас баталсан хөтөлбөр юм байгаа юм. 2003 оны. Энэ дээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хяналт шинжилгээ бас хийсэн. Энд бид нар Монгол Улсын хүний эрхийг хангах тогтолцоо, шүүх, прокурор, нутгийн удирдлага, төрийн захиргааны байгууллага, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын Их Хурал өөрөө хэн нь ямар ажлыг хариуцсан, одоо тэгээд юу дутуу байна бид нар аль түвшинд хүрэв гээд хийсэн. Ингээд шинээр 2 дахь хөтөлбөр гэдгийг батлах нь зөв юм байна. Бид нар хүрсэн нь ахиц амжилт гэж байгаа бол тэрийгээ дүгнэе. Ухралт гэж байгаа бол тэрийгээ дүгнэе. Зөрчлийг таслан зогсоож цаашидаа яах юм бэ гэдэг урт, дунд, богино хугацааныхаа бодлогыг нэгтгэе улсын хэмжээнд гээд ийм байдлаар Хүний эрхийн Үндэсний Комисс бол төслийг нь Засгийн газарт хүргүүлсэн. Одоо энэ төсөл цаашаа бас Засгийн газраар дамжаад, Улсын Их Хурлаар 2 дахь хөтөлбөр болж хэрэгжих учиртай байгаа. Бид нар иргэний нийгмийн зөвлөлийнхнийхөө саналыг авсан. Иргэний нийгмийн активистууд, шинжээчид, судлаачид, хүний эрхийн талаар санаа зовниж байгаа төрийн, төрийн бус байгууллагын, олон улсын байгууллагын бүх энэ экспертүүдийг оролцуулаад өргөн хүрээнд бид нар энэ 2 дахь хөтөлбөрийн төслийг гаргахыг бол хичээж өргөн.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Хугацааг нэмээд өгчихье.

Я.Цэлмэн: Цэлмэн. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн. Шижир гишүүний асуултад хариулъя. Монгол Улсад эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа байгуулагдах болсон үндсэн нөхцөл бол Эрүү шүүлтийн эсрэг конвенц, түүний нэмэлт протоколд Монгол Улс нэгдэж орсонтой холбоотой. Зайлигүй үндэсний байгууллага байгуулах ёстой. Өнөөдөр Хүний эрхийн Комиссын дэргэд байгуулагдсан. Гэхдээ хариуцсан гишүүн нь бол энэ асуудлаар дотоод, гадаадад төлөөлж, холбогдох санал хүргүүлж тайлан гаргах ийм үүрэгтэй. Ингээд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хүрээнд э эрүү шүүлтээс хохирч байгаа иргэдийн талаарх мэдээллийг бол тухай бүр 2 жилийнхээ тайланд бол тусгаж танилцуулсан. Бид мөн холбогдох албан тушаалтнуудад 35 удаагийн зөвлөмжийг энэ 2 жилийн хугацаанд хүргүүлсэн. Энэ 35 удаагийн зөвлөмжийг зайлигүй биелүүлэх шаардлагатай ийм хууль, эрх зүйн зохицуулалттай. Биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах, байгууллагын үйл ажиллагааг түдгэлзүүлэх санал хүргүүлэх эрхийнхээ дагуу бол хүргүүлж ажилласан зүйлүүд байгаа. Ер нь бол бид анх үйл ажиллагаагаа эхлэхэд зөвхөн бидний чиглэлээр 6 удаа өргөдөл, гомдол, эрүүдэн шүүгдсэн, хүнлэг бус харьцсан гэдэг дээр ирж байсан бол өнгөрсөн жил 66 удаагийн албан тушаалтантай холбоотой гомдол, мэдээлэл ирснийг холбогдох байгууллага албан тушаалтанд шалгуулахаар шилжүүлсэн.

Энэ дээр хамгийн гол асуудал бол миний дахин дахин яриад байдаг асуудал бол энэ эрүү шүүлт болон хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхалтыг бие даан шалгах ийм мөрдөн байцаах албаны бүтцийг бол тусад нь байгуулах шаардлагатай. Ер нь энэ прокурорын дэргэдэх мөрдөн байцаах хэлбэрээр бол

биш. Аль нэг байгууллагын дэргэд бол биш. Жинхэнэ хараат бус байдлаар нь яаж томилох ёстой юм тэрийг байгуулах, ёстой. Байгуулах ёстой асуудлыг судалж Засгийн газрын хуралдаанд танилцуулах гэснийг бол өмнөх Хууль зүйн сайдад үүрэг болгосон байсан. Их Хурлын тогтоолоор. Харамсалтай нь бүрэн эрхийн хугацаанд танилцуулаагүй байгаа асуудал бий. Дээрээс нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийн Эрүүгийн хуульд заасан ойлголтын асуудлыг бол өөрчлөх, ямар асуудлыг эрүү шүүлт гэх юм, ямрыг нь хүнлэг бус харьцаа гэх юм, алийг нь доромжилсон харилцаа гэж шийдэх вэ гэдэг дээр бол тодорхой эрх зүйн зохицуулалт хийх ёстой гэдгийг бол мөн Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлсэн. Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд бол зөвлөмжид бас 2 жил дараалаад орсон байгаа. Тэгэхээр хуульд бид бол зөвхөн санал хүргүүлнэ. Шийдвэрлэх эрх нь бол та бүхэнд байгаа учраас даруй одоо шийдвэрлэж өгөхийг хүсье.

Дээрээс нь бид тайлангаа гаргаад бас мөн олон улсад бас хүргэдэг байгаа. Үүнтэй холбогдуулаад өнгөрсөн 6 сард НҮБ-ын Эрүүдэн шүүхийн дэд хороо ирж ажилласан. Удахгүй Засгийн газарт зөвлөмж нь ирнэ. Мөн одоо Эрүүдэн шүүхийн нийгэмлэг энэ 9 сард ирж Монгол Улсад ажиллана. Энэ нь гэхдээ бүх хууль сахиулах байгууллагуудтай холбоотой сургалт, бусад зүйлийг хийхээр ирж байгаа. Тэгэхээр бид бол эрүү шүүлтгүй Монголын төлөө гэсэн ийм зорилтыг 2 жилийн өмнө дэвшүүлсэн. Ингээд 3, 3 жилээр алсын хараагаа төлөвлөөд хурлаа батлуулаад ажиллаж байна. Хариулж дууслаа.

Х.Тэмүүжин: Нэмэлт минут. 1 номерын микрофон.

Я.Цэлмэн: Шижир гишүүний асуултад хариулъя. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа өнөөдөр 5 албан хаагчийн

бүрэлдэхүүнтэй. Эхний жил 2022-2023 онд бид нар алба хаагчдын цалингаас гадна 160 сая төгрөгийн төсөвтэй ажилласан. Энэ жил алба хаагчдын цалингаас гадна 200 гаруй сая төгрөгийн төсөвтэй ажиллаж байгаа. Ингээд бидний ажиллах хүрээ бол үндсэндээ түрүүн бас та байхгүй байх шиг байна лээ. Танилцуулсан байгаа. Нийтдээ бол Монгол Улсын хэмжээнд 400 гаруй объект нь 21 аймагт байгаа. Түүн дотроо байнгын болон ямар нэгэн хугацаагаар эрхээ хязгаарлуулж байгаа иргэд бол 140 орчим мянга байна гэдэг албан тоог гаргаж танилцуулсан. Энэ хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа. Бидний хамгийн хийж чадаж байгаа гол зүйл бол мэдээж хуулийн энэ эрх зүйн зохицуулалт цаашид бол олон улсынхаа гэрээ конвенцод нийцсэн байдлаар өөрчлөгдөх шаардлагатай гэдгийг бол өнгөрсөн хаврын чуулганаар Их Хуралд танилцуулсан. Ингээд өнөөдөр хуулийн төслийн өөрчлөлт бас явж байгаа. Эрүү шүүлт мөн үү гэдэг асуудал. Тэр тухайн асуудлыг бол.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Нэмэлт 1 минут өгчих.

Я.Цэлмэн: Миний яриад байгаа гол зүйл бол энэ Монгол Улсын Эрүүгийн хуульд байгаа 21.12 дугаар зүйлд заасан эрүү шүүлт тулгах гэмт хэргийн ойлголтыг өргөн хүрээгээр нь буюу нэгдэн орсон конвенцынхоо утга агуулгаар нь яг тайлбарлаж өөрчлөх шаардлагатай гэдэг асуудал бол энэ дээр гарч ирж байгаа. Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл дээр бол тайлбар мэдүүлэг авах зорилгоор тодорхой зорилго байгаа. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн ойлголт бүрэлдэхүүн. Тэгэхээр энэ дээр хэрвээ эрүү шүүлтээр зүйлчилж тухайн хүнийг шалгая гэх юм бол тайлбар мэдүүлэг авсан уу, үгүй юү гэдэг дээр зорилгыг эхлээд тодорхойлох хэрэгтэй болж байгаа. Энэ дээр нэмэлт бүрэлдэхүүн шаардлагатай. Ялангуяа энэ нотлох баримтыг цуглуулахдаа эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бол 20 гаруй төрлийн буюу прокурорын зөвшөөрөлтэй явуулах, зөвшөөрөлгүй явуулах энэ арга хэрэгслүүдийг хуульчлаад өгчихсөн. Энэ болгон дээр эрүү шүүлт гарч болзошгүй юм гэдгийг бол өнгөрсөн 2023 оны хаврын чуулганаар танилцуулж, энэ дээр өөрчлөлт оруулах нь зүйтэй гэдгийг бол Их Хурлаас бол 35 дугаар тогтоолоор баталсан байгаа. Энэ бол ойлголтын хүрээний зөрүүний асуудал ийм байгаа. Харин иргэд.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Болсон. Дараа нь Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Аль болохоор товчхон ярья.

1.Бид нар бол шүүх хурал хийгээгүй, бас хэн нэгний гэм буруутайг тогтоохыг хичээгээгүй. Гагцхүү хүний амь нас эрсэдсэн энэ кэйс дээр тулгуурлаад ер нь энэ Монгол Улсад хүний эрхийн байдал ямар нөхцөл байдалд байгаа, асуудал ямар байгаа гэдгийг тодорхойд нь олон нийтэд нээлттэйгээр гаргах, цаашид эндээс шинэчлэлийн хувьд ямар ямар алхмууд яаралтай хийх ёстой юм. Энэ төрлийн зөрчлийг давтан гаргахгүй хүний амь насыг дахин хохироохгүй байх ямар боломжууд байна гээд ингээд асуудлыг өргөн хүрээнд харах маш том шинэчлэлийн эхний хурал явж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээ түрүүн Жудагийн Баярмаа гишүүн асуугаад хариултыг нь бүтэн бас авсангүй л дээ. Жишээлбэл энэ Жаргалбаатар гээд АТГ-ын ажилтан бол камер ажиллахгүй байсан. Камерын өнцөг өөрчилсөн гээд асар ноцтой юм яриад байгаа байхгүй юу. Энэ чинь эрх бүхий албан тушаал шүү дээ. Өнөөдөр бид нар энд 5 байгууллагын 18 субъект асуулга мэдээлэл авахад оролцож байгаа. Камерын өнцөг яагаад өөрчилсөн бэ гээд том асуудал. Тэгэнгүүт Цэлмэг гээд Хүний эрхийн комиссоос байгаа хүн юу гэж байна гэхээрээ тэр дүгнэлт дээр нь бас энэ нь хүний эрхийг ноцтойгоор

зөрчих магадлал бүхий орчин байсан гэж ингээд дүгнэлтдээ хэлээд байдаг. Тэгэнгүүт Сүхболд хурандаа Цагдаагийн ерөнхий газрын дарга юу гэж хэлээд байна гэхээр 266 камертай өрөө байх ёстой. Технологийн боломжоос 253 нь ажиллаж байгаа. Явж явж нөгөө эдийн засгийн боломж өрөөний хүрэлцээнээс болоод мэдүүлэг авч байгаа хүн өөрийнхөө өрөөнд ингэж хийж байгаа. Тэгэхдээ 2 гэрч байлцуулна гээд. Явсаар байгаад энэ чинь 3 байгууллагын ярьж байгаа зүйлүүд нь хоорондоо том зөрөөд байна шүү дээ. Зөрөөд байна шүү дээ. Гэхдээ энийг чинь хэн нь зөв бурууг нь тогтооно гэдэг чинь ингээд дараагийн асуудал болчихож байгаа юм.

Тэгэхээр эндээс үүдээд Хууль зүйн сайдаас асуулт асууя. Ер нь шинэ Засгийн газар байгуулагдаад, та Хууль зүй, дотоод хэргийн яам гэдэг маш том бүтэц, шударга ёсыг сахиулах, хүний эрхийг хангах, хуулийг хэрэгжүүлэх маш том итгэл найдварыг хүлээж байгаа. Тэгэхээр түрүүн таны яриа дээрээс сонсож байхад Цагдаагийн ерөнхий газрын хяналт шалгалтын дотоод хяналт шалгалтын дэд даргад хариуцлага тооцож байгаа гэсэн ийм мэдээлэл авлаа. Энэ бол байгууллагуудын хоорондын уялдаа холбооны асуудал, хүний эрхийн мэдрэмжийн асуудал гээд маш олон зүйлүүд өнөөдөр энд яригдаж байгаа. Тэгэхээр энэ дээр хууль зүйн салбарын реформ гэхээс илүүтэйгээр ер нь цагдаагийн шинэчлэлийг яаж хийх вэ. Яагаад гэхлээр өмнө нь Сүхбаатарын талбай дээр өөрийгөө шатаасан хүнийг орой нь мэдээ гарангуут наад чинь ер нь бол үл бүтэх хүн байсан юм гэдэг мэдээ гарсан. Маш олон кэйс дээр ЦЕГ-аас мэдээлдэг мэдээлэл нь дандаа ингээд нөгөө хохирсон хүнийг ч гэдэг юм уу, тухайн хүнийг буруутгах өнцөг гаргахуйц нөхцөл байдал үүсгээд байдаг. Эндээс нь болоод нөгөө нийгэм 2, 3 хуваагддаг. Үзэн ядалтууд явагддаг. Тэгээд хэн нэгэн хүнийг гэм буруутай нь тогтоогдоогүй байхад социал медиагаар ялчихдаг. Тэгээд тэр уур амьсгалыг дагаж хууль

хүчний байгууллагууд шийдвэр гаргах магадлал асар өндөртэй болчихдог. Нөгөө хууль хэлбэрэлтгүй хэрэгжих, дабл стандартгүй байх ялгамжгүй үйлчлэх юм нь алдагдах гээд байдаг. Ингээд Алтангэрэл сайдаас асуухад цагдаагийн шинэчлэл гэж энэ реформыг та ер нь яаж хийх юм бэ. Одоо энэ кэйс дээр.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Нэмэлт 1 минут.

С.Эрдэнэболд: Энэ кэйс дээр мэдээж бид нар дүгнэхэд эрт байгаа. Яагаад гэхээр шүүх эмнэлгийн дүгнэлт энэ тэр гээд маш олон зүйлүүд хүлээгдэж байгаа. Тэгэхээр маш олон зүйлүүд тодорхойгүй байхад бид нар ингээд нийгмийн сэтгэл зүйг дагаж ямар нэгэн байдлаар туйлширч болохгүй байгаа. Яагаад гэхээр бид нар чинь нөгөө хууль тогтоох субъект Улсын Их Хурлын бүрэн эрхийнхээ дагуу холбогдох байгууллагуудаас тодруулга авч байгаа учраас бид нар шүүхийн процесс, хэрэг мөрдөн шалгах процесст оролцох боломжгүй учраас бид нар мэдээлэл сонсголыг л авч байгаа юм. Мэдээллийг авч байгаа. Тэгэхээр Алтангэрэл сайд яг энэ салбарыг тэргүүлж байгаа хүний хувьд яг энэ цагдаагийн шинэчлэл гэдгийг яаж хийх юм бэ. Энийг маш олон хүмүүс хүлээж байгаа. 1 ажилтан албан тушаалтныг халснаар шинэчлэл хийгдэхгүй. Тогтолцооны хувьд ер нь энэ цагдааг хүний эрхийн мэдрэмжтэй, хүний эрхийг хамгаалдаг байлгахын төлөө та ер нь ямар бодлогын зорилтыг дэвшүүлж ажиллах юм бэ.

Х.Тэмүүжин: Хууль зүй, дотоод хэргийн сайд.

О.Алтангэрэл: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн байгууллага дан ганц цагдаагийн байгууллага гээд хууль сахиулах байгууллагын тогтолцооны шинэчлэл зайлшгүй яригдана. Тэгээд шинэчилнэ гэхээр одоо дарга удирдлагуудыг нь хэнээр тавих вэ, солих вэ гэдэг

асуудалтай биш, тогтолцоо талаас нь ярьж байгаа юм. Энэ дээр бол 3 үндсэн асуудлыг авч үзэж байгаа юм.

Хамгийн 1 дүгээрт хүний эрхийн асуудал. Хүний эрхийн асуудал, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа нь яаж хөндөгдөж байгаа юм бэ. Хууль сахиулах байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, журам, стандарт, энэ үйл ажиллагаа нь хүний эрхийн асуудал яаж хөндөгдөж байна вэ гэдэг дээр бид нар асуудал тавина. Тэгээд хүний эрхийн зөрчил байна гэж үзвэл, хуулийн зөрчил байна гэж үзвэл дараагийн том асуудал энэ дотоод хяналт шалгалтын асуудал. Дотоод хяналт шалгалтын асуудал дээр бол өнөөдөр яг аваад үзэхээр Хууль зүйн яам өөрөө энэ хяналт шинжилгээ үнэлгээний нэгжтэй. Тэгээд харьяа агентлаг байгууллагууд өөрсдөө энэ дотоод аюулгүй байдал хяналт шалгалтын нэгжтэй. Тэгээд яамныхаа болон салбарынхаа бодлоготой уялдах уялдаа холбоо муу. Байгууллагуудын дотоод хяналт шалгалтын нэгжүүд өөрсдийнхөө удирдлагаас хамааралгүйгээр энэ холбогдох эрх бүхий албан тушаалтан тухайлах юм бол салбарынхаа сайдад, яамдад энэ мэдээ тайлангаа өгдөг, цаашаагаа арга хэмжээгээ төлөвлөдөг энэ тогтолцоо сул байна. Тэгэхээр энэ хяналт шалгалтын тогтолцоог тэр чигт нь бол шинэчилнэ гэсэн ийм зорилготой байна. Энэ хяналт шалгалтын асуудал ороод ирэхээр үүнийг дагалдаад дандаа хариуцлагын асуудал ярьдаг. Өнгөрсөн жилүүдэд энэ олон нийтийн анхааралд хүрсэн хүн хэн хариуцлага хүлээсэн эсэх нь тодорхойгүй олон кэйсүүд байгаа. Яг судлаад үзэхээр зарим нэг нь ял шийтгэгдчихсэн, хариуцлага хүлээчихсэн ийм зүйлүүд байна. Энэ талаар бол олон нийт мэддэггүй. Тэгэхээр энэ асуудал бол юунаас болж байна вэ гэхээр хариуцлагын тогтолцоо нь өөрөө энэ хяналттайгаа тасралтгүй уялдаатай юм байна. Тийм учраас хууль сахиулах байгууллагууд нэн ялангуяа цагдаагийн байгууллагын энэ дотоод хяналтыг шинэ

түвшинд гаргах, хяналтын хүрээнд илэрсэн зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол ойлгомжстой энэ харьяалах байгууллага руу нь илжчихнэ. Энэ илэрсэн зөрчил дээр хариуцлага тооцох гэдэг асуудлыг хэвшүүлж чадах юм бол бид нар дараа нь аливаа нэг зөрчил ийм асуудал үүсэхэд хэн нэг албан тушаалтны тухай яриад суух биш тэр албан тушаалтан өөрөө автоматаар хариуцлагаа хүлээгээд ингээд явчихдаг, асуудлыг цаашаа яаж шийдвэрлэх вэ гэдэг том арга замаа бид нар яриад явна.

Тэр мэдээлэл хийх журамтай холбоотой асуудал бол их олон асуудлуудын хүний зөвхөн эмзэг мэдээлэл төдийгүй олон асуудлуудын нийлбэр цогц байгаа юм. Жишээлэх юм бол мэдээлэл хийгээд бусдыг гэмт хэрэг үйлдсэн сэжиглэж байгаа үндэслэлийн талаар ард нийтээрээ итгэхүйц ийм ойлголтыг өгдөг. Тухайн.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Нэмэлт минут.

О.Алтангэрэл: Тэгээд үүний дараа тухайн сэжиглэгдэн шалгагдаж байсан хэрэг нь хэрэгсэхгүй болсны дараагаар олон нийтэд хандсан тухайн хүний өөрийн нэр хүнд болоод ажил хэргийн нэр хүндэд халдсан тэр гэм хохирол арилдаггүй ийм байдал байна. Тэгэхээр бид нар энэ олон нийтэд мэдээлэл өгөх журмыг тал талаасаа олон газрын саналтайгаа боловсруулах нь зөв гэж үзэж байгаа. Үүн дээр бол Хүний эрхийн Үндэсний Комисс, тэгээд олон нийтийн төлөөлөл олон хүнээс бид нар санал авна. Ингээд энэ журмыг боловсруулна. Энэ журам маань зөвхөн энэ хохирогчийн эмзэг мэдээлэлтэй холбоотой төдийгүй хувь хүний болон мөрдөн шалгаж байгаа энэ хэрэгт буруутгагдаад хохироод үлддэг олон хохирогчтой холбоотой нийгэмд түрүүнд нь олон тохиолдол үүссэн эргэж харах ёстой том асуудал болчихсон байсан гэдгийг хэлье.

Х.Тэмүүжин: Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Одоо бид нар бол маш харамсалтай хэрэг дээр тулгуурлаж өнөөдрийн энэ хэлэлцүүлэг хийгдэж байна. Тэгээд эндээс түрүүнийхээ асуултыг л би дахиад л бас тодруулъя. Ерөөсөө тодорхой хэлэхгүй байна. Камер заавал ажиллах ёстой тийм ээ. Заавал ажиллах ёстой. Тэгвэл хэрвээ эвдэрвэл яаралтай засах ёстой. Дээшээ мэдээлдэг юм бол. Ер нь энэ кэйсээс өөр хэдэн удаагийн камер эвдэрсэн, зассан тохиолдол байгаа вэ. Энэ камер эвдэрснээс болоод хүний эрхийн маш ноцтой зөрчил гарсан байж болзошгүй талаар бол тодорхой албан тушаалтнууд бол хэллээ шүү дээ. Тэгэхээр үүнээс гадна бас энэ үйл явдал хэчнээн удаа давтагдсан юм бол. Энэ дээр яг нэг бас тоо баримттай нэг хэлээд өгөөч. Тэгээд хэрвээ камер эвдэрсэн юм бол тэр дээр ямар арга хэмжээ авагдсан юм. Тэрийг зассан юм уу эсвэл тэр мөрдөн байцаалтын үйл явцыг дахиж хийсэн юм уу. Энийгээ тайлбарлаад өгөөрэй.

2 дахь нь. Хүний эрхийн комиссынхон хариулаарай энэ дээр. Та нар бол маш их зөвлөмж гаргадаг. Бүх юман дээр очдог. Тэгээд та нарын зөвлөмж буцааж хүргэгдээд, тэрэнд ер нь ямар арга хэмжээ авснаа та нарт мэдээлдэг үү эргээд. Мэдээлдэг бол ер нь зөвлөмж хэдэн хувь биелдэг вэ. Аль салбарт хамгийн их биелдэг вэ. Аль салбарт хамгийн бага биелдэг вэ. Энэ талаар энэ 2 дээр л яг тодорхой хариулт авчихмаар байна.

Х.Тэмүүжин: Түрүүн яг энэтэй холбоотой сэдвээр цагдаагийн байгууллага бараг 3 ч удаа мэдээлэл өгсөн. Цагдаагийн байгууллага бол ямар мэдээлэл өгөөд байна вэ гэхээр мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байгаа мэдүүлэг авч байгаа өрөөнийхөө тухай ихэнхдээ яриад байна. Болсон үйл явдал бол мөрдөн шалгах үйл ажиллагаанаас илүүтэйгээр эрүүгийн төлөөлөгч нартай нь холбоотой тэр хэсэг дээр байна. Ер нь цагдаагийн байгууллага мөрдөн

байцаалтын өрөөнөөс гадуурх камер тэгээд хардалт гэдэг юм уу олон нийтийн шүүмж чинь юу яриад байна вэ гэхээр сая ч гэсэн кэйс дээр тодорхой ярьж байна. Камерын өнцгийг өөрчилдөг эсвэл камергүй хэсэг дээр очиж ийм асуудал гардаг гэдэг юм яригдаад байна. Энэ дээрээ л тайлбар хийчих. Тэр түрүүчийн прокурорын зөвшөөрөлтэй байцаалтын өрөөний тухай битгий яриарай. 2 дугаар микрофон.

Т.Сүхболд: Гишүүний асуултад хариулъя. Цагдаагийн байгууллагад ер нь нийтийн эзэмшлийн камергүй газар байхгүй. Камергүй тийм өрөө тасалгаа ч юм уу тийм юм байхгүй. Та түрүүнд хэлсэн гишүүн буруу ойлгосон байна лээ. Камергүй өрөөнд гэрчтэйгээр мэдүүлэг авна гэсэн байхгүй юу. Камергүй өрөөнд л мэдүүлэг авна гэсэн ойлголт огт байхгүй гэдгийг л та бүхэнд хэлье. Эвдэрч болно зассаны дараа л мэдүүлэг авна. Тийм тохиолдол байхгүй. Камергүй өрөөнд мэдүүлэг авсан тохиолдол байхгүй. Хэрвээ тэр эрүүгийн мөрдөгч нар өөрсдийнхөө өрөөнд оруулаад энэ хүнд эрх чөлөөнд нь халдсан бол тэр хүмүүсийн буруу. Тэр хүмүүс энэ цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм, ёс зүйн дүрэм хууль зөрчсөн байна л гэсэн үг. Тэгснээс бид нарын үйл ажиллагаа бүгд тэр цагдаагийн байгууллагад явагдаж байгаа бүх үйл ажиллагаа камерын доор л явагдах ёстой. Тэгэхээр ерөөсөө камер нь эвдэрлээ бол тийшээ тэр өрөөнд мэдүүлэг авахгүй, камертай өрөөндөө л мэдүүлэг аваад явна. Яах вэ тэр хүрэлцээ гэж яриад байсан тэр прокурорын зөвшөөрөл авсан өрөө байхгүй юу. Өөрөө сууж байгаа. Тэгэхдээ прокурорын зөвшөөрөл авсан камертай өрөө.

Х.Тэмүүжин: Хүний эрхийн Үндэсний Комисс. 1 дүгээр микрофон.

Д.Сүнжид: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Жил болгон хүний эрх чөлөөний төлөв байдлын илтгэлийг Улсын Их Хуралд эхний 3 дугаар сардаа

багтаан илтгэдэг. Түүний ард 1 мэдээлэл дандаа өгч байгаа. Тэр нь хэдэн шаардлага, зөвлөмжийг явуулсан бэ ямар ямар байгууллагад. Үүний хариу биелэгдсэн үү, үгүй юү гэдгийг давхар өгдөг. Өнгөрсөн жилийн байдлаар бол 6 байгууллага биелүүлээгүй гэдэг ийм хариу нь хангалтгүй, тооцох боломжгүй, биелэлтийг эсвэл ирүүлээгүй гэдэг 6 байгууллага байсан. Хууль зүйн байнгын хорооны хурал дээр дуудаж авчраад тухайн 6 байгууллагын удирдлагуудтай хамт ярилцсан. Яагаад биелүүлээгүй вэ. Цаашид энэ талаар биелүүлэх, хуулийг нэг мөр биелүүлэх, Үндсэн хуулийг чандлан сахиж ажиллах талаар Байнгын хорооноос бас сануулсан. Ийм тогтоол гаргасан. Тогтоолдоо заалт болгож оруулсан. Тэгэхээр биелэлтийг тооцохдоо бид нар нэг шаардлага зөвлөмж дээр олон зүйлийг бичдэг. 1 дүгээрт энэ хүний эрхийн зөрчил байна. Энийгээ хариуцлага тооцооч ээ гэж бичнэ. 2-т нь энэ зөрчлөө ингэж таслан зогсоогооч ээ гэж бичнэ. 3 дугаарт дахиад ийм төрлийн зөрчил гаргахгүйн тулд дүрэм, журам, албан хаагчдын тэр мэдлэг хандлага солих ёстой юм уу, сургах ёстой юм уу, нөлөөллийн ажил хийх ёстой юм уу гээд энэ бүхнийг нь хийдэг 1, 2 3, 4 гээд. Тэгэхээр 1 шаардлага, 1 зөвлөмж дотор маш олон заалт агуулгууд ороод явдаг. Тэр бүхнийг дүгнэх юм бол зарим энэ шаардлага зөвлөмжийн биелэлт ерөнхий ирдэг ерөнхий ирдэг. Энэ жилээс эхлээд бид нар давхар дандаа биелэлтийг нь тооцох, яг нэг бүрчлэн заалт бүрээр биелэлтээ ирүүлээч гэдэг ийм байдлаар явуулж байгаа юм.

Х.Тэмүүжин: Нарантуяа-Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Би түрүүн хаалттай хуралдааны үеэр бас нэлээн хэдэн асуултуудыг тавиад, зарим нэгэн асуултад хариулт аваагүй. Тэрийгээ давхар ярьчихъя гэж бодож байна.

1 дүгээрт Авлигатай тэмцэх газраас. 1 дүгээр сарын 29-ний өдрийн

хулгайн хэргээр мөрдөн шалгах ажиллагаагаар эрүүдэн шүүсэн гэсэн гомдлыг Авлигатай тэмцэх газарт амь насаа алдсан иргэн “О” 2 дугаар сарын 7-нд өгсөн байна. Тэгвэл энэ авлигатай тэмцэх газарт ирсэн гомдлын хүрээнд хянан шалгах ажиллагааг нэн даруй явуулсан уу. Тэгээд дээрээс нь эрүүдэн шүүсэн гэсэн гомдол ирсэн. Энэ гомдлоос үүссэн, энэ гомдолд мэдээлсэн бие махбод болон сэтгэл санааны хохирлын үнэлгээ хийсэн дүгнэлт, репорт байна уу. Тэгээд дээрээс нь энэ иргэн “О” энэ эрүүдэн шүүлтээс үүдэлтэй, хохирлоос үүдэлтэй 7 сарын 23-нд амь насаа алдах эх суурь тавигдсан байх боломжтой юу гэдгийг асуумаар байна. Мөн түүнчлэн яг энэ эрүүдэн шүүсэн гэсэн гомдлын дагуу тэр мөрдөн шалгах ажиллагааг хариуцаж явуулж байсан цагдаагийн албан хаагчдыг ямар хүрээнд хянаж шалгах ажлыг хийсэн бэ. Тэр дүгнэлтийг АТГ-аас авмаар байна.

2 дугаарт нь 461-ээс болохоор ийм асуултыг асууя. Ер нь бол хоригдож анх хоригдохоор ирсэн хүний эрүүл мэндийн суурь үзүүлэлтийг бүртгэж авдаг тийм бүртгэл мэдээллийн эрүүл мэндийн эмчилгээ байх ёстой байх гэж бодож байна. Тэгээд хоригдож байх хугацаандаа нэмэлтээр эрүүдэн шүүсэн, шүүгдсэн байж болох тийм боломж байгаа юу. Тийм юм болоогүй гэсэн баталгааг 461-ээс өгч чадах уу. Хэрвээ чадахгүй бол энэ хоригдож байх хугацаанд 90 хоногийн хугацаанд нэмэлтээр эрүүдэн шүүсэн асуудлаас үүдэлтэй эрүүл мэнд доройтсон улмаас амь нас хохирсон байж болох уу.

Мөн түүнчлэн 461-ээс асуухад нийт 90 хоног цагдан хоригдсон байна. Гэтэл энэ хугацаанд ар гэр бүлийн эргэлт уулзалт ердөө 4 удаа байгаад би их гайхаж байна л даа. Ар гэр бүлээс нь 4 удаа л уулзъя гэсэн хүсэлт тавьсны улмаас ингэж уулзсан юм уу. Эсвэл уулзуулахгүй байх шалтгаан байсан уу. Би энэ дээр бол үнэхээр гайхаж байна. Миний санахын хүмүүс бол 7 хоног

болгон очиж болоод байдаг юм шиг байдаг юм.

Түүнчлэн Цагдаагийн ерөнхий газрын даргаас асуумаар байна. Энэ амь хохирсон иргэн “О”-ийн эрүүдэн шүүсэн гэх гомдолд холбогдсон, нэр холбогдсон цагдаагийн албан хаагчид яг одоо цагдаагийн ажил үүргээ хашаад үргэлжлүүлэн хашаад явж байна уу эсвэл ажил албыг түр түдгэлзүүлэн завсарлуулж, хэрэгт холбогдох асуудлаар шалгагдаж байна уу.

Х.Тэмүүжин: Нэмэлт 1 минут.

М.Нарантуяа-Нара: Тэгээд мөн түүнчлэн бид нар зөвхөн яг одоо болж байгаа хэрэг дээр биш. Өнгөрсөн хугацаанд энэ он гармагц Сэлэнгэ аймагт 13 настай охин мөн цагдаагийн албан хаагч нарт 4-ийн 4 цагдаагийн албан хаагчид бэлгийн хүчирхийлэлд удаа дараа өртөж байсан ийм ноцтой гэмт хэрэг гарсан. Энэ хэрэг дээр энэ 4 албан хаагч одоо яг ямар нөхцөл байдалтай байна. Шалгагдаж байна уу. Ял шийтгэл хүлээж байна уу. Яаж байна. Тэр асуудлыг иргэдэд бас ил тод нээлттэй мэдээлмээр байна. Мөн түүнчлэн энэ охины гэрч, хохирогчийн хохирол барагдуулах ажил бие сэтгэл, сэтгэл санааг дэмжих ямар үйлчилгээг төрөөс үзүүлж байгаа юм бэ гэдгийг бас мэдмээр байна.

Түүнчлэн цагдаагийн албан хаагчийг 3 сарын сургалтаар ингээд ажилд авдаг гэсэн ийм мэдээллүүд яваад байна. Тэгээд энийг бас тодруулах хүсэлтэй байна.

Х.Тэмүүжин: Эхлээд Авлигатай тэмцэх газар. Хэргийн мөрдөлтийнхөө асуудлаас бусад хариулж болох сэдвээр хариулаарай. 5 дугаар микрофон.

Ч.Жаргалбаатар: Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Жаргалбаатар гэж хүн байна. Тэгээд гишүүний асуултад хариулъя. 1 сарын 29-нд болсон үйл явдалтай холбоотойгоор 2 сарын 7-нд

гомдол, мэдээлэл Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн. Авлигатай тэмцэх газрын мөрдөгч нар бол мөрдөн шалгах хойшлуулигүй ажиллагааг 2 сарын 14 гэхэд бүрэн хийж гүйцэтгээд, түрүүний миний нэр дуудсан албан тоотыг Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлсэн байгаа. Мөрдөн шалгах ажиллагааны зарим нэг тодорхой төрлийн мөрдлөгийн ажиллагаанууд удааширалтай явагдаж байгаа. Энэ өөрөө хуулийн зохицуулалттай холбоотой учраас бас энэ хуулийн зохицуулалтынхаа хүрээнд хийгдээд явах ажиллагаа. Таны асуугаад байгаа гол асуултууд бол энэ мөрдөн шалгах ажиллагаа бүрэн үү гээд. Энэ хэргийг хянан шийдвэрлэх цаг хугацаанд энэ ойлгомжтой, тодорхой болно. Авлигатай тэмцэх газрын гаднаас баривчилсан гэдэг асуудлуудыг нэлээн ярилаа. Энэ дээр бол түрүүн ЦЕГ болон бусад албан тушаалтнууд тодорхой хэлчихлээ. Энд бол АТГ гомдол гаргасан хүнээ цагдаагийн албан хаагчид барьж өгөөд явуулсан асуудал гэдэг бол эндүү ташаа мэдээллээ гэдэг нь тодорхой болсон.

Ганц эргэлзээд байгаа асуудал юу юм бэ гэхээр зэрэг энэ эрүү шүүлт мөн үү биш үү л гэдэг асуудлууд яригдаад байна. Энэ зүгээр мендезийн зарчим гээд яриад олон улсын жишиг хэм хэмжээ яриад үзэх юм бол ер нь сая цагдаагийн байгууллагын дарга хэллээ. Уулзах ёсгүй газар юм уу, мэдүүлэг авах байна уу, ярилцах байна уу, уулзаж л байгаа л бол дуу, дүрсний бичлэгтэй тухайн хүний эрхийг зөрчөөгүй гэдгээ нотолсон баримттай л байх ёстой. Ийм л шаардлагыг тавьж бид мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа. Бусад тэр мөрдөн шалгах ажиллагааны төлөвлөлт, үр дүн, тогтоогдсон нөхцөл байдлын талаар бол хуулиар хориотой учраас би мэдээлэл өгөх боломжгүй.

Х.Тэмүүжин: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар. Нарантуяа гишүүн 461 гээд ангиас асуугаад байна лээ. Энд анги ирэхгүй. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

газрын төлөөлөл ирж байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дотор эрүү шүүлт үргэлжилсэн байх магадлалтай юу. Тийм эрсдэл байгаа юу. Тийм юм болсон юм уу гэж маш тодорхой асуулт асуусан шүү. 4 дүгээр микрофон.

Б.Нандинболор: Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Нандинболор илтгэж байна. Нарантуяа гишүүн манай байгууллагатай холбоотой 3 төрлийн асуулт асуулаа. Тухайн амь хохирогчийн цагдан хорих шийдвэр гарсан үед хүлээж авсан эрүүл мэндийн анхан шатын үзлэгийн бүртгэл хөтлөгддөг үү гэж байна. Энэ бол хөтлөгдөнө. Энэ бол мөн хөндлөнгийн гэрч болон камерын бичлэгтэй явагддаг. Тухайн хүлээлгэн өгч байгаа албан тушаалтныг байлцуулан явагддаг ажиллагаа байгаа. 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр анх хүлээн авахад жижүүр эмчийн үзлэгээр өндөр 175см, жин 60кг, артерийн даралт 100/60, зүрхний цохилт 100, цусан дахь хүчилтөрөгчийн хэмжээ 97, архаг хууч өвчний асуумжгүй, толгой өвдөнө гэсэн зовууртай. Бусад мэдээлэл нь бол эмзэг мэдээлэлдээ орж байна. Энэ нь бол эмзэг мэдээлэлд хамрагдаж байгаа учраас ерөнхий биеийн байдлынх нь үзүүлэлтүүдийг нь дурдчихъя.

Дараагийн асуудал нь 461 дүгээр хорих ангийн цагдан хорих байранд эрүүдэн шүүх үйл ажиллагаа явагддаг уу. Энд тийм боломж нөхцөл бий юу гэсэн асуулт тавигдаж байна. Энэ бол ямар ч боломж байхгүй. Манайх бол зөвхөн шүүхийн шийдвэрийг биелүүлдэг байгууллага. Тухайн хоригдогч болон түүний аюулгүй байдлыг хангах ийм чиг үүрэгтэй. Хуучин бол хар булан гэж бас хүмүүсийн нэрлэдгээр тийм яриа Энхбаяр сайдын үед Их Хурлын гишүүн байхдаа Их Хурлын индэр дээрээс бас хэлсэн. 61-д эрүүдэн шүүдэг болон камергүй газар байна гээд. Үүний хүрээнд прокурорын байгууллага, хүний эрхийн байгууллагаас шалгалт хийгээд, яг

нийтийн эзэмшлийн 4 газарт ийм камергүй газар байна гэдгийг нь бүрэн камержуулаад, 461 бол бүрэн 24 цаг тасралтгүй камерын хяналт байж байгаа. Энэ дээр прокурорын байгууллага болон хүний эрхийн байгууллага прокурорын байгууллага бол өдөр болгон ирж шалгадаг. Нийслэлийн прокурорын газраас тухайн 61-ийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Хүний эрхийн байгууллагаас төлөвлөгөөт хуваарийнхаа дагуу очиж шалгадаг. Мөн хоригдогчийн гаргасан гомдлын дагуу хяналт шалгалтын ажлыг явуулдаг.

Эргэлт, уулзалтыг 4 удаа зохион байгуулсан байна гэнэ. Манайх эргэлт уулзалтыг зохион байгуулдаггүй гэдгийг бас эрхэм гишүүндээ хэлье. Хоригдож байгаа эрх бүхий шийдвэр гаргасан байгууллагын зөвшөөрлөөр манайх тухайн зөвшөөрлийн бичгийг үндэслээд тухайн хүнийг ар гэртэй нь уулзуулах өрөө тасалгаа нөхцөлөөр хангадаг ийм л чиг үүрэгтэй. Байцаалтын зохион байгуулалт хуваарийг тэдэн удаа уулзуулна тэдэн удаа уулзуулахгүй гэдгийг манайх гаргадаггүй. Манайх зөвхөн байр нөхцөлөөр хангаж өгөх тийм чиг үүрэгтэй гэдгийг илтгэе. Илтгэж дууслаа гишүүн ээ.

Х.Тэмүүжин: Энэ дээр ийм мэдээлэл өгч болох хэмжээнд байна уу, үгүй юу. Эрүү шүүлтэд өртсөн гэж байгаа иргэнтэй эрүү шүүлт хийсэн байж магадгүй гэж сэрдэгдэж байгаа цагдаагийн алба хаагчид цагдан хоригдож байгаа төвд очиж уулзсан тийм тохиолдол байгаа юм уу. Тийм мэдээлэл байна уу.

Б.Нандинболор: Яг тийм бодит кэйс бол байхгүй. Зүгээр яах вэ ер нь бол прокурорын байгууллагаас бол тухайн хорьж байгаа, хорьсон мөрдөгч болон бусад тэр хэрэг дээр хамтарч ажиллаж байгаа тухайн тушаал шийдвэрээр ажиллаж байгаа ажлын хэсэгт орж ажиллаж байгаа эрүүгийн төлөөлөгчийг бол уулзуулж байгаа. Тэрнээс өөр

дүүргийн мөрдөгч очиж уулзах тийм боломж байхгүй. Энэ дээр бол прокурор өөрөө яг биечлэн хяналт тавиад ажиллаж байгаа. Бид бол зөвхөн уулзалтын бичгийн хүрээнд нөхцөлөөр хангах л ийм үүргийг хэрэгжүүлж байгаа. Илтгэж дууслаа.

Х.Тэмүүжин: Энэ асуудал дээр Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье дөө.

С.Эрдэнэболд: Түрүүн Цагдаагийн ерөнхий газрын даргаас камер гээд асуухад та ингэж хариулсан шүү дээ. Одоо бүх камержуулалт явж байгаа гээд. Тэгэнгүүтээ таны хариулт дээр юу гэж байсан гэхээрээ гэрэл унтраа гээд байдаг учраас харанхуйд камер бичихгүй гээд тэгж хэлсэн тээ. Шүүхийн шийдвэр хэлсэн. Уучлаарай. Андуурсан байна. Тэгэхээр би лав оффис дотроо миний утсан дээрээс камер явахад шөнө яадаг вэ гэхээр харанхуйд хар цагаанаар бүх юм нь харагдаж байдаг. Тэгээд гэрэлтэй үед бол өнгөтөөр харагдаж байдаг. Тэгэхээр жишээлбэл 461 дээр нөгөө камерыг та 24/7 явдаг гэж хэллээ шүү дээ тээ. Ямар ч эрүүдэн шүүх боломжгүй. Булан, тохой болгоныг нь камержуулчихсан гээд байна шүү дээ. Тэгэхээр яг тэр шөнийн бичлэг, хоригдлуудын амарч байгаа үед ч гэдэг юм уу тэр үед нь бас бүх дүрсүүд авагддаг биз дээ. Авагдаж байгаа биз дээ тээ. Тэгэхээр ерөөсөө л өдөр шөнийн 24 цагт байнга тасралтгүй л явагдаж байгаа биз дээ тийм ээ.

Х.Тэмүүжин: Хэрвээ шөнө ажилладаггүй, зөвхөн гэрэлтэй нөхцөлд ажилладаг камертай байна гэдэг чинь өөрөө ерөнхий тогтолцооны эрүү шүүлт явна гэсэн үг байхгүй юу. Тэгээд тэрэн дээр Хууль зүйн яам анхаарна биз. Төсөв мөнгө боломжоо хараад хүнийг унтах нөхцөлөөр хангах ёстой шүү дээ. Тэгэхгүй өдөр шөнөгүй гэрэлтэй байлгана гэдэг бол эрүү шүүлтийн нэг хэлбэр шүү дээ. Тэгээд энэ асуудлыг бас 2, 3 газар яригдахыг сонссон. Тэгээд энэ чиглэлээр Хүний эрхийн Үндэсний Комисс,

Хууль зүй, дотоод хэргийн яам 2 хамтраад шийдэл гаргаад, дүгнэлт хийх байх. Протоколоор чиглэлүүд өгнө. Асуултад хариулаад дуусчихсан. Цагдаа дээрээс асуусан билүү. 2 дугаар микрофон.

Т.Сүхболд: Нарантуяа гишүүний асуултад хариулъя. Одоогийн байдлаар яг энэ амь хохирсон иргэний асуудал дээр цагдаагийн байгууллагаас яллагчаар татагдсан юм уу, шалгагдсан албан хаагч байхгүй. Нийтийн цахим сүлжээгээр болон хүмүүс энэ цагдаагийн 8 албан хаагч нийлээд зоджээ, 6 албан хаагч нийлээд зоджээ гээд л байгаа. Тэгээд л одоо яг цагдаагийн ямар алба хаагч зодсон юм, ямар алба хаагч юунаас болж зодсон юм гэсэн ийм юм нь нотлогдоогүй. Манай цагдаагийн алба хаагчдаас дуудаж байцаалт авсан энийг сэжиглэж байгаа, энийг шалгаж байгаа гэсэн одоогийн байдлаар надад тийм мэдээллийг ирүүлээгүй. Би энийг бол дахин дахин асуусан. Танай цагдаагийн хэлтсийн чинь ямар алба хаагч нар энд холбоотой юм бэ гээд. Одоогийн байдлаар бол тэр алба хаагч холбоотой, энэ алба хаагч шалгагдаж байгаа гэсэн ямар ч мэдээлэл байхгүй. Тэгэхээрээ би яг нэг алба хаагчтай холбоотой манайх чинь бас 13 мянга орчим алба хаагчтай байгууллага. Өдөр тутам энэ гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг хийж байдаг. Өдөр тутам иргэдийнхээ төлөө л ажиллаж байдаг байгууллага. Тийм учраас бас иргэдэд бас зөв ойлгуулаач та бүхэн гэж хэлмээр байна. Одоо бол яг ингээд тэр зодсон гэсэн юм байхгүй. Тэр зодсон гэсэн юм бол бид нар тэрийг нуух хэрэг байхгүй. Цагдаагийн байгууллагад хүн зодсон алба хаагч юм уу, хүний биед халдсан алба хаагч юм уу энийг нуух бид нарт янз бүрийн шалтгаан байхгүй. Би бол тэрийг албан ёсоор урьд өмнө нь ч хэлж байсан.

2 дахь асуулт нь тэр Сэлэнгэ аймагт гарсан тэр насанд хүрээгүй эмэгтэйтэй холбоотой харамсалтай хэрэг гарсан. Энэ хэргийн надад авагдсан

мэдээллээр манай авагдсан мэдээллээр цагдаагийн байгууллага шалгаагүй та мэдэж байгаа. Насанд хүрээгүй охин. Тэгээд надад байгаа мэдээллээр 1 алба хаагч нь яллагдагчаар татагдаж, шүүгдэгч болоод, 1 алба хаагч нь шүүхээр 12 жилийн ял авсан. 2 нь хоригдон шалгагдаж байгаа. 1 нь гадагш явахгүй таслан сэргийлэх арга хэмжээ аваад бас гадуур шалгагдаж байгаа гэсэн ийм л мэдээлэл байна.

Цагдаагийн алба хаагчийг 3 сар Дотоод хэргийн их сургууль дээр бэлддэг. Энэ ахлагчийн сургууль гэж байдаг. Энэ дээр яах вэ шалгаад л цагдаагийн байгууллагынхаа хүний нөөцтэй хамт шалгаад л, тэгээд эрүүл мэндийн үзлэгт оруулаад, тэгээд л шалгалт аваад л эрх зүйн шалгалт аваад л, тэгээд л бие бялдрын шалгалт аваад л ингээд л шалгадаг. Яах вэ, зүгээр цагдаагийн байгууллага сүүлийн үед энэ ахлагч нарын асуудал дээр бол ковидын үед цахимаар ахлагч нар олон бэлдсэн. Яг нөгөө хэрэгцээ шаардлагаа өгөөд. Тэгээд эрх зүйн мэдлэг дутмаг тийм хүмүүс байгаа. Бид нар бол тэд нарыг энэ жил дахин давтан сургалтад бүрэн хамруулсан. Мөн офицер бэлдэх дээр нөгөө шууд өмнө нь бол цагдаагийн байгууллага, офицер, сургуульд явуулах, цагдаагийн сургуульд сургах хүмүүсээ өөрсдөө шалгаад, өөрсдөө судлаад.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Гишүүд асуултаа буруу хүнээс асуугаад байна. Цагдаагийн алба хаагчид шалгагдаж байгаа юу, үгүй юу гэдэг асуултыг хэнээс асуух ёстой вэ гэхээр АТГ-аас асуух ёстой байхгүй юу. Авлигатай тэмцэх газар ямар нэгэн иргэний гомдлоор холбогдож байгаа хүмүүстэй нь холбоотой ямар нэгэн сэжүүр, таамаг явсан эсэх. Би бараг тэгж асуумаар санагдаад байгаа юм. Авлигатай тэмцэх газар гэрч хохирогчийг цагдан хоригдож байгаа үед цагдан хоригдож байгаа газраас нь гаргаж ирээд, тийм ажиллагаа явуулах эрхтэй биз дээ ер нь. Өөр байгууллага хийсэн байж болно. Цагдан хорьж байж

болно. Гэхдээ эрүү шүүлтэд өртлөө мөрдөж байгаа байгууллагын албан хаагчид над дээр гэмт хэрэг үйлдлээ гэж байгаа бол тэр хүнийг хаа байгаа газраас нь татаж гаргаж ирээд, таниулах үйл ажиллагааг биетээр явуулж болно доо. Хуульд тийм боломж байгаа байлгүй дээ. Байхгүй юм уу. Байгаа тэр боломжийг ашиглахгүй, далд хийчихсэн юм чинь хамаа алга гээд мартчихсан бол энэ бол танай байгууллагын хариуцлагын асуудал байхгүй юу. Тэгээд тэр зүгээс нь асуухгүй цагдаагаас асуугаад байвал наад цагдаа чинь өөрөө шалгаагүй юм чинь, мэдээлэл байхгүй юм чинь энэ хэрэг дээр шалгагдаж байгаа хүн байхгүй л гэдэг хариулттай байна шүү дээ. Авлигатай тэмцэх газар энэ дээр хариулт өгөх үү. 5 дугаар микрофон.

Ч.Жаргалбаатар: Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Жаргалбаатар байна. Ерөнхийдөө өнөөдөр мөрдөгчийн бие даасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүрээ хязгаар хумигдчихсан. Одоо эрүү шүүлт тулгалаа гэдэг гомдол, мэдээлэл Авлигатай тэмцэх газарт ирлээ гэхэд ямар хэрэгт холбогдуулан шалгаж байгаа юм, хэзээ мэдүүлэг авч вэ гэдгийг үзэхийн тулд Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч, мөрдөгч нар өөрсдөө очоод үзлэг хийх эрх байхгүй. Заавал прокурорын зөвшөөрлөөр очиж үзлэг хийдэг. Зөвхөн хэрэгт үзлэг хийгээд. Цагдан хорих ангид хоригдож байгаа тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд даргаас зөвшөөрөл авч хорих ангид нэвтэрч мэдүүлэг авч байгаа. Ийм л нөхцөл байдалтай байгаа. Энэ нөхцөл байдлын хувьд бид нар эхний үед биетээр таниулга хийх үйл ажиллагаа явуулсан боловч тухайн хүн хоригдчихсон байсан учраас бид нар таниулга хийх ажиллагаагаа зургаар хийх ажиллагаа явуулах шаардлагатай болсон. Ингээд 4 сарын 23-нд санаж байна. 4 сарын 23-нд бид цагдаагийн байгууллагад тэнд ажиллаж байгаа бүх эрүүгийн мөрдөгч нарын зураг мэдээллийг ирүүлээч гэсэн

хүсэлтээ явуулаад, 5 сар гараад манайд мэдээллүүд нь ирсэн. Практикт юу болж байгаа вэ гэхээр бид зургаар таниулаад явуулчихаар шүүх дээр тухайн таниулах ажиллагааны нотлох баримтыг хүчингүйд тооцчихоод байгаа. Яагаад гэвэл энэ дээд шүүхийн тайлбар гарчихсан. Хуулийн зохицуулалт чинь ийм байна. Хууль чинь ийм байна гэдэг ийм хууль зүйн үндэслэгээгээр нотлох баримтыг хүчингүйд тооцчихоод байгаа учраас бид нарын хийсэн ажил үр дүнгүй цаас болж хувираад байгаа. Энэ бүх хийдлүүдийг л бид арилгах шаардлагатай байгаа юм. Энэ өөр олон кэйс фактууд дээр гарч байгаа нийтлэг жишээ учраас бас энэ Эрүүгийн хууль, ЭХХШТХ-д бол үр нөлөөний шинжилгээнүүдийг хийгээд, яг энэ процессуудыг зөв болгохгүй бол ийм фактууд цаашид үргэлжилсээр байхаар ийм нөхцөл байдал байгаа учраас л энэ дээр бид нар энэ Эрүүгийн хуулийг боловсронгуй болгоё. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай процессын зохицуулалтыг боловсронгуй болгоё. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар зохицуулчихсан харилцааг бусад салбарын харилцааны хуулиудаар аваачиж хязгаарладаг, нөхцөл бололцоог хаадаг энэ нөхцөл байдлуудыг байхгүй болгоё л гэсэн ийм саналуудтай байгаа.

Х.Тэмүүжин: Хүний эрхийн Үндэсний Комисс дараагийн хэлэлцүүлэг дээр, хурал дээр прокуророос хүн дуудах ёстой юм байна. Хүний эрхийн Үндэсний Комисс, Авлигатай тэмцэх газар яг энэ эрүү шүүлттэй холбоотой энэ асуудлаа шалгахдаа прокурор луу таниулах ажиллагаа болон ийм чиглэлийн хүсэлтүүд явсан эсэх дээр нэг мэдээ баримтыг нь харчхаарай. Одоо Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Ер нь бол нэлээн асуултууд нь асуулт давхацчихлаа. Тэгээд яг сая сүүлийн асуусан асуулт буюу Авлигатай тэмцэх газраас асуумаар байсан юм. Энэ н юу гэхээр яг энэ эрүү шүүлттэй маш ноцтой мэдэгдлүүдийг хийж байна л даа.

Тэгэхээр яг эрүү шүүлттэй холбоотой хэрэг ер нь бол илрэх магадлал өөрөө маш бага сонсогдож байна. Өөрөөр хэлбэл хэрвээ бичлэг хийнэ. 100 хувь камертай байгаа. Камергүй нөхцөлд байцаалт авахгүй байх ёстой гэдэг юм ЦЕГ-аас хэлж байгаа боловч, нөгөө талдаа АТГ-аас ХЭҮК руу явуулсан албан тоот дээр маш тодорхой дурдсан. Энэ хэрэг дээр камерын бичлэг байгаагүй. Камеруудын өнцөг өөрчлөгдсөн байсан. Энэ асуудал яригдаж байна. Тэгэхээр энэ дээр бас нэг асуулт байгаа нь эрүүдэн шүүсэн бол ямар хариуцлага хүлээдэг вэ. Нөгөө талаасаа тухайн эрүүдэн шүүх нөхцөл байдал үүссэн байж болзошгүй тэр байцаалтыг авахдаа хэрэв хууль, журам зөрчсөн бол буюу албаар камер ажиллагаагүй болгосон эсвэл камерын өнцгийг өөрчилсөн бол ямар арга хэмжээ авдаг юм бэ. Энэ 2 хуулийн хариуцлагын арга хэмжээнийх нь санкцыг мэдмээр байна.

Нөгөө талаасаа яг үүнтэй адил шалтгаанаар буюу нотлох баримтын шаардлага хангагдаагүй учраас эрүүдэн шүүсэн гэх гомдол буцаж байсан хэчнээн тохиолдол байгаа вэ. Энэ талаар мэдээлэл өгөөч. Хэрэв бэлэн биш байгаа бол дараагийн удаа бэлдэж ирнэ үү гэдэг ийм асуулт байна.

Өмнө нь эрүүдэн шүүхээс гадна нөгөө хэрэг нь амь хохирсон асуудал байгаа. Энэтэй холбоотойгоор ШШГЕГ-аас асуулт байна. Өмнө нь бол тайлбарлахдаа эм, эмнэлгийн ажилтны хүний нөөц дутмаг, чадвар дутмаг байдаг. Нөгөө талаасаа эмнэлэгт аваачаад шилжүүлье гэхээр тэнд бол яалт ч байхгүй нөгөө хаалттай хамгаалалттай тийм нөхцөл байдал бүрдүүлсэн эмнэлэг ховор байдаг. Энэ нь өөрөө бас нөхцөл байдлыг хүндрүүлдэг гэдэг тайлбар хэлж байсан. Мөн журмын дагуу шаардлагатай нөхцөлд тусгай мэргэжлийн эмч нарыг урих боломжтой байдаг юм байна гэж ойлгосон. Тэр зөв үү. Нөгөө талаасаа яг энэ болсон хэрэг дээр тусгай мэргэжлийн

эмч урьсан, ажиллуулсан уу гэдэг 1 дүгээр асуулт, 2 дугаарт ер нь энд хорих урьдчилан хорих ангид болон хорих ангид тэр тусгай мэргэжлийн эмч урьж авчирч үзүүлж байсан тохиолдлууд ер нь хэр олон байдаг юм бэ. Тэр талаар бас статистик мэдээ авмаар байна.

Х.Тэмүүжин: Уянгахишиг гишүүн яг хэнээс асуув.

Г.Уянгахишиг: Шийдвэр шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас. Нөгөө урьдчилан хорих болон хорих ангид өвчтөн тусгай мэргэжлийн эмч гээд. Өмнөх нь бол АТГ-аас гэсэн шүү дээ.

Х.Тэмүүжин: Авлигатай тэмцэх газар нөгөө эрүүгийн эрүүдэн шүүх үйл явцтай холбоотой хэргийг 2018 оноос авсан гэсэн үү. Тэрнээс хойших статистик л харагдах байх даа. Авлигатай тэмцэх газар. 5 номерын микрофон дээр очоод суучих. 2018 оноос хойш АТГ-аас гадуур эрүү шүүлттэй холбоотой хэргийг мөрддөг шалгадаг өөр чиг үүрэгтэй байгууллага бол байхгүй байгаа юу. Тэгэхээр нэгдсэн статистик гарахад хэцүү байна уу.

Ч.Жаргалбаатар: Байгаа. ЭХХШТХ-д зааснаар бол АТГ болон цагдаагийн байгууллагын албан хаагчтай үйлдсэн бол тагнуулын байгууллага дээр. Ингээд энэ 3 байгууллагыг мөрдөх байгууллагуудыг хооронд нь энэ прокурор холбогдсон албан тушаалтнаас нь хамаараад тогтоож байгаа учраас өөр өөр байгаа.

Х.Тэмүүжин: Тэгвэл нэгдсэн статистик бол яг одоогоор шууд хариулж чадахгүй, зөвхөн байгууллагынхаа түвшиний юмыг хэлж чадах юм байна.

Ч.Жаргалбаатар: Тэгнэ. Яг 2020-2024 он гээд уг нь би энэ тоон статистикуудыг түрүүн нэлээн дэлгэрэнгүй хэлж өгсөн. 15 хэрэг одоо яг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдчихсэн

байгаа. Авлигатай тэмцэх газарт нийт яг эрүүдэн шүүгдлээ гэсэн гомдол мэдээллүүд бол энэ хугацаанд болохоор 113 гомдол мэдээлэл ирсэн байна лээ. Ирж байгаа нөгөө гомдол мэдээллийн хувьд зарим нь эрүүдэн шүүсэн асуудлууд, зарим нь энэ хүнлэг бус харьцсан асуудлууд, зүй бус харьцсан харилцааны асуудлаас үүдэлтэй холбоотой гомдол мэдээллүүд ирдэг байгаа. Энэ хэргүүдээс гадна эрүүдэн шүүлээ гэж байгаа боловч тухайн хүнд давуу байдал олгочихлоо. Нотлох баримт хуурамчаар үйлдчихлээ гэдэг энэ гомдол мэдээллүүд ирснээрээ бас яг энэ төрлийн 46 хэрэг шүүхээр эрслэн шийдвэрлэгдчихсэн байгаа. Хүний амь нас хохироосон гэмт хэргээр 1 хэрэг шийдвэрлэгдчихсэн байгаа. Ингээд тоо статистик нь шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн статистик нь бол энэ хэмжээнд байна.

Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн хувьд энэ төрлийн гэмт хэргүүд дээр зөвхөн камерын бичлэгээр нотолдог асуудал бол байхгүй. Өөр бусад эрүүдэн шүүлтийн гэмт хэргийг нотолдог нотлох баримтын асуудлууд байна. Энэ өөрөө процесстой, тусдаа нотолгооны онолтой, арга зүйтэй. Энэ процессынхоо дагуу хийгдээд нотлогддог. Камерын бичлэггүй хариуцлага хүлээдэггүй гэсэн ийм ойлголт бол биш шүү гэдгийг нэмэлтээр тайлбарлаж хэлье.

Х.Тэмүүжин: Эрүү эрүү шүүлттэй холбоотой энэ төрлийн гэмт хэргийн хариуцлага.

Ч.Жаргалбаатар: Хариуцлагын хувьд бол Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл дээр 1-5 жил гэгчихсэн байгаа. Ингэсэн хэр нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд дээр бол Эрүүгийн хуулийн 10.2.1 дүгээр зүйл дээр эрүүдэн шүүж, хүнд гэмтэл учруулсан бол, эрүүдэн шүүж хүндэвтэр гэмтэл учруулсан бол гээд нөгөө бусад гэмт хэргүүдийн шинжийг энэ зүйл заалт тодорхойлж өгснөөсөө болоод бүр

хөнгөн тийм нөхцөл байдлууд үүсдэг. Эрүүгийн хуулийн хэрэглээний явцад гэмт хэрэг үйлдсэн сэжиглэгдсэн этгээдэд ашигтай байдлыг баримталдаг. Энэ зарчим бол одоо шүүхийн практикт хэрэглэгддэг ийм нөхцөл байдлууд байдаг учраас ер нь бол яг эрүү шүүлт тулгах гэдэг дээрээ 1-5 жил, хүндэвтэр гэмтэл санаатай учруулсан, эрүүдэн шүүсэн бол тэрнээс бага ялтай байх жишээтэй. Энэ ялын интервал буюу энэ хууль дээр үр нөлөөний шинжилгээ хийх зайлшгүй шаардлага байна гэж хэлээд байгаа шалтгаан нь энэ байгаа.

Х.Тэмүүжин: Ер нь бол мөнгө угаах гэмт хэргийг бол бүх хэргийн ард хавчуулаад хэрэглэж чадаад байгаа мөртөө эрүү шүүлттэй холбоотой хэргийг бол чадахгүй байгаа юм байна. ХЭҮК хэлэх үү. Тэрийг прокурор ирэхээр прокурорын хяналт дээр түшиглэж байгаад хариулт авсан нь дээр байх. Одоо бол комиссоос асуулт асуугаагүй юу. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар.

А.Намсанманд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, хурандаа Намсанманд. Уянгахуушиг гишүүний асуултад хариулъя.

Түрүүний бас нөгөө энэ үдээс өмнөх асуулт дээр бас дурдагдаж байсан л даа. Эрүүл мэндийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд 2-ын хамтарсан 2019 оны журам байдаг юм. Дээрх журмаар ямар харилцааг зохицуулж байна гэхээр хорих байранд байгаа хоригдож байгаа хоригдол болон нь хоригдогчийг дараагийн шатлалын ахисан шатын эмнэлэгт хэвтүүлэн эмчлүүлэх болон ШШГБ бас ахисан шатын эмнэлгээс эмч, эмнэлгийн ажилтан дуудан ирүүлж үйлчилгээ авах харилцааг зохицуулсан журмын хүрээнд манай үйл ажиллагаа өнөөдөр бас явагдаж байгаа. Сая өнгөрөгч одоо бид бүхний яриад, дурдаад байгаа энэ тохиолдолд бол амь хохирогчийг тухайн үед бол улсын төв Шастины 3 дугаар

эмнэлэг, бидний хэлж заншсанаар 103-ын дуудлага өгч, 103-аас бол холбогдох эмч эмнэлгийн ажилтан ирж үзээд, энийг бол танай эмнэлгийн ахисан түвшний оношилгоо, үйлчилгээ шаардлагатай юм байна гэдэг дүгнэлтийг тавьсан учраас бид бүхэн Шастины эмнэлэг рүү эмчилгээ, үйлчилгээг шилжүүлсэн байж байгаа.

Х.Тэмүүжин: Би асуултаа асууя. Ер нь ихэнх асуултууд хариулагдчихлаа. Гэхдээ хэд хэдэн асуулт. Энэ удаа хариулах мэдээлэл хангалттай биш байгаа гэж үзэх юм бол дараагийнх дээр нь бэлдээд ирээрэй гэж би бас чиглэл өгөх юм.

1 дүгээрт энэ цагдаагийн байгууллагад хэрэгт шалгагдаж байгаа болон эсхүл цагдаагийн байгууллагад гомдол хүсэлт гаргаад, тэдний чиг үүргийн хүрээнд өртөж байгаа иргэд ямар нэгэн байдлаар ингээд хохирч байна. Алба хаагчид нь хувийн харилцаа тогтоохыг шаардаж байна. Заримдаа хүч түрж байна. Тэр байдлаасаа болоод Сэлэнгэд жишээ нь бага насны хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуудал хөндөгдөж байна. Яг үүнтэй адилхан нэг бус хэрэг гарсан гэдэг мэдээлэл байна. Гадуур бол зармыг дараад өнгөрөөд байна гэх мэтчилэн хардалтууд байна. Тэгэхээр ер нь цагдаагийн алба хаагчид өөрийнхөө чиг үүргийн хүрээнд орж ирсэн ямар нэгэн хүмүүстэй хувийн харьцаа тогтоосон ийм байдлаар асуудалд холбогдсон гэдэг хэрэг үнэхээр нэг бус байгаа юу, үгүй юу. Энийг дахиад давхар шалгахын тулд ХЭҮК энэ төрлийн мэдээллээ нягтлаад, дараагийнх дээр баримттай, бодитой тоотой яримаар байна. Тэгэхгүй бол гадуур нэг бол хавтгай яваад байгаа юм шиг, нэг бол худлаа яриад байгаа юм шиг ийм нэг эргэлзээтэй байдал бий болоод байна. Тэгээд энэ эргэлзээг 1 дүгээрт арилгамаар байна.

2-т нь бас дахиад маш ноцтой. Эрүү шүүлттэй холбоотой асуудал бол

ингээд цагдаагийн байгууллага төдийгүй мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын дотоод соёл ишг болчхоод байна. Өмнө нь Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлүүд дээр баримттайгаа, нэр устайгаа, эрүү шүүлттэй холбоотой дурдагддаг. Ядаж Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд дурдагдсан тэр албан хаагчдад ямар хариуцлага тооцсон бэ. Хэдэн хувьд нь тооцсон юм, тооцоогүй юм. Ямар хариуцлага тооцсон юм. Тэр тухай судалгаа байна уу. Тэр тухай мэдээлэл байна уу. Мэдээлэл байвал хэлээч. Мэдээлэл байхгүй бол дараагийн удаа ирэхдээ энэ тухай нарийн мэдээлэлтэй, судалгаатай ярина шүү.

3-д нь гэрч хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа сая АТГ дээр яриан дотор хөндөгдсөн. Манайд бол гэрч хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хэлтэст ямар нэгэн албан тушаалтан байхгүй. Байхгүй учраас гэрч хохирогчийг хамгаалах ажиллагааг бол бид бол хийж чаддаггүй. Гэрч хохирогчийг хамгаалах чиг үүрэг цагдаагийн байгууллага дээр байдаг. Цагдаагийн байгууллагын албан хаагч оролцсон гэрч хохирогчийг цагдаагийн алба хаагчид хамгаална гэдэг бол маш сонирхлын зөрчилтэй үйл хэрэг болно. Дахиад хэвлэл мэдээллийн хэрэгслээр ийм мэдээ гарч байна. Нөгөө Сэлэнгэд хохирсон бага насны иргэн мэдүүлгээсээ буцах, өөрчлөгдөх тохиолдол гараад эхэлж байна. Тэгэхээр гэрч хамгаалалтгүй байна гэсэн үг. Нөлөөлөлд автах болом бүрэн боломжтой байна гэсэн үг. Гэрчийг айлгах юм уу, худалдан авах юм уу, ямар нэгэн нөхцөлөөр мэдүүлгийг нь өөрчлөх боломж бүрэн байна гэсэн үг. Гэрч мэдүүлэг өөрчлөгдөж байгаа бол шүүх хурлын шийдвэр яаж гарах нь ойлгомжтой шүү дээ. Шударга ёс огт тогтохгүй гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцооны чинь одоо байгаа нөхцөл байдалтай холбоотой яаж гэрч, хохирогч хамгаалагдаж байгаа юм. Хамгаалагдаж чадахгүй гэрч, хохирогч

үнэхээр байгаа юм уу гэх мэтчилэн бас энэ мэдээлэл судалгаа хэрэгтэй байна.

Цагдан хорих төвд хүнийг нь аваачаад хийчихсэн. Тэгээд гэрч хохирогчоор өөрийгөө хамгаалуулах гомдол, санал гаргаагүй гээд сууж байх бол төрийн байгууллагын хувьд бол үнэхээр эмгэнэлтэй. Надад хамгаалалт хэрэгтэй байна гэдэг хүсэлтээ цагдаагийн албан хаагчаар дамжуулах юм уу, ШШГБ-ын албан хаагчаар дамжуулах юм уу. Дээр нь ШШГБ ийм эрүү шүүлттэй холбоотой байх юм бол тэд нар чинь тэр мэдээллийг чинь дамжуулахгүй шүү дээ. Тэгэхээр энэ АТГ өөрт нь гомдол гаргаад, эрүү шүүлтэд өртлөө гэж байгаа иргэнтэй очиж уулзахгүй, цагдан хорих төвд очоогүй байна гэдэг бол бас асуудал шүү. Энэ асуудал чинь хууль зүйн асуудал байгаа юм уу, эсвэл та хэдийн үйл ажиллагааны асуудал байгаа юм уу гэдэг дээр ХЭҮК дахиад яг энэ дээр нэг мэдээлэл цуглуулаарай. Үүнтэй ижил хэмжээний үйл явдлууд өрнөөд байгаа юм биш биз дээ. Үнэхээр хохироод байгаа мөртөө эрүү шүүлт хууль сахиулах болон гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаанд өртөөд хохироод байгаа мөртөө түүнийгээ илрүүлж чадахгүй хүмүүс цагдан хорих төв болон хуулийн байгууллагын эргэн тойронд тойроод гүйгээд байгаа юм биш биз дээ. Энэ бол аюул шүү. Энэ талаар хэлэх мэдээлэл байна уу, байхгүй юу. Эсвэл дараагийн Хүний эрхийн дэд хорооны хурал дээр ярьж өгөх юм уу. Тэрийгээ нэг тодорхой хэлээрэй.

Цагдаагийн байгууллагаас мэдээлэл хийхдээ иргэнийг буруутгах гэх мэтчилэн гээд сая бол нэлээн яригдлаа. Цагдаагийн байгууллага олон нийттэй харилцах ийм чиглэлийн мэргэжилтэн ер нь байгаа юу. Өөрсдөө л үзээд байна уу. Олон нийтийн уур амьсгалд өгч байгаа мэдээллээсээ болоод алдаанд хүрвэл энэ хууль сахиулах болон гэмт хэрэгтэй тэмцэх байгууллагын чинь нэр хүнд улам унана шүү дээ. Тэгээд энэ чадавхаа та нар нэг

өөрсдөө бодоорой. Хууль зүйн яам бас бодоорой. Дээр нь ер нь энэ хуулиар хамгаалагдсан хувь хүний нууц гэдэг дотор хуулийн зохицуулалтыг нь боловсронгуй болгох чиглэлийн юм харагдаад байна шүү. Нөгөө хүний эрхийг хамгаалдаг улс оронд чинь бага насны хүүхдийг хүчирхийлсэн иргэдийн мэдээлэл нээлттэй байдаг шүү. Хажууд нь амьдарч байгаа хүмүүс манай хөрш ямар вэ гэдгээ мэдэх эрхтэй байдаг шүү. Гэтэл энэ чиглэлийн мэдээллийг задалснаараа сэтгүүлч шоронд сууж байдаг. Энэ чинь зөв юм уу, буруу юм уу. Энийгээ дахиад нэг бодох ёстой шүү. Бодлогын хувьд. Хууль зүйн бодлогын хувьд. Ер нь хохирогч хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны улмаас хохирсон иргэдийн мэдээллийг өгөхдөө хүний эрхийн мэдрэмжтэй болгоомжтой өгөхгүй бол албаар нийгмийг уурлуулах гэж байгаа юм шиг дүр зураг харагдаад байна шүү. Зүв зүгээр байж байхад олон нийтийг турхираад л, уурлуулаад л, бухимдуулаад байгаа юм шиг ийм дүр зураг харагдаад байгаа чинь манай энэ чиглэлийн байгууллагуудын мэргэжлийн ур чадвар ямар түвшинд байгааг чинь л харуулж байгаа шүү. Тэр дээрээ бүгдээрээ бас бодоорой.

Хамгийн аюултай хэсэг. Энэ гүйцэтгэх ажлын хууль тогтоомж болон гүйцэтгэх ажил эрхэлж байгаа албан хаагчдын чинь үйл хэрэг дотор наад эрүү шүүлтийн чинь соёл хэтэрхий гүн суучихсан байна. Мөрдөн шалгах чиг үүрэг хэрэгжүүлж байгаа мөрдөгч нар бол арай гайгүй байх шиг байна лээ. Энэ гүйцэтгэх ажил чинь үнэхээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гадуур тусдаа хуулиар яваад байгаа учраас ийм байгаа юм уу. Энийгээ нэг харах ёстой. Эсвэл энэ гүйцэтгэх ажлын хяналт чинь Хүний эрхийн дэд хороо, Хууль зүйн байнгын хороонд харьяалагддаггүй учраас ийм юм яваад байгаа юм уу. Энийгээ бас харах ёстой.

Дараа нь Хууль зүйн яаманд ер нь энэ энэ чиглэлийн хяналтын чиг үүрэг чинь өөрөө сул байгаад байгаа учраас ийм юм яваад байгаа юм уу. Энийгээ харах ёстой. Ер нь бол дотоод хяналт чинь ер нь маш болхи байгаа юм биш үү.

Прокурорыг дараагийн хэлэлцүүлэг дээр дуудаж ирээд, хяналт тавих хууль зүйн хувьд хамгийн чухал чиг үүрэгтэй байгаа энэ байгууллага ер нь яаж ажиллаж байгаа гэдэг дээр сонсох ёстой юм байна. Гүйцэтгэх ажил энэ гүйцэтгэх ажлын хууль тогтоомж гэдэг энэ Монгол Улсад л байгаа хууль шүү. Олон улсын түвшинд ийм хууль байхгүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааныхаа хуулиар нэг хэсэг нь явна. Тагнуулын үйл ажиллагааныхаа тухай хуулиар нэг хэсэг нь явна. Тусдаа гуравдагч энэ салбар дундын юм шиг хууль бол байхгүй байгаа. Энэ салбар дундын юм шиг шинэ дугуй Монголчлоод зохиочихсоны чинь гороор иргэд ер нь эрүү шүүлт дотор илүү их өртөөд байгаа юм биш биз гэдэг ийм болгоомжлол байгаа шүү. Энэ дээр бас бодно биз.

Хамгийн чухал, дахиад нэг хэсэг. Ер нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг үйлдэгдэж байгаа энэ гэмт хэргийнхээ мөрдөн шалгах чиг үүргийг тусад нь байгууллага байгуулж өгөхгүйгээр бол явахгүй нь. Нотлох баримтыг хуурамчаар үйлдэнэ, гэрчийг айлган сүрдүүлнэ, шүүхэд нөлөөлнө, эрүү шүүлт тулгана. Энэ төрлийн гэмт хэрэг чинь ер нь бол эзэнгүй олон байгууллагуудын дунд хуваарилагдсанаасаа болоод нэгдсэн системтэйгээр тоо баримт нь ч гарч ирэхгүй байна. Үнэлгээ өгч чадахгүй байна. Байгууллага болгон өөр өөрийнхөө арга барилаар тэмцэж байгаа юм шиг харагдаад байгаа учраас үр дүнд ч хүрэхгүй байна. Тийм учраас яг энэ чиглэлээрээ Хууль зүйн яам бодлогоо гарга, зоригтой зарла, ажлаа хий. Тэгэхгүй бол одоо хар л даа Хүний эрхийн Үндэсний Комиссоос зөвлөмж явуулаа.

Үр дүн байхгүй. Ажлаа хийхгүй. Хууль зүйн яам дээр л алга болчихоод байна шүү дээ наадах чинь. Тэгэхээр Хууль зүйн яам одоо хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг хамгийн сонирхлын зөрчилгүй энэ чинь өөрөө дахиад энэ төрлийн гэмт хэргийг чинь дандаа мөрдөгчид, эрүүгийн төлөөлөгчид, хуулийн байгууллага хийж байгаа учраас энэ байгууллагатай ямар аргаар энэ гэмт хэрэгтэй нь тэмцэх юм, яаж шалгах юм гэдэг арай нэг онцгой статус, бас процессын арай нэг өөр шинж чанар үгүйлэгдэж байна. Үнэхээр. Тэгээд энэ дээрээ бол бодлогоо гаргасан нь зөв байх.

Саяын асуусан асуултад хариу байна уу. Мэдээлэл байна уу. Байхгүй бол дараагийн хурал дээр энэ чиглэлийн мэдээллийг Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүйн яам 2 оройлж байгаад энэ чиглэлийн судалгаа мэдээллийг оруулж ир. Яг энэ чиглэлтэй холбоотой прокурор дээр бид нар тусдаа дахиад бичиг явуулж байгаад ямар мэдээлэл авахаа ярьж байгаад оруулж ирье.

Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүйн яамтай хамтраад цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд мэдээллээ тийшээгээ нэлээн сайн өгөөрэй. Бодлогын өөрчлөлт байна. Хууль тогтоомжийн өөрчлөлт байна. Танай байгууллагуудын дотоод соёлын өөрчлөлтүүд байна. Бас арга ажиллагаа дээр, процессын арга ажиллагаа дээр бас нэлээн ноцтой бас асуудлууд харагдаж байна.

Үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Эрдэнэболд гишүүн, Цэнгүүн, Мөнхбаясгалан, Шижир, Баярмаа, Нарантуяа-Нара гишүүн тасаллаа. Эрдэнэболд гишүүнээр.

С.Эрдэнэболд: Би нэг кэйс ярихад саяын дурдагдаж байгаа цагдаагийн 4

албан хаагч насанд хүрээгүй хүүхдийн эрх чөлөөнд халдсан тухай асуудал гарч байх үеэр фэйсбүүк дээрээ би нэг пост оруулсан. Энэ асуудал ингээд үнэн зөвөөр шийдэгдэх ёстой гэсэн маш ерөнхий Цагдаагийн ерөнхий газарт хандсан пост. Ингэсний дараагаар над руу нэг дугаараас тэр дугаарыг нь би бичиж авсан. Би цагдаагийн байгууллагаас ярьж байна. Та энэ постоо устгаач ээ гээд тийм дарамтлах маягтайгаар над руу утсаар ярьсан. Тэгэнгүүт нь би шууд тэр хүнд хэлж байсан. Монгол Улсын иргэн Үндсэн хуулиараа үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бас хардах эрхтэй. Бид таны ярьж байгаа зүйлийг одоо бичлэг хийж авна. Та асуултаа давтаад хэлээрэй гэнгүүт утсаа тасалчихсан. Эргээд тэр утас руу хэд хэдэн удаа залгасан. Хариу ирүүлээгүй. Тэгээд энэ нэг тохиолдол. Өөрөөр хэлбэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн тодорхой иргэний эрхээ хэрэгжүүлээд эдлээд явж байгаа хүн дээр ЦЕГ-тай холбоотой пост оронгуут араас нь шууд ийм дарамтлах өнгө аястай зүйл болсон. Энэ бол надад тохиолдсон явдал. Надад бол бүр факттайгаа байж байгаа. Тэгэхээр жишээлбэл би хэлсэн л дээ. Би бол хуульч хүн байна. Эрхээ мэдэж байна. Бас та нараас шаардах эрхтэй. Ямар албан тушаалтан хаанаас яаж ярьж байгаа юм бэ гэдэг тэр утасны дугаар эд нар бүгд байгаа. Он, сар өдөртэйгөө хадгалж байгаа. Энэ бол надад тохиолдож байгаа ч гэсэн маш олон хүн дээр ийм тохиолдох магадлалтай юм байна гэж бодсон. Ер гадуур ярьдаг шүү дээ. Цагдаажсан улс боллоо. Иргэдээ айлган сүрдүүлдэг боллоо. Жагсаал цуглаан хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, иргэний эрхээ эдлэхэд нь Цагдаагийн ерөнхий газар ингэж айлган сүрдүүлдэг боллоо гэсэн ийм хандлага явж байгаа юм.

Тэгэхээр түрүүн би уг нь Хууль зүйн сайдад хэлсэн. Би хуулийн 2 сургууль төгссөн хүний хувьд бол бүр хэллэгийг нь тэгэхээс тэг гэж хэлж байгаа байхгүй юу. Цагдаагийн реформ гэж. Яагаад энийг хэлж байна гэхээрээ Хүний эрхийн

Үндэсний Комисс болон олон улсын байгууллагуудаас гаргасан хүний эрхийн төлөв байдлын судалгаагаар манайх жил болгон хойшлоод байдаг. Тэгээд Хүний эрхийн Комисс нь болохоор ингээд бид нар ингээд тайлан дүгнэлтээ гаргаад байдаг. Гэхдээ бид нарыг ингээд юманд оролцуулахгүй байна гээд байдаг. Одоо ингээд шүүх хурал дээр жишээлбэл хаалттай шүүх хурал дээр оролцуулахгүй ч гэдэг юм уу, дүгнэлт тайлан нь амьдрал дээр нь хэрэгжиж байгаа эсэх нь тодорхойгүй байгаад байна. Тэгэхээр энэ дээр хэн нэгэн хүнийг шүүх гэж байгаадаа биш. Бид нар энэ хүний эрхийг хамгаалах чиглэлээр түрүүн Хууль зүйн сайдын хэлсэнчлэн энэ шинэчлэлийнхээ гол реформын номер нэг ажил бол хүний эрхээс эхэлнэ гэж хэлж байгаа. Энэ дээр бол бид нар ямар нэгэн байдлаар улс төржүүлж, популизм хийж, эсвэл социал медиа дээр явж байгаа нийгмийн сэтгэл зүйн давлагаа дээр дөрөөлж ямар нэгэн мэдэгдэл хийх ёсгүй. Цэвэр хуулийн хийдэл байгууллага хоорондын хоорондын уялдааны асуудлаас үүдээд, хүний эрх зөрчих үндэс болоод байна. Энэ дээр иргэдийн хардах эрх маш хүчтэй байгаад байгаа учраас ил тод, нээлттэй байдал, хүний эрхийг дээдлэх чиглэлтэй бид нар ажилламаар байгаа юм.

Х.Тэмүүжин: 1 минут.

С.Эрдэнэболд: Тийм учраас түрүүн Хууль зүйн сайд хэлж байна. Аль нэгэн албан тушаалтныг сольсноор асуудал шийдэгдэхгүй гэж хэлж байгаа. Нөгөө талдаа энэ тогтолцооны өөрчлөлт хийх ёстой гэж хэлж байгаа. Би юу гэж бодож байгаа вэ гэхээр энэ дээр тогтолцооны өөрчлөлт бол хүнээс эхэлнэ гэж бодож байгаа. Тэр хүмүүсийн хандлага энэ кэйсүүдээс болоод цагдаагийн байгууллагын олон мянган жирийн шударгаар ажиллаж байгаа хүмүүсийн нэр төрийг харлуулах, гүтгэх тийм зүйл бол байхгүй. Гэхдээ тодорхой ингээд хариуцлага тооцохгүй тодорхойгүй байдал чинь өөрөө иргэдэд улам л хардалт бий болоод хууль ёсондоо

итгэх, төрдөө итгэх итгэл нь сулраад байдаг. Үүнийгээ дагаад ардчиллын чанар нь унаад байдаг ийм л нөхцөл байдал байгаад байгаа. Тийм учраас хуралдаан даргалагчид энэ дээр бас тодорхой хэлэхэд өнөөдөр энэ Хууль зүйн байнгын хорооны Хүний эрхийн дэд хорооны энэ хуралдааныг тодорхой төлөвлөгөөтэй болгоод, тодорхой асуудал болгоноор нь одоо ингээд прокурорын байгууллагыг дуудах ёстой гэж байна. Өнөөдөр 5 байгууллага байж байна. Хөндлөнгийн судлаач нарыг оролцуулаад мөн бас олон улсын байгууллагуудын судалгаанууд.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Гишүүд үгээ хэлж байхдаа хугацаагаа хянаарай. 4 минутыг нэг дор өгчих үү. 4 минутыг нэг дор өгчихье. Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Тэгэхээр ер нь бол Улсын Их Хуралд олгогдсон бүрэн эрхийн дагуу хууль тогтоох дээд байгууллага бид нар Их Хурлын гишүүд байгаа юм. Гэхдээ өнөөдрийг хүртэл энэхүү хууль тогтоох эрхийнхээ дагуу гаргасан хууль тогтоомжууд нь уялдаа холбоогүй, ямар нэгэн дүрэм журмууд нь бол хоорондоо нийцдэггүй, гүйцэтгэх засаглал дээр ороод ирэхээр хэрэгжүүлэгч байгууллагууд нь болохоороо яаж аль тохиолдол д алийг нь дагаж мөрдөх вэ гэдэг нь тодорхойгүй байдгийн улмаас өнөөдрийн жишээ нэг кэйс дээр л үүсэж байгаа энэ олон төөрөгдлүүд бол бий болчихож байна. Тэгэхээр үндсэндээ нэг зүйл нь бид нар харах ёстой юм. Үнэхээр бодит хөрсөн дээр ажиллаж байгаа албан хаагч нартайгаа бид нар хэр сайн нүүр тулдаг вэ. Тухайн дүрэм журмыг боловсруулж байхад албан хаагч шиг яг тэрийг хийх цаг хугацаа, ажлын ачаалал юмнууд нь таардаг уу, үгүй юу гэдгийг бид нар харах ёстой. Өнөөдөр албан хаагч нарыг ярьж байгаа ч гэсэн энэ хүмүүс бол робот биш. Энэ бас л Монгол Улсын иргэд байж байгаа.

Тэгэхээр тухайн хүмүүс дээр үүсэж байгаа ачааллаас болоод тэр хүмүүс ч

гэсэн сэтгэл зүйн бас ажлын стрессээс үүдсэн сэтгэл зүйн асуудлууд бол гарч байгаа, би бол гарч байгаа гэж бодож байна. Тэгэхээр холбогдох байгууллагынхан маань сэтгэл зүйч нартай хэр холбогдож ажилладаг вэ. Ялангуяа хууль хүчний байгууллагынхан бол хүнд нөхцөлд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ тохиолдлууд дээр бид нар аль аль талаа бас маш сайн харж үзэх ёстой. Яагаад манай иргэд цагдаа нар гэхээр айдаг болчихсон юм. Ер нь цагдаа гэж хэлэхээр бид нар яагаад айдаг юм.

Нөгөө талдаа цагдаа нар маань уг нь бол бид нарын аюулгүй байдлыг хангах ёстой байж байдаг. Гэхдээ аль аль талд нь л бас адилхан хүмүүс байж байгаа. Тэгэхээр энэ тал дээрээ бид нар илүү ажиллаж анхаарах ёстой юм болов уу гэдгийг хэлмээр байна.

Тэгээд I зүйл дээр бол процессоо бид нар маш сайн тодорхой болгомоор байна. Хууль тогтоогч нар маш гоё дүрэм журмууд гаргадаг. Гэхдээ хэрэгжилтийг нь бид нар хянаж чадахгүй байгаад байна. Тэр дээрээ нийцлүүдээ хангах дээр та бүхэн ажлын хэсгээ ийм хамтарсан байдлуудаар гаргаад явдаг болоосой гэж бол хүсэж байна. Энэ дээр ХЭҮК ч гэсэн яг зөвлөмжүүдээ гаргаад орхих биш хойноос нь тэр яагаад хэрэгжихгүй байна, яагаад орхигдчихов гэдэг дээр нь илүү сайн хойноос нь хөөж ажилладаг байсан бол өнөөдөр бид нар энэ олон хүний амь настай холбоотой хэргүүд дээр гарахгүй байсан байх гэж бодож байна. Тэгэхээр хойноос нь асуудал гарсны дараа ингэж ийм хянан шийдвэрлэх байдлаар явах биш бид нар урьдчилан сэргийлэх тал дээр нь илүү анхаарч ажилламаар байна гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Х.Тэмүүжин: Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Сонсоод байхад ХЭҮК, ЦЕГ, АТГ, Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх газар, 3 дугаар эмнэлгийг сонссонгүй. Мэдээллүүд чинь хоорондоо зөрүүтэй, логик алдаатай байдлууд нэлээн ажиглагдлаа. Тэгээд уг хэлэх учраас ер нь үеийн үед л цагдааг АТГ-ыг нохойд барьдаг мод мэт эрх баригчид өөрсдөдөө ашиглахыг хүсдэг л дээ. Томилогдсон хүндээ үнэнч байж, төрдөө үнэнч биш байсны гор нь ингэж гардаг. Энгийн жирийн ард иргэддээ дээрэлхүү, эр бяр, тэд нарыг үл тоосон тийм хандлага үеийн үед ажиглагддаг.

Тийм учраас Цагдаагийн ерөнхий газрын дарга Сүхболд та тангаргаа санаж, хэрвээ үнэхээр иргэнээ эрүүдэн шүүсэн ийм байдал байх юм бол битгий албан хаагчдаа хамгаалж, өөрийгөө хамгаалж, битгий тийм үйлдэл гаргаарай. Та бол тангараг өргөсөн хүн. Тийм учраас хамтарч ажиллаж энэ байдлыг засаж залруулах нь цаашидаа хэрэгтэй. Энэ үг бас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Авлигатай тэмцэх газарт хамаатай. Бид буруугүй гэдгээ хамгаалж хамтрах биш, хэрвээ хүний эрх зөрчсөн, хүмүүнлэг бус, ардчилсан бус үйлдэл байгаа бол энийг илрүүлээд шалгаад өгдөг газар нь өгөх ёстой. Тэрнээс ингээд нэг тийм бүгдээрээ нийлээд нэг ийм хамгаалсан маягтай, аль болохоор бид нэг тал гэсэн маягтай юм харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхдээ дараа дараагийн хуралдаанаас их олон юм тодорхой болох л байх л даа.

Чимгээ, Содномдаржаа нарын хэргийг мартаагүй бол ямар ч хүнийг эрүүдэн шүүгээгүй гэгчхээд жилийн дараа билүү дээ тэр чинь бичлэг нь гараад ирдэг шүү дээ. Хогийн саваа шалгасан юм байгаа биз дээ. АТГ-ынхан. Иймэрхүү баримтууд сүүлд гараад ирэх вий дээ. Тийм тохиолдол Монгол Улсад болж байсан шүү. 461-д хүн амиа хорлож байсан шүү. Сая тэр болсон Сэлэнгийн хэрэг ч гэсэн тийм байсан. Тэгэхээр энэ бүх үйлдлийг таслан цогцлоохын тулд өргөсөн тангарагтаа үнэнч байж, хуулийн дагуу хамтарч ажиллаарай л гэж хэлмээр байна даа.

Тэгээд дараа дараагийн асуудлууд дээр хурал даргалагч дуудах хүмүүсээ нэмэх байлгүй. Нэлээн тийм зөрчилтэй, логик алдаатай баримтууд нь хоорондоо зөрөөд байгаа асуудлууд гарч ирж байгаа. Тэгэхээр энийг бол нэлээн ул суурьтай шалгамаар байна. Хууль зүйн сайд ч гэсэн анхаарал тавиарай. Содномдаржаа, Чимгээ нарын хэргийг битгий мартаарай. Сүүлд баримт нь гарч ирсэн шүү дээ.

Х.Тэмүүжин: Шижир гишүүн.

Ө.Шижир: Би өмнө ч хэлсэн. Бас дахиад хэлье. Сая өмнө нь хэлсэн асуултад бас тодорхой хариулт авсангүй. Тэгээд хуралдаан даргалагчийн зүгээс асуулга маягаар явуулъя гэж байх шиг байна. Зөв үү тээ.

Х.Тэмүүжин: Ер нь Улсын Их Хуралд дуудагдаад ирсэн албан хаагчид мэдээлэл өгөхдөө цаг хугацаа нь бүрдээгүй, эсвэл бүрэн биш байгаа бол 2 хоногийн дотор асуулт асуусан Улсын Их Хурлын гишүүнд цаасаар мэдээллээ хүргүүлэх үүрэгтэй байдаг. Тэгэхээр тэр чиглэлээрээ мэдээллүүд нэмж ирэх байх. Дээр нь би Дэд хорооны энэ хурлыг 1 удаа ерөөсөө хийхгүй. Дотор нь байгаа сэдэв үүдээр нь хувааж байгаад нэлээн нухацтай ярих сэдвүүд зөндөө байна. Алийн болгон иргэний эрхээ ингээд гудамжинд хөсөр хаячхаад сууж байх вэ. Тийм учраас хэдүүлээ бас нэг энэ намрын чуулган дээр нэлээн сайн ажиллаад, өөрчлөх ёстой хууль байгаа бол хуулийг нь өөрчилье. Өөрчлөгдөх ёстой арга барил, соёл байгаа бол тэрийг нь бас өөрчилье. Өөрчлөгдөх ёстой хүн байгаа бол бас тэрийг нь өөрчилье. Энэ дээр жоохон хариуцлагатай суух ёстой гэж үзэж байна.

Ө.Шижир: Та миний үгийг хэлүүлсэнгүй дарга аа. Тэгээд цааш нь түрүүн 5 асуулт асуусан. Харамсалтай нь би 2 дээр нь л хариулт авсан. Үлдсэн 3 дээр одоо 2 хоногийн дотор хариуцсан байгууллагууд асуулга хэлбэрээр хариулт

өгөх юм байна гэж ойлголоо. Ер нь бол түрүүн бас Эрдэнэболд гишүүний үг дээр гарч байна. Нийгмийн сэтгэл зүй өөрөө ийм эмзэг хардлага өндөртэй байгаа үед ажил хариуцсан байгууллагууд энэ тал дээр маш тодорхой хариултуудыг өгөх ёстой. Тэгж байж та бүгдийн ажил үүргийн, албан үүргийн тухайн байгууллагын нэр хүнд үлдэнэ. Энэ өөрөө ямар хор уршигтай байдаг вэ гэхээр төрийн байгууллагад итгэх итгэл, ялангуяа хамгаалах үүрэгтэй цагдаа, сахин сахиулах үүрэгтэй байгууллагууд, хүний эрхийг хамгаалах үүрэгтэй Үндэсний комисс зэрэг байгууллагууд нь өөрсдөө өнөөдөр энэ хэл амных нь нэг бай болж байгаа бол дараа дараагийн хэрэг, дараа дараагийн асуудал үүсэж байгаа юмнууд энэ кэйс чинь өөрөө дараагийн үүсэх асуудлууд дээр маш их хүндрэл авчирна шүү. Тухайн байгууллагад итгэх итгэл байхгүй болно гэдэг өөрөө нэг талаасаа төрийн тогтворгүй байдлыг бий болгохыг хамгийн хамгийн түрүүнд бий болгодог юм.

ХЭҮК-т хандаж хэлэхэд бид нар бас өнөөдөртөө биш, өнгөрсөн дээр биш, ирээдүй дээр маш тодорхой хөтөлбөр гаргаж ажилламаар байна. Хүний эрх бол ганцхан төрийн байгууллагуудын эрх биш, хүний эрх бол ганцхан төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын эрх биш, хүний эрх өөрөө ганцхан одоо юу гэдэг юм ШШГБ-д хоригдож байгаа тэд нарын эрхийн асуудал яригдах асуудал биш. Энэ өөрөө нийгмийн өнөөдөр сошиал медиа хөгжчихсөн, орчин үеийн харилцаа өөрөө маш эмзэг болчихсон энэ үе дээр хүний эрх гэж бараг хүүхдийн эрх гээд бүх юмны эрхээс эхэлж байгаа байхгүй юу. Тэр юмнууд дээр ХЭҮК өөрөө ямар байдалтай, ямар байр суурьтай, ямар урт хугацааны хөтөлбөр батлуулж ажиллах юм бэ гэдэг дээр ажиллаач.

Алсын хараа 2050 гэдэг хөтөлбөр шиг ХЭҮК дээр ийм үндэсний хэмжээний хөтөлбөр баймаар байна. Яагаад гэвэл та хэд чинь үндэсний хэмжээний

байгууллага шүү дээ. Тэгээд маш олон асуудлууд дээр дараа дараагийн Дэд хорооны хурлууд дээр хүртэл одоо сэтгүүлч Өнөрцэцэгийн асуудлыг оруулж байж яримаар байна. Тэр Сэлэнгэ аймагт цагдаагийн байгууллагын албан хаагч нар зүй бусаар харьцсан гэдэг тэр жоохон охины асуудлыг бас яримаар байна. Энэ нийгмийн асуудлыг нэг тийш нь мухарлахгүй бол нийгмийн сэтгэл зүй өөрөө тогтворгүй болоод та хэдийн байгууллагын нэр хүндэд халтай шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Х.Тэмүүжин: Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: Ерөнхийдөө бас саналууд давхцаж байна. Тэгээд яах вэ, бүгдээрээ бол анзаарсан байх. Бид нар бол ийм эмзэг хүний эрхтэй холбоотой, амь настай холбоотой асуудал дээр цаг, минут алдалгүй ажиллаж байх ёстой. Төрийн ажил бол маш хурдан, яаралтай явагдаж байж дараа дараагийн гарах асуудлуудаа сэргийлж байх ёстой гэдэг үүднээсээ 1 дүгээрт, 2 дугаарт бас хууль тогтоогч Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу бол бүрэн эрхтэй байгаа. Нийтийн сонсгол зохион байгуулах гээд. Нийтийн сонсголын тухай хуульд болохоор бүр тусгайлан 6.2.9 дээр “хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой хяналтын сонсгол” гээд бүр ингээд 9 төрлийн 1 болгоод оруулчихсан байгаа. Бусдыг нь бол ерөнхий хяналтын сонсгол гээд ингээд танилцах, томилгооны гээд. Гэтэл энэ асуудлыг бүр тусгайд нь авч ингэж нэг төрөл болгож оруулж байна гэдэг чинь уг нь манай Монгол Улс энэ хүний эрх, эрх чөлөөний асуудал дээр онцгой анхаарал хандуулаад байгаа юм. Харамсалтай нь яг тэр хэрэгжилт болоод ирэхээрээ ингээд бид нар алдаад байна.

Дээрээс нь энэ хууль тогтоомжуудын зөрчил, үл нийцэл бол асар их байгаа юм байна. Та бүхэн өөрсдөө бүр хэлээд байна шүү дээ. Энд ингэж өөрчлөлт оруулмаар байн, ингэж өөрчлөлт оруулмаар байна. Тэгэхгүй энэ

журам ингээд байдаг юм, энэ хууль ингээд байдаг юм гээд. Энэ бол маш эмзэг сонсогдож байна. Өдий хүртэл яагаад энэ олон зөрчилтэй асуудлууд засагдаагүй байгаа юм бэ. Тэгээд тэрнээсээ болоод ингээд явж байдаг. Журмаар гавлах ёстой гээд л байж байна гэж байна. Гэтэл энэ чинь Мөнхбаясгалан гишүүн удаа дараа асуулаа шүү дээ. Ухаангүй байгаа хүнийг гавлах тухай асуудал байж болохгүй шүү дээ. Атал тэр хүн тэр цагдаагийн бие бүрэлдэхүүн ингээд аль журмаа бариад ингээд гавлаад байгаа юм гээд. Та нар өөрсдөө бүр энэ дундаа маш том асуудалд орчихсон л харагдлаа. Тэгэхээр энэ дээр тэр Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу гишүүдийн бүрэн эрхийн дагуу бол маш олон ноцтой асуудлууд яригдаж байгаа учраас зөвхөн цагдаагийн алба биш энд хүний эрх гэдэг асуудлынхаа хүрээнд гэх юм бол нөгөө хоригдолтой холбоотой асуудлууд байна. Ноднин бид нар бас мэдэж байгаа шүү дээ. Нөгөө лайвчин Мөнх-Эрдэнийн хэрэг дээр бас л тусгай тасгийнхан очиж янз янзын асуудал үүсгэлээ гээд л бид нар мэдэж байгаа. Дээрээс нь нөгөө цэргийн асуудлууд байна. Дахиад л хүний эрхийн асуудал. Бас нэг цэрэг нас барсан. Цэргийн дэглэлт гээд л байж байгаа. Энэ бүгдийн чинь ард дандаа л хүний эрхийн асуудал явагдаж байгаа. Тийм учраас энэ нийтийн сонсголыг зохион байгуулах шаардлагатай гэж бол би үзэж байгаа. Манай АН-ын гишүүд ч гэсэн бас энэ дээр санал нийлж байгаа. Энийг бол бид нар нийтэд ил тод сонсгож байж сая нэгдсэн ойлголттой болно. Одоо ингээд ярихад бол бас багагүй л зүйлүүд тодорхой болж байна л даа. Яг энэ чинь зөвхөн энэ төрийн албан хаагчдын зүгээс одоо ний нуугүй хэлэхэд бас нийлж байгаад биеэ өмөөрнө гэдэг шиг юм бас явагдаад байна шүү дээ. Тэгээд 1 матрын нулимс унагаж байгаа ч юм шиг нэг ийм юмнууд бол харагдаж байна. Тэгэхээр зөвхөн төрийн албан хаагчдын үгийг биш, үүнтэй холбоотой хамаарал бүхий этгээдүүд болох тэр хохирогч,

гэрч нарыг оролцуулах хэрэгтэй.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Нарантуяа-Нара гишүүн.

М.Нарантуяа-Нара: Тэгэхээр хамгийн харамсалтай зүйл бол яг энэ идэр залуу насан дээрээ эд амьдралд хөл тавьж, амьдралын баяр баясгалан, тэгээд тэр бүх зүйлийг өөрийнхөөрөө мэдэрдэг насан дээрээ сүүлийн жилүүдэд яг энэ 18-22 орчим насны залуучууд эрүүл мэндийн шалтгаанаар амь хохироод байгаа нь иргэдийн дунд төдийгүй бид бүгдийн хувьд бүгдэд нь сэтгэл эмзэглүүлсэн асуудал байна. Энэ асар том хүний эрхийн зөрчлийн асуудлыг эрүүл мэндийн шалтгаанаар хаацалдаг ийм жишиг тогтчихов уу бараг гэж би хувьдаа айж байна. Өнгөрсөн хугацаанд цэрэг, цагдаа хүчний байгууллагуудтай холбоотой яг энэ идэр залуу насны залуучуудын амь хохирлын асуудал хэчнээн байна. Тэгээд дандаа эрүүл мэндийн шалтгаанаар нас барлаа гэдэг ийм дүгнэлтүүдэд хүрдэг. Тийм учраас сая нас барсан залуугийн талаар иргэд бас маш их эргэлзээтэй, хардах эрхээ эдэлж, маш их хардлага сэрдлэгтэй байгаа. Тэгэхээр энийг бид нар бас үнэхээр эрүүл мэндийн тэр суурь үзүүлэлтүүдийг маш сайн бүртгэж авдаг, ялангуяа цэргийн ангид бол дандаа эрүүл саруул хүүхдүүд явдаг юм шүү дээ. Тэгээд л дараа нь эрүүл мэндийн шалтгаанаар нас барсан гэсэн ийм дүгнэлттэй байдаг.

Дээрээс нь цагдаагийн газар гэрч хохирогчийг хамгаалах. Түрүүн Эрдэнэболд гишүүн хэлж байна. Нөгөө 13 настай хүүхдийн асуудлаар дуу хоолойгоо илэрхийлсэн. Би бас хамгийн түрүүнд хэлж байсан. Тэгээд тэр асуудлаар над руу бас Гэрч, хохирогчийг хамгаалах албанаас амралтын өдөр, оройн цагаар холбогдож энэ юмыг ингээд хүн үүднээс энэ постоо устгачхаач ээ, лайваа устгачхаач. Тэгээд дээрээс нь ер нь бол энийг хүн үүднээс гуйж байна.

Гэхдээ юм нэгээр дуусах биш дээ гэдэг нь ер нь бол нэг ийм тодорхой хэмжээнд заналхийллийн, дахиад юм нэгээр дуусах биш дээ гэсэн тийм юмнууд байгаа нь энэ өөрөө зүгээр иргэд дуу хоолой хүргэх төдийд цагдаагийн байгууллагаас ингэж иргэдийн хувийн мэдээллийг шууд холбогдоод дарамтлах, хүсэх маягаар ингэж холбогдож байна гэдэг бол энэ өөрөө нөгөө цагдаажсан нийгэм гэдэг чинь бас тодорхой хэмжээгээр батлагдаад байна гэж би хувьдаа харж байна. Тэгээд би уг нь түрүүн асуусан л даа. Тэрэнд хариулсангүй. Одоо ялангуяа энэ 13 настай жоохон охин хүчирхийллийн удаан хугацааны туршид бүлэглэсэн албан хаагчдын хүчирхийлэлд өртөж байсан энэ охинд одоо хамгийн гол нь яг бие, сэтгэл санааны, эрүүл мэндийн, сэтгэцийн эрүүл мэндэд нь ямар терапи үйлчилгээ төрөөс хийж байгаа вэ гэдгийг гол нь асуусан. Тэр дээр хариулсангүй. Бид нар бас яг ийм асуудлыг илүү Хууль зүйн яам дээр ч гэсэн тодорхой хариуцаж ажилладаг ийм албыг маш сайн сэтгэл зүйч, мэргэжилтнүүдийг бэлтгэх энэ ажлыг.../минут дуусав/

Х.Тэмүүжин: Хүний эрхийн дэд хорооны хурал ер нь дуусах тийшээ хандаж байна. Энэ удаа бол бид нар бол ямар нэгэн тогтоол, шийдвэр гаргахгүй. Мэдээллээ бүрэн авч байж шийдвэрүүд гаргана. Гэхдээ протоколоор бол тодорхой чиглэлүүдийг бол өгч байна. Түрүүн дурдсан 8 асуудал байгаа. 8 асуудлаараа ХЭҮК, Хууль зүйн яам 2 тэргүүлээд, зохион байгуулалтаа хийгээд, нэр дурдагдаж байгаа байгууллагуудаасаа мэдээллээ гүйцэд аваад, дурдагдсан 8 асуудлаар судалгаа, мэдээлэл, санал бэлдээд ирэхийг хүсэж байна.

Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо дээр ярьж байгаад сэдвүүдээ бид нар хуваана. Нэг хуралдаанаар шийдэх боломж бол хомс байна.

Дахиад дурдъя. Хамгийн чухал нь албаны үйл ажиллагаанд нь өртөж байгаа иргэнтэй хувийн харьцаа тогтоодог, орой үдэш утасддаг, ямар нэгэн байдлаар эд хөрөнгийн асуудал үүсгэдэг гэх мэтчилэн их маш олон гомдол бол иргэдийн дунд гараад байна. Ийм нотлогдсон баримттай кэйс хэд байгаа юм бэ. Гомдол, санал хэд байгаа юм бэ. Тоо статистик нь болон тодорхой кэйсүүдийг мэдээлэл болгож авчирч өгөх шаардлага байна.

Дахиад дурдъя. Гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа чинь ямар түвшинд байгаа юм бэ. Уялдаа холбоо алга байна. Байгууллага болгон дээрээ бүтэц байхгүй байна. Цагдаа дээр байгаа зарим чиг үүрэг чинь сонирхлын зөрчилтэй болоод байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд дурдагдсан эрүү шүүлттэй холбоотой асуудал кэйсээрээ түрүүн дурдсан. Нэг бус удаа, бүр нэг биш шүү. Энэ чинь бараг гарын 10 хуруунаас илүү гараад явчихлаа. Дүгнэлтүүд, илтгэлүүд. Түүнд дурдагдсан тодорхой нэр устай кэйсүүд хариуцлага хүлээсэн юм уу. Хариуцлага тооцогдохгүй байгаа учраас наад үйл явдал чинь дотоод соёл болоод хувирчихлаа шүү дээ. Хариуцлага тооцогдохгүй байгаа учраас ингэж л байдаг юм гэдэг өнгө аястай иргэд рүү хүчирхийлэл үйлдэгдээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ хариуцлага хэр зэрэг тооцогдсон юм гэдэг статистик, тоо баримт тэр мэдээлэл нь хэрэгтэй байна. Тооцоогүй бол яагаад. Хуулийнхаа хувьд байгаа юм уу, журмынхаа хувьд байгаа юм уу, хүмүүс дээрээ байгаа юм уу, удирдлага дээрээ байгаа юм уу. Энэ тухай нарийн мэдээллүүд хэрэгтэй байна.

Дахиад тэр гүйцэтгэх ажилтай холбоотой. Гүйцэтгэх ажил нэрийн доор эрүү шүүлт явагддаг. Тэр Зоригийн хэргийн аллагатай холбоотой хэрэг дээр явагдсан чинь гүйцэтгэх ажлын хүрээнд л явагдсан шүү дээ. Гүйцэтгэх ажилтай

холбоотой, гүйцэтгэх ажилтнуудтай холбоотой өөрсдийгөө хуучин хуулиар эрүү шүүлтээс гадуур байсан. Хуучин бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч л эрүү шүүлттэй холбоотой гэмт хэргийн субъект байсан. Одоо бол өргөссөн. Гэтэл тэр хуучин хандлагаар одоо хүртэл тэр соёлоо аваад яваад байгаа бол үүнийх нь эрх зүйн орчныг яаж өөрчлөх юм, зохион байгуулалтыг нь яаж өөрчлөх юм. Тэр асуудлаар мэдээллээ нэлээн сайн боловсруулаарай.

Хууль зүйн яам дээр Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй холбоотой шийдлээ гарга. Гэрч, хохирогчийг хамгаалахтай холбоотой тогтолцооны шийдлээ гарга.

Гишүүд дахин дахин хэллээ. Хууль сахиулах байгууллагуудын чинь реформ дутагдаад байна. Цагдаагийн реформ ганцаараа биш шүү. Ер нь бол Law enforcement хийж байгаад хууль сахиулах үйл ажиллагаа явуулж байгаад гэмт хэрэгтэй тэмцэж байгаа байгууллагуудын чинь дотоод соёл, зохион байгуулалт, арга барил, процессын хууль гэх мэтчилэн удирдлагын тогтолцоо гэх мэтчилэн олон зүйл дээр шинэ өөрчлөлт үнэхээр үгүйлэгдэж байгаа юм байна. Тэгэхээр энэ чиглэлийнхээ реформыг эртхэн зарла. Засгийн газрын энэ хөтөлбөр дотроо тодорхой бич. Улсын Их Хурал Засгийн газрын хөтөлбөртэй холбоотойгоор хуралдах байлгүй дээ. Тэнд бас яг энэ асуудал чинь нэхэгдэх нь байна шүү гишүүдийн зүгээс. Хууль зүйн яам богино хугацаанд хурдан ажиллаад реформоо тодорхой зарлаарай.

Протокол байгууллагууд дээр араас чинь очно. Чиглэлүүд дээр маш тодорхой очно. Тэр чиглэлүүд дээр мэдээллээ нэгтгээд, дараагийн хурал 14 хоног амжих уу. 21 хоног байх уу. 21 хоногийн дот дараа хэдүүлээ Улсын Их Хурал дээр дахин уулзалдах нь байна шүү.

*Хүний эрхийн дэд хорооны хуралд
ирсэн гишүүд болон хүрэлцэн ирж
мэдээлэл өгсөн байгууллагууддаа
баярлалаа. Хурал хаасныг мэдэгдье.*

14.55 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ